



Монголын Эмэгтэйчүүдийн Сан



# ЖЕНДЭР БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

СУРГАГЧ БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР 2023



Монголын Эмэгтэйчүүдийн Сан

© 2023

**Монголын эмэгтэйчүүдийн сан**  
(МОНЭС)

**Гарын авлагыг боловсруулсан:**

Ж. Чанцалдулам      Бидний оролцоо нөлөөлөл ТББ-ын тэргүүн, зөвлөх багш (Модуль 1)  
З. Ундрах              ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн маркетингийн тэнхимийн эрхлэгч, ахлах доктрант (Модуль 2)

**Зургийг:**

Ц. Ариунсанаа              Зураач

**Зөвлөсөн:**

Б. Агни                      Монголын эмэгтэйчүүдийн сан (МОНЭС)-ийн гүйцэтгэх захирал

Энэхүү гарын авлагыг эмэгтэйчүүдийн бүлэг, ТББ болон Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудад зориулав.

ГАРЧИГ

<b>МОДУЛЬ 1.</b>	Жендэрийн үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд тусгах	1
Хичээл 1:	Жендэрийн оролцооны сургалтыг зохион байгуулах зөвлөмж	3
Хичээл 2:	Жендэрийн ойлголт	13
Хичээл 3:	Жендэрийн тэгш байдал	22
Хичээл 4:	Жендэрийн дүн шинжилгээ	33
Хичээл 5:	Жендэрийн үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт ба хэрэгжилтэд тусгах	52
<b>МОДУЛЬ 2.</b>	“Уур амьсгалын өөрчлөлтөд жендэрийн мэдрэмжтэй дасан зохицох нь”	68
Хичээл 6:	Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр нөлөө	69
Хичээл 7:	Уур амьсгалын өөрчлөлт ба эрүүл мэнд	75
Хичээл 8:	Уур амьсгалын өөрчлөлтийн нийгмийн үр дагавар ба жендэрийн ялгаатай байдал	84
Хичээл 9:	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн байгаль орчин, эдийн засаг, нийгмийн төлөвлөлт, жендэрийн оролцоо	90
Хичээл 10:	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, өөрчлөлтөд дасан зохицох жендэрийн мэдрэмжтэй бодлого, арга хэмжээ	98

## ЖЕНДЭР БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

---

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

- ХХААХҮ - Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр
- ЖҮХ - Жендэрийн үндэсний хороо
- ОНЖДХ - Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр
- ХАБЭА - Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
- ТНЗ - Тогтвортой хөгжил Нийгмийн хариуцлагын Зөвлөл
- НҮБХХ - Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
- БОННУ - Байгаль орчны нөлөөллийн нарийвчлалын үнэлгээ
- БХБОС - Барилга хот байгуулалт, орон сууц
- ОНЖДХ - Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр
- ХШҮ - Хяналт шалгалт үнэлгээ
- УАӨ - Уур амьсгалын өөрчлөлт
- УАНС - Уур амьсгалын ногоон сан

## МОДУЛЬ 1. ЖЕНДЭРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ТУСГАХ

### Зорилго:

Энэ модулийг үзсэний дараа сургагч багш нар жендэрийн үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хэрхэн тусгадаг талаар ойлголт, мэдлэгтэй болно.

### Зорилт:

- Сургагч багш нарын жендэрийн сургалтыг оролцоонд тулгуурлаж зохион байгуулах чадварыг дээшлүүлэх
- Жендэрийн ойлголтыг бататгах, бусад сэдвүүдтэй хэрхэн уялдах талаар тайлбарлах
- Жендэрийн тэгш байдлын ач холбогдлыг багаар ажиллах, дүн шинжилгээ хийх, кейс дээр ажиллах аргыг ашиглан ойлгуулах
- Байгаль орчин ба хөдөө аж ахуйн салбарт хийгдэж буй жендэрийн дүн шинжилгээний талаар мэдээлэл өгөх
- Жендэрийн үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хэрхэн тусган ажиллаж байгааг бодлогын бичиг баримт дээр тайлбарлах
- Жендэрийн нөлөөллийн ач холбогдлыг танилцуулах, кейс дээр ажиллах замаар нөлөөллийн арга замыг ашиглаж сурах

### Хүлээгдэж буй үр дүн:

- Сургагч багш нар жендэрийн үзэл баримтлалыг байгаль орчин, хөдөө аж ахуйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хэрхэн тусгаж байгаа талаар мэдээлэлтэй болж цаашид иргэдэд энэ чиглэлээр сургалт явуулах мэдлэг, чадвартай болно.

### Хичээлийн нэр, хугацаа:

Уг модуль нь нийт таван хичээлээс бүрдэх бөгөөд нийт 7.5 цаг үргэлжилнэ.

Хичээл 1: Жендэрийн оролцооны сургалтыг зохион байгуулах зөвлөмж

Хичээл 2: Жендэрийн ойлголт

Хичээл 3: Жендэрийн тэгш байдал

Хичээл 4: Жендэрийн дүн шинжилгээ

Хичээл 5: Жендэрийн үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт ба хэрэгжилтэд тусгах



**Хичээл 1: Жендэрийн оролцооны сургалтыг зохион байгуулах зөвлөмж**

Хичээлийн төлөвлөгөө

Зорилт: Сургагч багшийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх

Хэрэглэгдэхүүн: **“Оролцооны сургалтын арга зүй” гарын авлага**

Хугацаа: 90 минут

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Хугацаа /минут/	Хичээлийг чиглүүлэх алхам	Аргачлал
30 мин	Танилцах хэсэг: Оролцогч бүр өнгийн цаас, маркер ашиглан өөрийн нэрний агуулгыг зурж, өөрийн гурван давуу талаа бичих	“Өвөрмөц нэр” мөс хагалах дасгал
20 мин	Сэдэлжүүлэх дасгал: <ul style="list-style-type: none"> <li>▪ Сургагч багш юу хийдэг вэ? асуултын хүрээнд ярилцлага өрнүүлэх</li> <li>▪ Оролцогчдын саналыг нэгтгэж ангилах</li> <li>▪ Ярилцлагын дүгнэлтийг танилцуулах</li> </ul>	Оюуны дайралт Картаар сортлох
30 мин	Мэдлэг олгох: <ul style="list-style-type: none"> <li>▪ Үр дүнтэй сургалтыг хэрхэн зохион байгуулах вэ? сэдвийн дагуу ППТ ашиглан мэдээлэл, зөвлөгөө өгөх</li> <li>- Оролцогчдын асуултад хариулах</li> </ul>	Мэдээлэл Бие даан ажиллах
10 мин	Мэдлэг бататгах дасгал: <ul style="list-style-type: none"> <li>- Сургагч багшийн үүрэг гүйцэтгэхэд танд ямар чадвар байна вэ? асуултад оролцогч бүрийг хариулж бичихийг хүсэх</li> <li>- Оролцогчдыг хариултаа том цаасан дээр бичихийг урих</li> <li>- Оролцогчдод урам өгч хичээлийг төгсгөх</li> </ul>	Оюуны дайралт Ханын самбар арга

Мэдлэг олгох хэсэгтэй холбоотой унших нэмэлт мэдээлэл:

**Үр дүнтэй сургалтыг хэрхэн зохион байгуулах вэ?**

Мэргэжлийнхээ хүрээнд сургалт зохион байгуулдаг сургагч багш нар төдийгүй сургалт бие даан зохион байгуулах хүсэл эрмэлзлэлтэй хүмүүс

хүртэл «Сургалтыг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах вэ?» гэдэг асуултыг өөрөөсөө болон туршлагатай сургагч багш нараас байнга асуудаг.

Хэрвээ та зохион байгуулах гэж буй сургалтынхаа зорилго, зорилтыг тодорхойлохоос эхлээд сургалтын үнэлгээ хийж дуусах хүртэлх бүхий л үшатыг зөв төлөвлөн, удирдан зохион байгуулж чадвал таны сургалт хүмүүсийн сэтгэлд хүрсэн үр дүнтэй сургалт байх болно.

Үр дүнтэй сургалт зохион байгуулахын тулд сургагч багш нь **сургалтын өмнө, сургалтын үеэр болон сургалтын дараа** юу хийхээ мэддэг байх ёстой. Сургагч багш та дараах мэдээллийг уншиж, мэдлэгээ сургалт зохион байгуулах бүртээ ашиглан ажил хэрэг болгоорой.

### 1. Сургалтын өмнө юу хийх вэ?

Аливаа сургалтыг зохион байгуулахын өмнө сургалтын бэлтгэл ажлыг сайн хийх шаардлагатай байдаг. Бэлтгэл ажлын хүрээнд сургагч багш, чиглүүлэгч нь сургалтыг ямар зорилготой хэнд зориулж хийх, сургалтанд оролцогчдоос урьдчилан мэдлэг, чадварын тест бөглүүлэх, сургалтыг зохион байгуулах багийг сонгох, сургалтын хөтөлбөрөө боловсруулах, сургалтанд ямар гарын авлага, материал, тоног төхөөрөмж хэрэгтэйг тодорхойлох, сургалтын үнэлгээний хуудас боловсруулах, сургалтын өрөө байраа сонгох ажлуудыг хийдэг.

#### □ Сургалтын зорилгоо тодорхойлох

Сургалтын зорилго нь нийгмийн болон суралцагчдын хэрэгцээ, сонирхлоор тодорхойлогдоно. Жишээлбэл, та сургалтад оролцогчдынхоо мэдлэгийг дээшлүүлэх гэж байна уу, хандлагыг өөрчлөхөд туслах гэж байна уу эсвэл дадал чадвар олгох гэж байна уу гэдгээс хамаарч сургалтын зорилго өөр өөр байж болно.

#### Мэдээлэл

Сурах, хөгжих үйл явцын онол буюу КАП-ийн онолоор аливаа зохион байгуулагдаж буй сургалт нь:

- Мэдээлэл өгөх буюу мэдлэгийг дээшлүүлэх (knowledge)
- Зан үйлийн буюу тодорхой асуудалд хандах хандлагыг өөрчлөхөд туслах (attitude)
- Дадал чадвар олгох (practice) зорилгыг агуулж байдаг.

#### □ Сургалтын хөтөлбөр боловсруулах

Сургалтын зорилгоо тодорхойлсны дараа зорилгыг хангахын тулд “сургалтын хөтөлбөр” сургалтын гол хэрэгсэл нь болдог. Сургалтын хөтөлбөрөө боловсруулахдаа дараах мэдээллээс эхлэх хэрэгтэй. Үүнд:



1. Сургалтын нэр, зорилго, хүлээгдэж буй үр дүн
2. Сургалт хийх хугацаа, он, сар, өдөр, байршил, цаг
3. Сургалтаар заах хичээлийн сэдэв, зарцуулах цаг, арга зүй болон сургалтын хэрэглэгдэхүүн
4. Сургалтад оролцогчид, сургагч багш нарын болон зохион байгуулж буй газрын танилцуулга

## 2. Сургалт үед юу хийх вэ, сургагч багш ямар үүрэгтэй вэ?

- **Сургалтын зорилго, хүлээгдэж буй үр дүнг танилцуулах.** Сургалтанд оролцогчид тухайн сургалтаас ямар мэдээлэл, мэдлэгийг олж, ямар чадварыг эзэмших талаар нэгдсэн ойлголттой болохын тулд сургалтын эхэнд заавал зорилго, хүсэн хүлээгдэж буй үр дүнг тайлбарлаж өгөх хэрэгтэй.
- **Сургалтанд оролцогчдын мэдлэгийн түвшинг таньж мэдэх.** Сургалтын зорилгыг танилцуулсны дараа оролцогчдоор тухайн сэдвийн талаарх мэдлэгийн түвшин тогтоох тестийг бөглүүлнэ. Энэ нь сургагч багшид оролцогчдын мэдлэгийн хүрээг тодорхойлох, сургалтын үр дүнг тооцох боломжийг олгодог.
- **Сургалтанд оролцогчидтой танилцах.** Танилцах хэсгийг амжилттай явуулснаар оролцогчдын сургалтын талаарх анхны сэтгэгдлийг эерэгээр бүрдүүлж чадах бөгөөд энэ нь сургалтын уур амьсгалд сайнаар нөлөөлдөг. Танилцах цагийг бүх оролцогчдын оролцоог хангасан сонирхолтой аргаар явуулах хэрэгтэй.

### Танилцах дасгалын жишээ:

- Оролцогчид өөрийн нэрний агуулгыг зургаар илэрхийлэх, оролцогчдын сонирхол, давуу талыг хэлүүлэх, хэлэх дуртай эсвэл амьдралдаа мөрдлөг болгодог үгийг нь бичүүлэх
- “Нөгөө хэсгийг олох” танилцах дасгал: Эвлүүлдэг зураг, эсвэл чихэр хийсэн уут/хайрцгаа барьж өрөөн дотуур явах ба хүн бүрийг нэг нэгийг авахыг санал болгоно. Бүгдэд тарааж дуусаад оролцогчдыг суудлаасаа босож, өөрийн хосоо олохыг хүснэ. Хосоо олмогц 2-3 минутанд багтааж бие биеэсээ нэр, мэргэжил, хамгийн сайн хийж чаддаг зүйлс, мөрөөдлийн талаар асууж, танилцах
- Бүжиглэцгээе: Чиглүүлэгч хөгжмийн ая тавиад оролцогчдыг хос хосоо олоод 2 минутын хугацаанд бүжиглэхийг урина. Оролцогчид бүжиглэх явцдаа нэр, ямар байгууллага төлөөлж байгаа, сургалтаас юу хүсэн хүлээж байгаагаа ярилцана. Бүжиглэх хугацаа дуусахад оролцогчид өөр өөрийн хосоо буюу бие биенээ танилцуулна.

- **Оролцогчдын асуултанд хариулах.** Аль болох оролцогчдын асуултанд хариулж, мэдээлэл өгөхийн тулд урьдчилан сургалтын сэдэвтэй холбоотой асуулт, хариултыг өөртөө бэлтгэх хэрэгтэй. Асуултанд үндэслэлтэй хариулахын зэрэгцээ өөрийн үзэл бодлоо бусдад тулгаж болохгүй.
- **Заасан сэдэв бүрийн дараа цаашид гүнзгийрүүлэн үзэх, ашиглах материалын талаарх мэдээллийг өгөх.** Сургалтын гарын авлага эсвэл тараах материалыг текст, зураг, хүснэгт, бүдүүвч зэрэг олон хэлбэрийг ашиглан бэлтгэж оролцогчдод тараах хэрэгтэй. Мөн тухайн сэдэв бүртэй холбоотой нэмэлт унших ном, материалын жагсаалтыг хавсралт байдлаар оролцогчдод хүргээрэй. Олон материал өгөх нь гол биш, оновчтой, тодорхой, цаашид ашиглахуйц материал оролцогчдод үр өгөөжтэй байдгийг санах хэрэгтэй. Жишээ нь: энэ гарын авлагын 33-р хуудаснаас цаашид жендэрийн дүн шинжилгээ хийхтэй холбогдолтой унших материалын жагсаалттай танилцаж болно г.м
- **Сургалтын үр бүтээлтэй орчинг бүрдүүлэх.** Оролцогчидтой мэндлэхээс эхлээд сургалтын явцад сайн харилцаа тогтоох нь сургагч багшийн чадвартай холбоотой байдаг. Хамгийн гол нь сургагч багшийн инээмсэглэл, оролцогчдоо өөртөө татаж, дулаан уур амьсгалыг бий болгодог гэдгийг санах хэрэгтэй. Мөн сургалтын өрөө, ширээ, сандлаас эхлээд сургалтын хэрэглэгдэхүүн нь оролцогчдын тав тухтай орчинг хангасан байх нь сургалтын үр дүнд нөлөөлдөг.
- **Сургалтын үндсэн мэдээллийг товч, тодорхой өгөх.** Сургагч багш өөрийн зааж буй сэдвийнхээ илтгэл эсвэл лекцээ товч тодорхой гол санаагаа оруулсан байдлаар бэлтгэх хэрэгтэй. Мөн дан нуршсан текст хэлбэрээр биш, зураг, хүснэгт, график хосолсон хэлбэрээр бэлтгэх нь оролцогчдын сурах, мэдээлэл авах сонирхлыг илүү төрүүлдэг.
- **Сургалтын цаг хугацааг зөв төлөвлөж баримтлах.** Сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийн цагийг аль болох баримтлах хэрэгтэй. Гэхдээ оролцогчид идэвхигүй, ядарсан үед алжаал тайлах дасгал болон багийн ажилд нэмэлт цаг өгөх зэргээр сургалт явуулах цаг хугацаанд өөрчлөлт хийж болно. Энэ нь үндсэн мэдээлэл, бүлгийн ажил, дасгалын уялдаа холбоог сайн тохируулахад ашиг тустай бөгөөд мөн оролцогчдын идэвх оролцоог дээшлүүлэхэд нөлөө үзүүлдэг.
- **Дуу хоолойгоо тохируулах.** Сургагч багш нь хэт нам дуугаар эсвэл чанга орилсон маягаар ярихгүй байх хэрэгтэй. Гол нь агуулгатайгаа холбогдуулж дуу хоолойны өнгөө сул, тод эсхүл өндөрсгөх зэргээр тохируулах нь зүйтэй.
- **Оролцогчидтой сайн харилцаа холбоо тогтоох.** Сургагч багшийн хувьд бүх оролцогчидтой эелдэг харьцах хэрэгтэй. Мэдээж сургалтанд янз бүрийн зан, үзэл бодолтой хүмүүс оролцдог хэдий ч тухайн оролцогчдод тохируулж харилцааны аргуудыг ашиглах хэрэгтэй. Үүний тулд сургагч багш нь хүмүүстэй хэрхэн харилцах талаар мэдлэгтэй байж, харилцах чадвараа дээшлүүлэх хэрэгтэй.

### Мэдээлэл

#### Сургалтанд оролцогчдын тухай

- Сургагч багш нарт зориулсан гарын авлагуудад сургалтанд оролцогчдыг дуугүй, ганцаардмал, ухаалаг, шооч, бусдад найддаг, эелдэг, гутранги үзэлтэй, мэргэн буудагч оролцогч гэх мэтээр ангилсан байдаг. Жишээлбэл, Эелдэг оролцогчид багшийн үгийг шууд хүлээн авч маш идэвхтэйгээр биелүүлдэг. Багшийн хэлсэн бүх юм туйлын үнэн гэж боддог. Ийм оролцогчид багшдаа харанхуй итгэдэг, иймээс өөрсдөө бодох чадвар бага байдаг. Гэхдээ энэ оролцогч сурах чадвар муутай биш гэдгийг мартаж болохгүй. Иймэрхүү оролцогч нараас асуулт асууж өөрийн санал бодлоо хуваалцдаг болгоход нь туслах хэрэгтэй. Тэднээс санал асуусан асуултыг голдуу асууж болно. Мөн тэдний өгсөн мэдээллийг ашиглан хариу өгч болох асуултууд маш үр дүнтэй байдаг. Тэд ямар ч хариу өгсөн дэмжих нь чухал, тэгснээр тэд урам зоригтой болж, өөрийгөө үнэлж чаддаг болно.
  - Мөн тэдгээр оролцогчидтой хэрхэн харьцах аргыг тусгасан байдаг.
- **Биеийн хэлийг оновчтой ашиглах.** Биеийн хэл нь таны ярьж буй хичээлийн агуулгыг дэмжиж өгдгөөрөө сургалтын нэг чухал хэсэг болдог. Тийм ч учраас таны юу хэлж байгаа тань чухал ч, түүнийгээ хэрхэн хэлж байгаа нь түүнээс ч илүү чухал. Биеийн хэл буюу үггүй харилцаа нь нүдний харц, нүүрний хувирал, гар болон хөлийн дохио зангаагаар илэрч байдаг. Дохио зангаа бүр өгүүлбэр доторх үгтэй адил учраас түүний утга санааг сайн ойлгож мэддэг байх хэрэгтэй.

#### Биеийн хэлийг хэрхэн ашиглах жишээ:

*Нүүрний хувирал нь хүний сэтгэл хөдлөл, мэдрэмжийг ойлгоход их тус болдог. Тиймээс та сургалтын үеэр аль болох инээмсэглэж, инээсэн царайтай байх хэрэгтэй. Хэрвээ хөмсгөө зангидсан байдалтай оролцогчдын зүг харах юм бол тэд таныг ууртай, сэтгэл дундуур байгаа юм байна гэж бодно. Та сургалтаа явуулж байхдаа аль болох бүх оролцогчидруу жигд харж байх хэрэгтэй. Эхний эгнээнд сууж буй оролцогчид, эсвэл таныг анхааралтай сонсож байгаа хэсэг рүү нүдний хараагаа чиглүүлэн ярьвал бусад оролцогчдын сурах идэвхи буурдаг. Хэрэв та хичээлээ зааж байх үедээ хоёр гараа арагш нь гэдийлгэсэн байдалтай зогсох юм бол өөртөө итгэлтэйг, харин гараа чанга атгасан байвал та хэтэрхий дарамттай байдалтай харагдах болно.*

- **Сургалтын олон арга ашиглах.** Сургалтын явцад багш өөрийн чадавхи, боломж, онцлогтоо тохируулан янз бүрийн сургалтын арга зүйг хэрэглэж болно. Хэдийгээр одоо хүртэл лекцийн хэлбэрийг өргөн хэрэглэж байгаа боловч, бусдаасаа илүү гэсэн нэг ч арга байхгүй. Гэхдээ жендэрийн агуулгатай сургалтын үед идэвхтэй оролцоо, нээлттэй харилцан яриг онцолсон сургалтын аргыг хэрэглэх нь чухал. Ялангуяа сургах, сурах арга зүйг хослуулан хэрэглэх шаардлагатай. Энэ хоёр арга зүйн аль алиных нь

байнгын өөрчлөлт, явц нь оролцогчдыг үргэлж суралцахад бэлэн байлгадаг. Ямар ч арга сонгосон, тухайн арга сургалтын зорилгодоо хүрэхэд тань үр ашигтай байх ёстой. Тиймээс сургалтын зорилгодоо тулгуурлан сургалтыг зохион байгуулахад тохирсон аргуудыг сонгож ашиглах хэрэгтэй.

### Мэдээлэл

#### Сургалтын аргын тухай

Сонгож авсан сургалтын аргууд нь сургалтын ямар зорилгыг илүү хангахад тохиромжтойг харуулъя. Үүнд:

- Илтгэх онол нь мэдлэгт тохиромжтой.
- Үзүүлэн таниулах материал ашиглах нь мэдлэгийн баталгаажилт, ур чадварт тохиромжтой.
- Хэлэлцүүлэг нь мэдлэг, ур чадвар, хандлагаа өөрчлөхөд тохиромжтой.

Мөн ямар зорилтот бүлэгт ямар сэдвийн хүрээнд сургалт явуулах гэж байгаагаас шалтгаалан сургалтын аргуудаа сонгох хэрэгтэй. Жишээлбэл, төрийн удирдах албан тушаалтнуудад сургалт явуулах бол эхлээд тухайн сэдвийнхээ хүрээнд бодит жишээг танилцуулахаас эхэлж болно. Үүний дараа тусгайлан бэлтгэсэн үзүүлэн таниулах материалаа харуулж товч бөгөөд тодорхой ярих хэрэгтэй. Үүний дараа хэлэлцүүлгийн аргыг ашиглан асуулт хариулт өрнүүлж, тэдний санал бодлыг сонсож болно.

Харин жендэрийн сургалт хийх багш нар орон нутгийнхаа иргэдэд зориулж жендэрийн талаарх тэдний ойлголтыг нэмэгдүүлэх ухуулга нөлөөллийн ажил хийх бол зураглал үзүүлэх, түүх ярих, дасгал тоглоом, үзүүлэн материал ашиглах нь илүү үр дүнтэй. Тухайлбал, иргэдээс үзэл бодол зөрүүтэй хүмүүсийг сонгож, тэдний саналыг сонссоны дараа аль аль үзэл бодлынх нь талаар бодит түүхийг хэлж болно. Дараа нь үзүүлэн таниулах материал ашиглах байдлаар мэдээлэл өгч, жендэрийн хэвшмэл ойлголт, нэр томъёоны талаар дасгал тоглоомын аргыг ашиглан танилцуулга хийж болно. Ер нь олныг хамарсан сургалтын үеэр аль болох оролцогчдыг өөрсдийг нь оролцуулсан зурах, багаар ажиллах аргуудыг илүү түлхүү ашиглах хэрэгтэй.

#### Сургалтын олон аргыг хослуулан ашиглах жишээ:

*Жишээ 1. Төрийн байгууллагын нэгэн даргатай хийсэн доорхи ярилцлагыг уншаад дүн шинжилгээ хийх даалгаврыг сургалтанд оролцогчдод өгч болно. Гол нь тухайн жишээнээс юуг ойлгож авсан, дүгнэлт, сургамж, өөрийн шийдвэр гаргах, нотолгоо эсвэл няцаалтыг оролцогчид бичих юм.*

*Ярилцлага: “Хүчирхийлэл нь хүчирхийлэл үйлдэгчийн бусдыг эрхшээлдээ байлгах гэсэн хүсэл, хүч хэрэглэж асуудлыг шийдэх гэсэн буруу хандлагаас*

үүдэлтэй. Нөлөөлөгч хүчин зүйлд сөрөг зан үйл, ядуурал зэргийг хэлж болно. Тиймээс асуудлыг хүч хэрэглэн шийдэх буруу хандлагыг өөрчилж, нөлөөлж буй хүчин зүйлсийг багасгаж байж хүчирхийллээс урьдчилан сэргийлж, таслан зогсоож чадна. Мөн хуулийн зарим зүйл заалтыг өөрчилж, чангатгах хэрэгтэй. Хориглосон зүйл заалтууд хуульд байдаг ч дутуу юм олон бий. Жишээ нь: Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ямар ямар арга хэмжээг, хэн хэрхэн явуулахыг, хориглоод дийлээгүй тохиолдолд мэдээллийг хэрхэн өгөх, мэдээлэл авсан тал ямар үйл ажиллагаа явуулах, хохирогч, гэрчийг хэрхэн хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид ямар хариуцлага тооцох зэрэг асуудлыг тусгасан Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинээр боловсруулах зайлшгүй шаардлага тулгараад байна.”

Жишээ 2. Оролцогчдыг бусад салбарын болон иргэний нийгмийн байгууллагуудын сайн туршлагаас суралцуулж болно. Үүний тулд танилцах аялал хийх замаар хэн нэгнийхээ байгууллагад зочлон очиж, бодит байдалд хэрхэн жендэрийн асуудлаар үйл ажиллагаа явуулж байгааг нь хардаг. Туршлагаа хуваалцаж байгаа мэргэжилтэн, байгууллага нь өөрсдийн амжилттай болсон үйл ажиллагаа, сайн туршлагаа үзүүлэн таниулах материал, цахим хуудас, видео бичлэг, хэлэлцүүлэг, түүх ярих зэрэг аргыг ашиглан бусдад түгээж болно.

Жишээ 3. Бэрхшээлийн мод зурах аргыг ашиглан салбар зөвлөл, хорооны дарга, гишүүдэд зориулан жендэрийн сургалтыг явуулахад тулгамдаж буй асуудлаас нэн тулгамдсан нэг асуудлыг сонгож аваад жендэрийн мэргэжилтнүүдийн дунд багийн ажил хийлгэж болно. Бэрхшээлийн мод арга нь гол бэрхшээл, түүний шалтгаанууд, сөрөг үр дагавруудын уялдаа холбоог гаргаж ирэх боломжийг сургалтанд оролцогчдод олгодог давуу талтай. Нэн тулгамдсан бэрхшээлтэй асуудал буюу “жендэрийн сургалтыг үр дүнтэй явуулж чадахгүй байна” гэсэн асуудлыг сонгон авч сургалтанд оролцогчид буюу жендэрийн мэргэжилтнүүд “Жендэрийн сургалтыг хэрхэн үр дүнтэй явуулах вэ?” асуултын хүрээнд оюун санааны зураглал зурж асуудлыг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлж болно.

□ **Оролцогчдын идэвх оролцоог дээшлүүлэх, тэднийг урамшуулан дэмжих.** Энэ нь сургагч багшийн эзэмшвэл зохих нэг чадвар бас үүрэг байдаг. Тиймээс багийн ажил, дүрд тоглох, дүн шинжилгээ хийх дасгал ажлын үеэр оролцогчдыг урмын үгээр дэмжиж заавар зөвлөгөөг өгөх хэрэгтэй. Мөн оролцогчид ядарсан, асуудлаа гаргаж ирж чадахгүй байгаа тохиолдолд дасгал тоглоомын аргыг ашиглан тэднийг сэргээж, шинэ соргог байдлаар багийн ажлаа үргэлжлүүлэх, хичээлдээ анхаарлаа хандуулахад нь туслах хэрэгтэй. Мөн дуугүй, ганцаардмал, хичээлд идэвхтэй оролцохгүй байгаа оролцогчид руу илүү хандаж тусалж дэмжих нь нийт оролцогчдын эерэг уур амьсгалыг бий болгоход тустай байдаг. Зарим сургагч багш сургалтын үеэр оролцогчдоо урамшуулан дэмжиж

өөрийн гаргасан гарын авлага, ном материалаа бэлгэлэх, зарим нь сургалтын төсөвтөө урамшууллын бэлгийн зардлыг ч тусгасан байдаг.

### Мэдээлэл

#### Хамтран сургалт зохион байгуулах тухай

Сургагч багш нарын хувьд хамтран сургалт зохион байгуулах тохиолдол олон гардаг. Хамтран сургалт зохион байгуулах нь хэд хэдэн давуу талтай байдаг. Үүнд:

- Харилцан бие биенээ нөхдөг. *Нэг сургагч багш нь оролцогчдод мэдээлэл өгөх тал дээрээ илүү туршлагатай бол нөгөө нь тухайн мэдээлэл дээр тулгуурлан дасгал ажил болон багийн ажлыг зохион байгуулдаг.*
- Бэрхшээл, эрсдлийг хамтдаа туулдаг. *Сургалтын бэлтгэл ажлаас эхлэн сургалтын үеэр гарсан аливаа асуудлыг шийдвэрлэхэд харилцан ярилцаж, эрсдлээс гарах арга замыг хамтдаа тодорхойлдог.*
- Хэвтээ тэнхлэгт манлайллыг хөгжүүлдэг. *Сургагч багш нар адил эрх, үүрэг, оролцоотой байж сургалтын зорилго тодорхойлох, хөтөлбөр, агуулгаа боловсруулах, шийдвэр гаргах зэрэгт тэгш оролцдог.*
- Харилцан бие биенээсээ суралцдаг. *Сургалт зохион байгуулах чадвар, тухайн сэдэвтэй холбоотой мэдлэг, оролцогчидтой харилцаж буй байдал, хамтран ажиллаж байгаа чадвар зэргээс нь байнга суралцаж байдаг.*

### 3. Сургалтын дараа юу хийх вэ?

- **Сургалтын үр дүнг дүгнэх.** Сургалтын үнэлгээг хийснээр сургагч багш нь өөрийнхөө ажлын чанар, өгөөжийн талаархи болон цаашид зохион байгуулах сургалтаа сайжруулах мэдээллээ олж авдаг. Сургалтын үр дүнг үнэлж дүгнэнэ гэдэг нь оролцогчдод сургалтын хөтөлбөр, түүний агуулга хэр таарч тохирсон, ямар шинэ зүйлийг сурч эзэмшсэн, үйл ажиллагаанд нь ямар өөрчлөлт гарсан, аж амьдралд нь ямар нөлөөтэй болсон гэдгийг тодорхойлно гэсэн үг юм.

Үнэлгээ өгөх, санал бодлоо хуваалцах нь оролцогчдод сургалтын үеэр юу сурч, ямар үйл ажиллагаанд оролцсон тухайгаа бодох, цэгцлэх боломж олгож байгаа юм. Эерэг сайхан зүйлс хэлэх нь мэдээж хүлээн авч буй хүнд таатай, урам зориг хайрлах боловч сөрөг шүүмжлэл нь сургагч багшид мэргэжлийн хувьд илүү хөгжих, аргаа барилаа сайжруулахад нь ашиг тустай байдаг. Сургалтын үед гарч байсан бэрхшээлүүдийн шалтгааныг олж мэдэх нь сургагч багшид туршлага хуримтлуулах, ур чадвараа нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэгийг мартаж болохгүй.

Сургалтын үр дүнг үнэлэх жишээ:

Сургалтанд оролцогчдын мэдлэг, чадвар хэр өөрчлөгдсөн талаар мэдэхийг хүсвэл, “өмнө нь ба дараа нь” гэсэн харьцуулах хэлбэрээр сургалтын үнэлгээг хийдэг. Жишээ нь сургалтын эхэнд оролцогчид өгсөн асуултаа, сургалтын дараа дахин өгч мэдлэг, чадварын өөрчлөлтийг харьцуулж харж болдог. Мөн сургалтанд оролцогч ямар мэдлэг, чадвар эзэмшсэн түүнийгээ хэрхэн өөрийн эрхэлж буй ажил, амьдралдаа ашиглах талаар мэдээлэл авах зорилго бүхий асуулгын хуудас өгч хариулт авч болдог.

**Мэдээлэл**

**Сургалтын үнэлгээний тухай**

Сургалтын дараа сургагч багийн гүйцэтгэлийн талаарх үнэлгээг дараах асуулгын хүрээнд хийж болдог. Үүнд:

- Сургагч багш сургалтын зорилго, хүлээгдэж буй үр дүнг танилцуулсан уу?
- Зааж буй хичээлийнхээ сэдвийн хүрээнд хэр мэдлэгтэй байсан вэ?
- Сургалтын олон аргыг ашигласан уу?
- Оролцогчдын асуултанд хариулж чадсан уу?
- Хэрэгцээтэй материалаар хангасан уу?
- Сургалтын үр бүтээлтэй орчин бүрдүүлж чадсан уу?
- Сургалтын үйл явцын хурд ямар байсан вэ?
- Биеийн хэл ашигласан уу?
- Дуу хоолойгоо зөв тохируулж байсан уу?
- Сургалтын цаг хугацааг зөв төлөвлөж баримталсан уу? г.м

□ **Сургалтын тайлан бичих.** Сургалтын тайлан нь сургагч багшийн ажлыг үнэлэх, сургалтын талаарх мэдээллийг оролцогчид болон захиалагч нарт хүргэх гол хэрэгсэл юм. Сургалтын тайланд дараах зүйлсийг оруулж бичих хэрэгтэй. Үүнд:

- Сургалтын зорилго
- Зохион байгуулагдсан он сар өдөр, газар,
- Хамтран зохион байгуулсан байгууллага, багшийн нэр
- Оролцогчдын талаарх мэдээлэл (үүнд: оролцогчдын хүйс, шаардлагатай гэж үзвэл нас, мөн албан тушаалыг тусгах)
- Сургалтын сэдэв, дэд сэдвийн талаарх товч мэдээлэл
- Сургалтын арга зүй
- Сургалтыг оролцогчид хэрхэн үнэлсэн талаарх мэдээлэл
- Оролцогчдын санал сэтгэгдэл
- Сургалтаас олж авсан сургамж

Мөн сургалттай холбоотой фото зураг, сургалтын үеэр оролцогчдын хийсэн үзүүлэн, зураглал, хэлэлцүүлгийн тэмдэглэл зэргийг хавсралт байдлаар сургалтын тайланд оруулах хэрэгтэй.







## Хичээл 2: Жендэрийн ойлголт

Хичээлийн төлөвлөгөө

Зорилт: Сургагч багш нарын жендэрийн талаарх ойлголтыг дээшлүүлэх

Хэрэглэгдэхүүн:

- <https://www.youtube.com/watch?v=hREiBYfO17E>
- “Жендэр ба бодлого төлөвлөлт” модуль сургалт, ЖҮХ, 2018

Хугацаа: 60 минут

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Хугацаа /минут/	Хичээлийг чиглүүлэх алхам	Аргачлал
10 мин	Мэдлэг олгох: Оролцогчдод хүйс, жендэрийн ялгааг дараах <a href="https://www.youtube.com/watch?v=hREiBYfO17E">https://www.youtube.com/watch?v=hREiBYfO17E</a> видео болон ППТ ашиглан оролцогчдод ойлгуулах	Видео Мэдээлэл
25 мин	Сэдэлжүүлэх дасгал: Оролцогчдыг 2 багт хуваана. Нэгдүгээр баг малчин эрэгтэй, хоёрдугаар баг малчин эмэгтэйн нэг өдрийн ажлыг 10 минутад багтаан дүрслэн зурна. Сургагч багшийн зүгээс энэ дасгал ажлын үеэр ямар нэгэн санал, зөвлөмж өгөхгүй, сонсох үүргээр оролцоно Багууд зургаа зурсны дараа танилцуулга хийнэ. Үүнд: эмэгтэй эрэгтэй хүнийг дүрсэлсэн элементүүдийн аль нь хүйстэй, аль нь жендэртэй холбоотойг ярилцана. Жишээ нь, эмэгтэй хүнд хөх, эрэгтэй хүнд сахал зурсан нь хүйсийн шинж, харин эмэгтэй хүнийг ээмэг, алчууртай, эрэгтэй хүнийг гаанс бариулан зурсан нь жендэрийн шинж г.м. Дараа нь чиглүүлэгч оролцогчид хамтран жендэрийн дүр төрх, үүрэг, үнэлэмж, жендэрийн хэвшмэл ойлголтын талаар багуудын зурсан зураг дээр дахин ярилцана	Үзүүлэн материал ашиглах Багаар ажиллах Дүн шинжилгээ хийх
25 мин	Мэдлэг бататгах: Жендэрийн ойлголтыг бататгах, жендэрийн үүрэг, хэвшмэл ойлголтын уялдаа холбоо, хамаарлын талаар бодит түүх болон судалгааны тайлан ашиглан тайлбар хийнэ	Сайн туршлага Хэлэлцүүлэг

Мэдлэг олгох хэсэгтэй холбоотой унших нэмэлт мэдээлэл

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.1-д "жендэр" гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага" гэж тодорхойлсон байдаг.

"Жендэр" нь дэлхий нийтэд түгээмэл хэрэглэж буй компьютер, техник зэрэгтэй адил шинэ үг бөгөөд улс орнууд хэлний онцлогтоо нийцүүлэн ашигладаг.

Жендэр гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн биологийн ялгаа ба нийгмийн үүргийг ялган салгаж ойлгохын тулд хэрэглэх болсон, тэдний эдийн засаг, нийгэм, улс төр ба соёлын амьдралын онцлог шинж чанар, боломж бололцоог тодорхойлдог нэр томъёо юм.



Жендэрийн агуулга нь нийгэм соёл бүрт харилцан адилгүй бөгөөд цаг хугацаанд хувиран өөрчлөгдөж байдаг учраас байгалиас заяасан, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хувьсан өөрчлөгддөггүй биологийн "хүйс" хэмээх нэр томъёоноос ялгаатай.

Жендэр нь хүмүүсийн хүлээсэн үүрэг, хариуцлага, тулгарч буй саад бэрхшээл, хүртэж буй боломж бололцоог нь дүгнэн шинжлэх нийгэм-эдийн засаг, улс төрийн шинжтэй хувьсах хэмжигдэхүүн юм. Тиймээс жендэр нь нийгмийн анги давхраа, нас, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, газарзүйн байршил, эдийн засаг, улс төр, соёлын орчин гэхчлэн олон үзүүлэлттэй харилцан хамааралтай байдаг.

Жендэрийн талаарх жишээ авч тайлбарлахдаа эмэгтэй эрэгтэй хүмүүсийг тэнцвэртэй танилцуулахад анхаараарай. Тухайлбал, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн нийгэм гэр бүлдээ гүйцэтгэх үүрэг харилцан адилгүй байдаг: аймгийн төвд амьдарч буй эмэгтэй, хөдөөгийн малчин эмэгтэй хоёрын гүйцэтгэж буй ажил үүрэг, амьдралд нь тулгарч буй асуудал ялгаатай. Мөн хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй оюутан, энгийн эрэгтэй оюутан хоёрын эрүүл мэндийн, нийгмийн асуудал өөр ялгаатай гэх мэт.

### Жишээ

Жендэртэй холбогдох ажил хөдөлмөрийн асуудал нь мэргэжил сонголтоос өгсүүлээд ажлын байран дахь жендэрийн эрх тэгш байдал хүртэл олон ойлголтыг хамарсан маш том сэдэв гэж хэлж болно. Тэр дундаа ажил хөдөлмөр дэх жендэрийн хуваарь гэж нэг ойлголт бий. Гэр бүлийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлага болон ажлын шаардлагын хооронд үүсдэг зөрчил нь хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийг ашиггүй байдалд оруулдаг. Улмаар цалин багатай, баталгаагүй, хагас цагийн ажил сонгох нь түгээмэл бол эрчүүдийн хувьд карьерын шахалтаас шалтгаалж гэр бүлийнхээ амьдралд хангалтгүй оролцоход хүрэх нь бий. Энэ нь өрх гэрийн асуудал юм шиг харагдавч нийгэмд охид хөвгүүдийн сурч боловсрох, ажил мэргэжлээ сонгох, эрхэлсэн ажилдаа өсөж дэвшихэд ялгаатай байдлыг үүсгэдэг байна. Мөн ажил хөдөлмөр дэх жендэрийн хуваарь нь хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийн талаарх хэвшмэл ойлголтыг бэхжүүлэхэд ихэд нөлөөлж байдаг ажээ.

Эр хүн юм чинь, хөөрхөн хүүхэн юм чинь, эзэгтэй юм чинь гэхчлэн хайрцаглаж, эрхийг нь зөрчиж, бие биедээ халдсаныгаа “зүгээр шдээ”, “энийг бол ингэхэд яадаг юм” хэмээн хаацайлж, үл тоомсорлох нь ялгаваран гадуурхалтыг дэвэргэж улмаар бэлгийн хүчирхийллийг бий болгож байдаг. Жендэрийн мэдрэмжгүй нэгний бодлогогүй, бүдүүлэг үйлдлийн улмаас бие махбодь, сэтгэл санаагаараа хохирсон олон хүмүүс байдаг.

Жендэрийн тэгш эрхийн ойлголт зөвхөн эмэгтэй хүнд хамаарахгүй. Эрчүүд ч мөн хүйсээсээ шалтгаалан дарамтад өртдөг. Хөвгүүдэд бага байхаас нь л “эр хүн зоригтой байх ёстой, эр юм байж битгий уйлаад бай, охин шиг шалчигнахаа боль” гэхчлэн эр хүний талаарх нийгмийн тогтсон ойлголтыг хүчээр тулгадаг шүү дээ. Харин энэ бүхний үр дагавар юу вэ? Манай улсын хэмжээнд нийт амиа хорлосон зургаан хүн тутмын тав нь, гэмт хэрэгт холбогдож эрхээ хязгаарлуулсан хүмүүсийн 90 орчим хувь нь эрчүүд гэсэн судалгаа бий. Эрчүүдийн талаарх хэвшмэл ойлголтыг арилгаж, бусдын мэдрэмжийг хянаж цагдахаа больсон цагт энэ тоо буурах боломжтой. Амьдрал бол хамтын бүтээл. Нэгнээ байгаагаар нь хүлээж авч, хүлээн зөвшөөрч сурцгаая. Эр хүн ч уйлах эрхтэй.  
<https://unread.today/c/gender-everything-guide>

**Жендэрийн үүрэг нь** хүйсийн онцлогоосоо үүдэн амьдралын тодорхой үе шатанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн гүйцэтгэдэг ялгаатай ажил үүрэг

төдийгүй “эмэгтэйлэг”, “эрэгтэйлэг” байхын талаар тухайн нийгэм соёлд хэрхэн авч үздэгээс үүдэн эмэгтэй эрэгтэй хүмүүст нийгмийн зүгээс оноож буй “зохиомол” үүрэг юм. Эдгээр нь хамтдаа тэдний гадаад дүр төрх, зан авир, гэр бүл, нийгэмд эзлэх байр суурийг хэм хэмжээ болгон тодорхойлдог.

Жендэрийн үүрэг нь нийгэм соёл, анги давхраа бүрт ялгаатай байдаг төдийгүй боловсрол, технологи, эдийн засгийн хөгжил, дайн тулаан, өлсгөлөн, уур амьсгалын өөрчлөлт зэргийн улмаас байнга хувьсдаг. Тухайн нийгмийн нөхцөл байдлаас үүдэн жендэрийн үүрэг нь уян хатан, эсвэл хатуу, адил төстэй болон ялгаатай, мөн зохистой болон зөрчилтэй байж болно.

Жендэрийн үүрэг нь тухайн нийгэм соёл дахь жендэрийн харилцаа буюу эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хоорондох нийгмийн харилцаа, эрх мэдлийн хуваарилалтыг тодорхойлдог. Жендэрийн үүрэг, түүнээс үүдсэн жендэрийн харилцаа нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хэн хэнд тодорхой үүрэг хариуцлага ноогдуулан, хэм хэмжээ, хязгаарлалт тогтоож байдаг. Нийгмийн зохион байгуулалт, гишүүдийнхээ гүйцэтгэх үүргийн хамтаар хүн төрөлхтний түүхийн явцад өөрчлөгдсөөр ирснийг бид мэднэ. Нийгмийн үүргийн нэгэн хэлбэр болох жендэрийн үүрэг ч мөн өөрчлөгдөж байгааг бид хардаг. Гэтэл хүмүүс хүйсийн ялгаа тогтвортой байдагтай ижил жендэрийн үүрэг ч мөн хувирч өөрчлөгдөшгүй гэж ойлгодог. Ийнхүү ойлгож хандах нь жендэрийн хэвшмэл ойлголтыг төрүүлдэг.

**Жендэрийн хэвшмэл ойлголт (стереотип)** нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, тодорхой бүлгүүдийн шинж төрх, ялгаа, гүйцэтгэх үүргийн тухайд нийгэм соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан ерөнхий ойлголт юм.

Жендэрийн хэвшмэл ойлголт нийгэм соёл бүрт харилцан адилгүйгээс гадна цаг хугацааны явцад өөрчлөгддөг боловч эмэгтэйчүүдийн захирагдмал, хамааралтай байр суурийг хадгалж бэхжүүлсэн түгээмэл шинжтэй байдаг. Тухайлбал эмэгтэй хүний тухайд гэрлэж, олон хүүхэд төрүүлдэг, гэр бүлийнхээ сайн сайхны төлөө өөрийгөө золиослогч, асран халамжлагч, сайхан зан дуулгавартай, дур булаам, үзэсгэлэнтэй гэх зэрэг, харин эрэгтэй хүний тухайд өрх гэрийг тэжээгч, бие даасан, эрэлхэг, сэтгэл хөдлөлөө барьдаг гэх зэрэг хэвшмэл ойлголт түгээмэл. Ийм маягийн хэвшмэл ойлголтууд нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийн талаар харилцан адигүй хэм хэмжээг нийгэмд тогтоон хүлээлт үүсгэж, тодорхой дүрийг хувь хүмүүст тулгаж байдгаараа хувь хүний хөгжил дэвшил, өөрийгөө илэрхийлэхэд ихээхэн садаа болдог. Улмаар жендэрийн хэвшмэл ойлголт нь шударга бус хандахын, аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг.

Анхаарах зүйл:

1. Хэвшмэл ойлголтын талаар жишээ сонгохдоо эмэгтэй эрэгтэй хүмүүсийг тэнцвэртэй дүрслэх, мөн монголын болон бусад нийгэм соёлын жишээг тэнцвэртэй ашиглахад анхаарна.
2. Хэвшмэл ойлголтын талаар ярилцах нь зарим тохиолдолд үндэсний соёл уламжлал, зан заншилыг хөнддөг учраас мэдрэмжтэй байх хэрэгтэй. Зарим ёс заншил жендэрийн тодорхой хэм хэмжээг тогтоож байгаа боловч өнөөгийн нөхцөлд гэр бүл, хувь хүмүүсийн зан үйлд эерэг сайн нөлөөтэй байж болно. Жишээ нь эрэгтэй хүн гэрийн хойморт суух гэх мэт. Ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг зөвтгөх хэрэгсэл болж байгаа тохиолдолд халах шаардлагатай гэдгийг тайлбарлана.

## Жишээ

Эмэгтэйчүүд шагай харваж болохгүй буюу хуучинсаг сэтгэлгээнд тушигдсан үндэсний спортын хөгжил гарчигтай сэтгүүлч Б.Буяндалайн нийтлэл: Эх сурвалж: <https://equur.mn/284886/>

Түүнийг Оюунчимэг (Өөрийнх нь хүсэлтээр нэрийг нь өөрчлөв) гэдэг. Хэнтий аймгийн харьяат тэрбээр багаасаа аав, ахыгаа бэлтгэл хийх, тэмцээнд оролцоход нь дагаж явсаар шагайн харваанд хорхойсжээ. Анхандаа нууцаар бэлтгэл хийн, харваж сурч. Гэтэл үүнийгээ хэлэхээс зүрхшээсээр олон жил болжээ. Нэг удаа харваж байгаад баригдан, үнэнээ хэлэхээс аргагүйд хүрсэн байна. Түүнээс хойш аав, ах хоёртойгоо хамт бэлтгэл хийх болсон гэнэ.

Гурван жилийн дараа гэхэд аав, ахыгаа байтугай нутгийнхаа цолтой харваачийг ч хожих хэмжээнд хүрсэн байна. Гэхдээ түүнд улсын наадамд битгий хэл жирийн нэгэн тэмцээнд цэц сорих боломж огт байгаагүй. Оюунчимэг 30 жил шагай харвахдаа ганц ч тэмцээнд оролцож чадаагүй. Учир нь “Эмэгтэй хүн шагай харвадаггүй” гэсэн хэвшмэл ойлголт, “Болохгүй” гэдэг үг хөндөлссөөр, түүний олон, олон боломжийг үгүй хийсээр өдий хүрсэн юм.

Түүнтэй уулзсаны дараа “Миний нэрийг битгий бичээрэй. Эмэгтэй хүн байж шагай харван, өв уламжлалаа уландаа гишгэлээ гэж намайг хүмүүс гоочилно, элдвээр шүүмжилнэ. Аав, ах хоёрыгоо эвгүй байдалд оруулчих байх” гэсэн юм. Тиймээс бид ийн нэрийг нь өөрчлөв.

Хэдийгээр “Ийм учраас эмэгтэй хүн шагай харваж болохгүй” гэсэн тодорхой журам байхгүй ч бүсгүй хүн болж төрснөөсөө болж шагай харвах, тэмцээнд оролцох эрхээ эдэлж чадахгүй яваа олон, олон бүсгүйчүүдийн нэг нь Оюунчимэг.

Монголчууд бид өнөөг хүртэл “За, угаасаа эмэгтэй шагай харваж, бөх барилдаж болдоггүй” гэсээр өдий хүрсэн. Өв уламжлалаа дээдлэх, ирээдүй хойчдоо өвлүүлэх чухал ч нөгөө талаар хуучинсаг сэтгэлгээ биднийг хүлсээр,

тушсаар ирсэн нь үүнд нөлөөлж байгаа юм. Сүүлийн үед энэ асуудал хүчтэй яригдаж, олны анхаарлыг татах боллоо. Учир нь Монголд шинээр байгуулагдсан Олон улсын шага Монголын холбоо энэ долоо хоногт хийх тэмцээндээ эмэгтэй тамирчдыг анх удаа цэц сориулах гэж буй нь олныг ихэд талцуулж байна.

Үүнийг эсэргүүцсэн Монголын шагайн харвааны холбооныхон өнгөрсөн долоо хоногт хэвлэлийн хурал хийхдээ “Эмэгтэй хүн дээр үеэс шагай харваж байгаагүй. Учир нь эмэгтэйчүүд эрчүүдийг дээдэлж, эр улсын тоглоомоор тоглодоггүй уламжлалтай. Энэ уламжлал одоо ч хадгалагдсаар ирсэн. Хэрвээ бидний шаардлагыг биелүүлэхгүй бол тэмцээн болох “Мөсөн өргөө”-нд очиж хэвтэнэ, хүчтэй эсэргүүцэл үзүүлнэ” гэж мэдэгдсэн юм.

Шагайн харваагаар дээр үеэс өнөөг хүртэл зөвхөн эрэгтэйчүүд харван, цэц мэргэнээ сорьсоор ирсэн нь үнэн. Өв уламжлалаа дээдэлж, хүндэтгэх нь чухал уу гэвэл чухал. Гэхдээ “Зөвхөн эрчүүдийн спорт” гээд шагай харвах, тэмцээнд оролцох хүсэлтэй эмэгтэйчүүдийг шууд хориглох, тэдний эрхэнд халдах нь хэр зохистой вэ. Бид энэ удаа эл асуудлыг хөндлөө.

#### *Дондогдулам хатан шагай харвадаг байжээ*

Зөвхөн эрэгтэйчүүд шагай харвасаар ирсэн нь дээр үеэс тогтсон ёс уу. Эсвэл цаг хугацааны явцад өөрчлөгдөж, шинэчлэгдсээр ийм хэв шинжтэй болсон уу. Эхлээд энэ талаас нь судаллаа.

Түүхийн хуудас сөхөхөд, Богд хааны Их хатан Дондогдулам ордны үйлчин бүсгүйчүүдийг цуглуулж шагай харвадаг, хүрээний томоохон багуудтай өрсөлддөг байсан тухай түүхийн хэд хэдэн номонд өгүүлсэн байдаг. Дондогдулам хатан нэг удаа Богд хаанаас “Эмэгтэй хүн шагай харваж болох уу. Хориглох шалтгаан бий юү” гэж асуухад нь “Төр, шашны ёсонд харшлах зүйл үгүй. Эмэгтэй хүн наадамд цэц сорих нь хэр зохимжтой юм бол” гэж хариулсан гэдэг. Үүний сацуу “Уран” Янжин гэдэг алдартай харваач эмэгтэй байсан, Хүрээний алдартай багтай өрсөлдөөд хожсон гэх аман яриа бий. Эндээс харахад, дээхнэ үед эмэгтэй хүнийг шагай харвахыг эрс эсэргүүцэж, хориглодоггүй байсныг бэлхнээ харж болно.

#### *Монгол улс шагайн харвааг “ЮНЕСКО”-д бүртгүүлэхдээ жендерийн тэгш байдлыг хангана гэж амласан*

Нүүдэлчин монголчуудын язгуур өв соёлын нэг шагайн харвааг улсын наадмын хөтөлбөрт 1998 онд оруулсан. Улмаар 2014 онд “ЮНЕСКО”-гийн Соёлын биет бус өвийн хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтад 2015 онд бүртгүүлсэн юм. Монгол Улс шагайн харвааг “ЮНЕСКО”-д бүртгүүлэхдээ жендерийн тэгш байдлыг хангана гэж амласан. Энэ тухай материалыг хаанаас ч харах боломжтой. Тэгж амласан мөртлөө шагайн харваагаар

эмэгтэй хүн хичээллэх, тэмцээнд оролцох боломж хаалттай байсаар ирсэн, одоо ч тийм байгаа нь харамсалтай.

*Жендерийн тэгш байдлыг хангахгүй л бол ямар ч спортыг олон улсад хүлээн зөвшөөрөхгүй*

Үндэсний спортоо олон улсын түвшинд хөгжүүлэх бүр цаашлаад олимпын наадмын хөтөлбөрт багтаахыг хүсдэггүй, тэгэхийн тулд хөрөнгө, мөнгө зарцуулдаггүй улс гэж үгүй. Тийм боломж Монгол Улсад ч мөн нээлттэй. Тэгэхийн тулд тавигддаг таван том шалгуурын нэг нь жендерийн тэгш байдлыг хангасан байх. Тухайн спортыг олон улсад хэчнээн сонирхож, улс нь баруун, солгойгүй мөнгө цацсан ч жендерийн тэгш байдлыг хангахгүй л бол олон улсад хүлээн зөвшөөрөхгүй. “Эмэгтэй хүн хичээллэж болохгүй” гэдэг хэвшмэл ойлголтоор хандсаар байвал шагай ч мөн олон улсын түвшинд хөгжих боломж хаалттай хэвээр байна.

*Д.Сүнжид: Эмэгтэй хүн шагай харвахыг хориглох нь үндсэн хууль, жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг зөрчиж байна*

- “Шагай харваагаар зөвхөн эрэгтэй хүн хичээллэдэг. Эмэгтэй хүн харвадаггүй уламжлалтай” гээд бүсгүй хүн харвахыг эсэргүүцэх нь хүний эрх, жендер талдаа хэр ёс зүйтэй үйлдэл вэ?

- За, хууль зүйн талаас нь тайлбарлая. Үндсэн хуулийн оршилд “Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн заасан байдаг.

Үндсэн Хуулийн 14 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” заасан. Эл заалтыг нарийвчлан 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүн тэгш эрхтэй” хэмээн заасан. Энэ шинжийг тодруулахад, юун түрүүнд хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх, жендерийн тэгш байдал хэмээх хоёр ойлголтыг хэрэглэдэг. Хүйс нь биологийн шинжийг, жендер нь нийгмийн бүх төрлийн харилцаанд хүйсээс үл хамааран адил тэгш оролцохыг илэрхийлдэг гэж үздэг.

Уламжлал, соёл нэрийн дор хүйсээр хууль зүйн үндэслэлгүйгээр ялгаварлах хориотой. Хүний эрхийг хэрэв хязгаарлах бол хуульд заасан үндэслэлээр л зайлшгүй, тохирсон байдлаар хязгаарлах учиртай.

Яригдаад байгаа шагайн харвааны тухайд уламжлалт соёл талаасаа ч, хууль зүйн үндэслэл талаасаа ч хүйсээр ялгаварлах үндэслэлгүй байна.



Соёлыг хадгалах, хүндэтгэх орон зай хэрэгтэй хэдий ч явцууруулж тайлбарлах боломжгүй. Соёлын өв уламжлал ихэнхдээ нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зан заншил, жаягаар илэрдэг, бас цаг үетэйгээ нийцэж байнга шинэчлэгддэг.

Монголын шагайн харвааны холбооныхны ярилцлага гарсантай холбогдуулан тус холбооны 2018 онд баталсан Шагайн харвааны нэгдсэн дүрмийг сайтнаас нь танилцлаа. Тэр дүрмэнд шагайн харвааны зорилго нь харваачдад болон залуу үеийнхэнд бие бялдар, гоо сайхны хүмүүжил олгох, эрүүл мэнд, сэтгэл зүйн хатуужлыг бэхжүүлэх, тэдэнд хамт олонч, ахмад үеэ хүндэтгэх уламжлалт ёс, жаягийг өвлүүлэх явдал гэдэг их зөв зорилго тодорхойлж, зохион байгуулалт, тэмцээний дүрмээ зохицуулсан байна билээ. Хүйсийн талаар дурдсан зүйл харсангүй.

- Шагай харвах, тэмцээнд оролцох хүсэлтэй олон эмэгтэй бий. Гэтэл бүсгүй хүн болж төрснөөсөө болж энэ эрхээ эдэлж чадахгүй байгаа нь ямар, ямар хууль зөрчиж байна вэ?

- Үндсэн хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг зөрчинө. Ерөнхийдөө спортын төрөлд хүйсээр ялгамжтай өрсөлдүүлдэг нь бие бялдрын хөгжил, жин, булчингийн хөгжил ялгаатай учраас тусад нь хүч сориулдаг. Түүнээс биш спортын төрлөөр хичээллэх, тэмцээнд оролцох бол нээлттэй боломж, өөрсдийн сонголт байх ёстой.





### Хичээл 3: Жендэрийн тэгш байдал

Хичээлийн төлөвлөгөө

Зорилт: Сургагч багш нарт жендэрийн тэгш байдлын ач холбогдлыг ойлгуулах

Хэрэглэгдэхүүн:

- Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь, сургагч багшийн гарын авлага, 2014, ЖҮХ
- Монгол улс: Жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин, 2020, ЖҮХ
- Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал, 2020, МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ, НҮБХХ: Эрх мэдлийн алхалт дасгал ажил
- Байгаль орчны салбарын жендэрийн стратеги (2014-2030)
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба талуудын оролцоо гарын авлага, ТНЗ, 2022

Хугацаа: 90 минут

Үйл ажиллагааны төлөвлөлт

Хугацаа /минут/	Хичээлийг чиглүүлэх алхам	Аргачлал
10 мин	Мэдлэг олгох: Жендэрийн тэгш байдлын талаар ППТ ашиглан мэдээлэл хийнэ	Мэдээлэл буюу ППТ
40 мин	Сэдэлжүүлэх дасгал: “Эрх мэдлийн алхалт” дасгал ажлаар оролцогчдод жендэрийн тэгш бус байдалд нөлөөлдөг хүчин зүйлс, тэгш бус байдлын үр дагавар, тэгш бус байдлыг үүсгэх (нийгэм эдийн засгийн, соёлын, хөдөө/хот, нийгэмд эзлэх байр суурь г.м.) шалтгааны талаар ярилцана Оролцогч бүрд урьдчилан бэлтгэсэн асуумж өгнө Сургагч багшийн заавраар эрх мэдлийн алхалт буюу дүрд тоглох дасгал ажлыг хийнэ. Зааврыг унших нэмэлт материалаас харна уу.	Эрх мэдлийн алхалт
20 мин	Мэдлэг олгох: Эрх мэдлийн алхалт дасгалын дараа ППТ ашиглан жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүй, бодлогын орчин ба удирдлага зохион байгуулалтын талаар товч мэдээлэл өгнө. Энэ мэдээллээс оролцогчид өмнөх дасгал дээр гарсан жендэрийн тэгш бус харилцааг хэрхэн зохицуулах ямар хууль, бодлого, хөтөлбөр, байгууллага байдаг талаар ойлголттой болно.	Мэдээлэл

20 мин	<p>Мэдлэг бататгах:                  Жендэрийн тэгш байдлыг хангах салбарын бодлогоос жишээ болгон Байгаль орчны салбарын жендэрийн стратегийн зарчмыг танилцуулна                  Байгаль орчны салбарын жендэрийн стратегийн зарчимд тусгагдсан зорилтот бүлгүүд болох эрэгтэй, эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт хүмүүс байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хэрхэн оролцох талаар мэдээлэл өгөх                  Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд иргэд өөрсдөө хэрхэн оролцож нөлөөлөх талаар ярилцана</p>	Мэдээлэл Хэлэлцүүлэг
--------	---	-------------------------

Дасгал ажлын заавар

Эрх мэдлийн алхалт дасгал ажлын заавар

1. Өрөөн доторх сандал, ширээг чөлөөлж зай гаргах ёстой. Боломжгүй бол сургалтын өрөөнөөс гадна коридорыг ашиглаж болно
2. Оролцогчдыг танхимын голд нэг эгнээнд зогсохыг урина
3. Оролцогч нарт урьдчилан бэлтгэсэн дүрийг хуваарилж өгнө
4. Оролцогч бүрийг өөрт таарсан дүрээ бусдад харуулалгүй зөвхөн өөрөө уншихыг сануулна
5. Оролцогч бүрд мөн урьдчилан бэлтгэсэн асуумж болон бал өгнө
6. Асуумжийн асуултыг нэг нэгээр дуудаж өгнө. Асуумжийн нэгдүгээр асуултад “тийм” гэж хариулсан нь урагшаа нэг алхам, “үгүй” гэж хариулсан нь хойш нэг алхам алхах гэх мэтээр бүх асуултад хэрхэн хариулснаасаа урагшаа эсвэл хойшоо алхахыг сануулна
7. Хүн бүр харагдахуйц газарт буюу хананд “Нийгмийн баялаг” гэсэн бичигтэй цаас наасан байна.
8. Урд ба ард зогсож буй оролцогчдоос нийгмийн баялагаас очиж аваарай гэсэн даалгавар өгнө
9. Урд ба ард зогсож буй зарим оролцогчдоос сэтгэгдлийг сонсоно: Ард үлдсэн хүмүүсээс яагаад баялгаас авахаар ирэхгүй байгааг нь асууж хэлэлцүүлэг өрнүүлнэ. Алхаж, гүйж ирсэн хүмүүсээс санаа, сэтгэгдлийг нь асууна, дараа нь урд, ойрхон байсан хүмүүсээс асууна.
10. Хэсэг ярилцаад, оролцогчдыг дүрээсээ гараад, тойрон суухыг урина. Дараах асуултын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлнэ.
  - Ямар хүнд нийгмийн баялгаас хүртэх боломж байна?
  - Ямар хүнд байхгүй байна?
  - Яагаад, юунаас шалтгаалж байна гэж бодож байна вэ? (Бодлого журамтай холбоотой юу, хувь хүний чадвараас шалтгаалж байна уу, хүйсээс хамаарч бна уу?)

- Оролцогч нарын хоорондын зай нь нийгэмд байгаа эрх тэгш бус байдлын бодит зайг илэрхийлж байна уу?
- Жендэрийн эрх тэгш байдлын ямар асуудал байна вэ? (Орлогоос хамаарч байна уу, ялгаатай хэрэгцээнээс үү, эрх үүргийн тэнцвэргүй байдал, жендэрийн хэвшмэл ойлголтоос уу, нийгэм эдийн засгийн, соёлын, хөдөө/хот, нийгэмд эзлэх байр суурь г.м)

### Оролцогчдод тараах дүрүүд

1. 55 настай, эрэгтэй мянгат малчин
2. Зуданд малаа алдсан малчин, 24 настай эрэгтэй
3. Сумын төвд хүүхдээ харж буй малчин эмэгтэй, 28 настай
4. Эрх толгойлсон, таван хүүхэдтэй, 40 настай эмэгтэй
5. Аймгийн төвд ажилладаг төрийн албан хаагч, 50 настай эрэгтэй
6. Хөгжлийн бэрхшээлтэй, сумын төвд амьдардаг ажилгүй, 25 настай залуу
7. Бусад улиралд давхар ажил эрхэлдэг малчин, 30 настай залуу
8. Олон улсын төсөлд хамрагдаж аж ахуй эрхэлдэг эмэгтэй, сумын төвд амьдардаг 45 настай
9. Айлын мал маллаж цалин авдаг тэтгэврийн насны эрэгтэй
10. Бэлчээрийн хомсдлоос болж маргаан үүсгэн хэрэгт татагдсан малчин залуу, 33 настай
11. Цөөн малтай учраас банкны зээл авч чадахгүй байгаа малчин, 38 настай эмэгтэй
12. 15 жил гаруй ажиллаж байгаа малчдын хоршооны дарга, 60 настай эрэгтэй
13. Малжуулах хөтөлбөрийн буцаан төлөлтөө төлж чадаагүй өрөнд орсон эмэгтэй, 36 настай
14. Гэр бүлийн хардалтаас болж хүчирхийлэлд өртөж байгаа малчин эмэгтэй, 22 настай
15. Өв залгамжлан мал маллаж буй залуу гэр бүлийн гишүүн, эрэгтэй, 35 настай
16. Аймгийн төв зам дагуу цагаан идээ, хоол хийж зардаг эмэгтэй, 45 настай
17. Аймгийн төвд нэрийн барааны дэлгүүртэй, 2 давхар байшинтай, 40 настай эмэгтэй
18. Сумын төвд тохилог зочид буудал ажиллуулдаг эрэгтэй, 48 настай
19. Аймгийн ИТХ-ын төлөөлөгч эмэгтэй, 37 настай
20. Уул уурхайн компанид тогтмол цалинтай ажилладаг эрэгтэй, 23 настай

**Асуумж**


Бөглөх заавар: “тийм” гэвэл 1-ийн тоо, “үгүй” гэвэл 0-ийн тоо тавиарай.

№	Асуулт	Тийм	Үгүй
1	Уур амьсгалын өөрчлөлтөөс ямар нэгэн хохирол амссан уу?		
2	Сарын орлогоороо гэр бүлийн хүнсний бүтээгдэхүүнээ авч чаддаг уу?		
3	Та эсвэл таны хүүхдүүд дээд боловсрол эзэмших боломжтой юу?		
4	Гэр бүлийнхээ чухал асуудлаар шийдвэр гаргахад оролцдог уу?		
5	Хамт олон, орон нутгийн асуудлыг ярилцаж байхад таны үг нөлөөтэй, жинтэй байж чаддаг уу?		
6	Орлогоо өөрөө хянан зарцуулах боломжтой юу?		
7	Яаралтай, зайлшгүй хэрэгцээтэй, гэхдээ үнэтэй хагалгаа хийлгэж чадах уу?		
8	Ганцаараа, биеэ даан чөлөөтэй зорчих боломжтой юу?		
9	Хүчирхийлэл, дарамтанд өртөхгүй байж чадах уу?		
10	Хувийн бизнес эрхлэх чадавхитай юу?		
11	Орон нутгийн шийдвэр гаргагч нартай уулзаж саналаа хэлэх боломжтой юу?		
12	Гэр бүлтэйгээ хамт амьдрах боломжтой юу?		
13	Байгалийн гамшигт үзэгдлээс хамгаалагдаж чадах уу?		
14	Ундны усаар бүрэн хангагдаж чадах уу?		
15	Эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ авах боломжтой юу?		
16	Сонгосон хүнтэйгээ суух боломжтой юу?		
17	Байгаа газраасаа дайжих шаардлага гарахгүй, хөөгдөхгүй гэдэгт итгэлтэй байж чадах уу?		
18	Мэдээллийн бүхий л сувгийг ашиглан мэдээлэл авч чаддаг уу?		
19	Өдөржингөө ажиллаж, ажиллаж гэртээ ирчихээд амарч чадах уу?		
20	Банкнаас их хэмжээний зээл авах боломжтой юу?		

Мэдлэг олгох хэсэгтэй холбоотой унших нэмэлт мэдээлэл:

**Жендэрийн тэгш байдал** гэдэг нь эмэгтэй эрэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл энэ нь эрэгтэй эмэгтэй хүмүүс ижилхэн байх бус, харин тэдний эдлэх боломж бололцоо нь тэгш, нийгэм, гэр бүлдээ эзлэх байр суурь, эрх үүрэг нь адил байх тухай ойлголт юм. НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO) жендэрийн тэгш байдлыг өнөөдөр дараах байдлаар томъёолж байна. Үүнд:

- Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн, охид хөвгүүдийн ялгаатай зан үйл, хүсэл эрмэлзэл болон хэрэгцээг эн тэнцүү анхаарч, үнэлж байхыг хэлнэ.
- Тэдний эдлэх эрх, хүртэх буюу сонгох боломж бололцоо, хүлээх хариуцлага нь ямар хүйстэй төрснөөс нь үл шалтгаалж байхыг хэлнэ.
- Эмэгтэй эрэгтэй хэн ч болов бүрэн дүүрэн амьдрах ёстой.



### **Жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүй, бодлогын орчин**

БНМАУ-ын 1924 оны анхны Үндсэн хуульд эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш шударга хандах талаар тусгасан нь 1992 оны Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөний гүнзгийрүүлсэн агуулгаар уламжлагдсан бөгөөд уг үзэл баримтлалын дагуу Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд баталсан.

Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгахад чиглэж байна.

Эмэгтэйчүүд нийгэм, эдийн засгийн эрх, улс төрийн ба хувийн эрх, эрх чөлөөгөө эдлэхэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулинд заасан эрх тэгш байх зарчим хэрэгжиж байна уу гэдэг нь маш чухал асуудал юм. Уг хуулинд жендэрийн эрх тэгш байдлыг дараахь үндсэн зарчимд тулгуурлана гэж заасан байдаг. Үүнд:

- ▶ жендэрийн тэгш эрхийн зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах;

- ▶ ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх;
- ▶ төрийн хариуцлагын зарчим: төр эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах талаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжоор ногдуулсан үүргээ биелүүлэх, түүний үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх;
- ▶ жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим: хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн агуулгатай болгох;
- ▶ жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчим: хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах.

Монгол Улсын Засгийн газраас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг (2013-2016), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг (2002-2015), (2017-2021) онуудад баталж үе шаттай хэрэгжүүлж байна. Бодлогод суурилсан төлөвлөгөөт үйл ажиллагааны хүрээнд 1996 оны Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай үндэсний хөтөлбөрөөс эхлэн тооцвол жендэрийн тэгш байдлын чиглэлээр нийтдээ 5 хөтөлбөр хэрэгжүүлжээ.

2013 оноос эхлэн салбар, орон нутгийн жендэрийн тусгайлсан бодлого, төлөвлөлтийг хөгжүүлж, өнөөдөр 9 салбарт жендэрийн стратеги, бодлого, 21 аймаг, нийслэл, нийслэлийн 8 дүүрэгт оролцоонд суурилан боловсруулсан жендэрийн дэд хөтөлбөр хэрэгжиж байна.

### ***Жендэрийн тэгш байдлыг хангах удирдлага зохион байгуулалт***

Жендэрийн харилцаа нь нийгмийн амьдралын бүх салбар, чиглэлийг хамардаг тул жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо нь салбар болон нийгмийн оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах чадамжтай байхыг дэлхий нийтээр даган мөрддөг Бээжингийн мөрийн хөтөлбөрт чухалчлан заасан байдаг.

Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлсэн, Жендэрийн үндэсний хороо нь ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, төрийн бусад болон төрийн бус байгууллагын төлөөллийг багтаасан салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан зөвлөх чиг үүрэг бүхий дэлхийн тэргүүн туршлагын жишээ юм.

Жендэрийн үндэсний хороо нь 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт 31 салбар хороо, төрийн захиргааны 14 төв байгууллага (яамд)-д салбар зөвлөлтэй, Хорооны Ажлын алба нь 14 ажилтантай, төрийн захиргааны төв байгууллагад 14, орон нутагт 31 жендэрийн мэргэжилтэнтэй ажиллаж байна.

Мэргэжилтнүүд Жендэрийн салбар зөвлөл, хороодод нарийн бичгийн үүрэг гүйцэтгэж, жендэрийн асуудлыг үндсэн ажлын хамт хавсран гүйцэтгэдэг. Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах үүрэг бүхий байгууллагууд, түүний дотор ЖҮХ-ны Ажлын алба нь үйл ажиллагааныхаа хүрээнд дотоод, гадаадын төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо бүхий өргөн хүрээтэй түншлэлийг хөгжүүлэхээр чармайж байгаа бөгөөд ТХЗ-уудын хүрээнд жендэрийн тэгш байдлыг хөгжлийн үндсэн арга стратеги хэмээн үзэж бодлого, үйл ажиллагааныхаа чухал хэсэг болгодог НҮБ-ын тогтолцооны байгууллагууд, түүний дотор олон улсын санхүүгийн байгууллагууд, түүнчлэн Хөгжлийн албан ёсны туслалцааны хоёр талт бүх байгууллагатай хамтран ажиллаж байна.

**Жишээ:**

***Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан  
Монгол Улс дахь НҮБ-ын мэдэгдэл***

2023 оны 03-р дугаар сарын 08

Улаанбаатар хот

Монгол Улсын охид, эмэгтэйчүүдийн дуу хоолой, улс төр, нийгэм, эдийн засаг дахь байр суурийг бэхжүүлэхэд технологи болон инновацын ололтыг ашиглах нь Монгол Улсын хөгжилд эерэг нөлөөллийг бий болгож, Тогтвортой хөгжлийн зорилгуудыг биелүүлэхэд чухал түлхэц болно.

Гэвч, цахим шилжилтийн үр өгөөжийг хүн бүрд тэгш хүртээхийн тулд охид, эмэгтэйчүүдийн оролцоог чухалчилж, цахим орчин дахь аюулгүй байдлыг нь хамгаалах ёстой.

Энэ жилийн Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дэлхий нийтээрээ инновац болон технологиор дамжуулан тэгш бус байдлыг бууруулж, жендэрийн ялгаатай байдлыг багасгах боломжийг онцолж байна. Цахимжилт болон хиймэл оюун ухааны дэвшил нь эдийн засаг, аж үйлдвэрлэл, нийгмийг өргөн хүрээнд өөрчилж буй хэдий ч, охид эмэгтэйчүүд хөгжлөөс орхигдож, үүгээр үл барам түүний сөрөг нөлөөлөлд өртсөөр байна.

Хэдийгээр Монгол Улс жендэрийн эрх тэгш байдлыг бий болгоход тодорхой ахиц гаргаж буй ч, хангалттай түвшинд хүрэхийн тулд цаашид илүү далайцтай, өргөн хүрээнд ажиллах шаардлагатай байна. Эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлт, хүнсний аюулгүй байдал, амьжиргааны өртгийн хэт өсөлт зэргээс үүдэн бий болж буй олон улсын болон дотоодын хямрал, бэрхшээлүүд нь одоогийн тэгш бус байдлыг улам ихэсгэж, өрх толгойлсон эмэгтэйчүүд, орон нутгийн эмэгтэйчүүд зэрэг Монгол Улсын эмзэг бүлгийн



иргэдэд хурцаар нөлөөлж байна. Эдгээр иргэдийн хямрал, бэрхшээлийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд мэдээлэл, харилцаа холбооны технологи ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж чадна.

Монгол Улсын охид, эмэгтэйчүүд технологи, санхүү, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, урамшуулал болон шийдвэр гаргалтын хувьд адил тэгш оролцох боломжгүй, мөн цахим болон цахим бус орчинд өргөн тархсан ялгаварлал, хүчирхийлэлтэй нүүр тулж буй байна. Жендэрийн хэвшмэл буруу ойлголтууд эдгээрийг улам дэврээж, олон нийтийн болон цахим орчин дахь эмэгтэйчүүдийн оролцоог хумих, цаашлаад охид, эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдал, аюулгүй байдалд нэн халтай, нөхөн сэргээх боломжгүй хохирол учруулдаг нийгэм, соёлын хэм хэмжээ амь бөхтэй оршсоор байна.

Мэдээллийн технологийн салбар дахь боловсрол болон хөдөлмөр эрхлэлт нь мөн тэнцвэргүй байдалд байна. Тухайлбал, 2022 онд мэдээллийн технологийн чиглэлээр их сургууль төгсөгчдийн 73% нь эрэгтэй оюутан байжээ.

Бид жендэрийн тухай сөрөг ойлголт, хэм хэмжээний эсрэг зогсож, охид эмэгтэйчүүдэд технологи, ур чадвар, хөдөлмөр эрхлэлт болон цахим эдийн засагт бүрэн оролцох тэгш, хүртээмжтэй боломж бүхий таатай орчныг бүрдүүлэх замаар эдгээр асуудлыг олон талт, харилцан уялдаатай арга барилаар шийдвэрлэх ёстой.

Бид тэгш хүртээмжтэй, тогтвортой бөгөөд хөгжингүй Монгол Улсын төлөөх бидний дараах хамтын алсын харааг хэрэгжүүлэх зорилгод Монгол Улс дахь НҮБ-тай нэгдэхийг Монгол Улсын нийт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хөвгүүд, охидод уриалж байна. Иймд:

- Охид хүчирхийлэлгүй, эрүүл, аюулгүй орчинд өсөн дэвшиж, шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи зэрэг өөрийн сонгосон бүхий л мэргэжлийн чиглэлээр суралцдаг;
- Мэргэжлийн ур чадвартай эмэгтэйчүүд нь жендэрт бус харин ур чадвар, гүйцэтгэлд суурилсан шударга бөгөөд адил тэгш цалин хөлс авдаг;
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд цахим эдийн засагт өндөр түвшинд оролцож, илүү үр өгөөж хүртдэг;
- Шилжин суурьшигч эмэгтэйчүүд нь хөгжлийн гадна орхигдохгүйгээр нийгэм, эдийн засгийн зохистой боломжийг тэгш хүртдэг;
- Малчин эмэгтэйчүүд орон нутгийнхаа хөгжилд идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг;

- Нийт охид эмэгтэйчүүд өрх гэрийн болон төрийн шийдвэр гаргах түвшинд эрх тэгш оролцдог, үзэл бодол, дуу хоолойгоо чөлөөтэй илэрхийлдэг;
- Залуу эмэгтэйчүүд аливаа дарамт, шахалтад өртөлгүйгээр эрүүл мэнд, бие махбодынхоо талаар бие даасан шийдвэр гаргадаг;
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажилтнуудын (80 гаруй хувь нь эмэгтэйчүүд) эрх, нийгмийн хамгаалал нь хамгаалагдаж, баталгаажсан Монгол Улсыг цогцлоон хөгжүүлэхэд хүн бүрийг хувь нэмрээ оруулахыг уриалж байна.

Бид Монгол Улсын тогтвортой хөгжлийг хурдасгахад технологи болон инновацийн дэвшлийг ашиглахдаа охид, эмэгтэйчүүдийг хөгжлийн гадна орхигдуулахгүй, тэдний аюулгүй байдал, сайн сайхан байдлыг нь эрсдэлд оруулахгүй байхуйц нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн Газар болон хөгжлийн бүхий л түншүүддээ уриалж байна.

### ***Байгаль орчны салбарын жендэрийн стратеги (2014-2030)***

Монгол орны уур амьсгал, байгалийн нөөц баялаг нь эрт үеэс өнөөг хүртэл оршин сууж ирсэн монголчуудын зан заншил, аж амьдралын хэв маяг, аж ахуй эрхлэлт, түүнийдотор эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарь, гэр бүл, нийгэмдээ гүйцэтгэх үүргийг тодорхойлж, ингэснээрээ монгол үндэстний жендэрийн харилцааг төлөвшүүлэх суурь нөхцөл болж ирсэн билээ. Уур амьсгал, байгалийн нөөцөд гарч буй сөрөг өөрчлөлт, ялангуяа цөлжилт, байгалийн нөөцийн хорогдол нь хот хөдөөгийн бүх насны эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд харилцан адилгүй нөлөөлж, улмаар нийгэм дэх тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлж улмаар ядуурал, эрүүл мэндийн эрсдэл, шилжих хөдөлгөөн зэрэг нийгмийн олон тулгамдсан асуудлыг хурцатгах хүчин зүйл болж байна. Сүүлийн жилүүдэд улам тулгамдаж буй уул уурхайн нөлөө, хот суурин газрын агаарын бохирдол, хатуу болон аюултай хог хаягдал болон бохир усны менежменттэй холбоотой асуудлууд нь байгаль орчинд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ хүн амын эрүүл мэнд аюулгүй байдлын эрсдэлийг ихэсгэж, амьдралын чанарыг муутгаж байна.

Нөгөө талаас сүүлийн жилүүдэд эрчтэй өрнөж буй нийгэм соёлын шилжилт нь монголын хот хөдөөгийн эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн үнэт зүйл, түүний дотор байгаль орчноо хамгаалах уламжлалт соёл, байгалийн нөөц баялагт хандах байдалд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд энэ бүхэн нь эргээд байгаль орчинд ихээхэн дарамт учруулж, байгаль орчны бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны үр дүнг бууруулах хүчин зүйл болж байна. Иймээс дээрх тулгамдсан асуудлыг шийдэх арга замыг байгаль орчин, жендэр ба тогтвортой хөгжлийн харилцан уялдааны хүрээнд эрж хайх хэрэгцээг бий болжээ.

Байгаль орчны салбарын жендэрийн стратеги нь салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй, оновчтой, нээлттэй болгон ногоон хөгжлийг дэмжихийг зорихдоо эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн жендэрийн хэрэгцээг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд эн тэнцүү харгалзан үзэх, тэднийг хөгжлийн хөдөлгөгч хүч гэж үзэх “Жендэр ба Хөгжил” хандлагыг баримтлах бөгөөд энэ нь дараах хоёр зарчмаар хэрэгжинэ. Үүнд:

- Байгаль орчны салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны үр нөлөө эмэгтэй эрэгтэй хүмүүс, охид хөвгүүд, нийгмийн бүлгүүдэд харилцан адилгүй тусч байгааг, тэдний ногоон хөгжилд оролцох боломж, чадавхи ялгаатай байгааг анхаарч судлах, бодлого төлөвлөлтөд тусгах жендэрийн мэдрэмжтэй байх зарчим.
- Байгаль орчны салбарт ажиллаж байгаа болон салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны үр шимийг хүртэж байгаа хот хөдөөгийн эмэгтэй эрэгтэй хүмүүс, охид хөвгүүд, нийгмийн бүлгүүдийг чадавхижуулах замаар ногоон хөгжилд илүү өргөн хүрээнд үр өгөөжтэй оролцон үр шимийг нь хүртэх боломжийг нь нэмэгдүүлэх, улмаар нийгэм дэх жендэрийн тэгш бус байдлыг арилгахад бодитой хувь нэмэр оруулах жендэрийн хувьд өөрчлөн сайжруулах зарчим.

*Жендэрийн стратегийн зорилтот бүлгүүдэд* байгаль орчны салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний үр шимийг хүртэгч нийт хүн ам буюу Монгол улсад амьдарч буй хот хөдөөгийн нийт хүн ам энэ бүлэгт хамрагдана гэж стратегид тодорхойлсон байна.

Байгаль орчны бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн хүн амд нөлөөлөх байдлыг үе шаттай үнэлж, хэрэгцээг нь салбарын бодлого болон хөгжлийн бусад хөтөлбөрт тусгахад бүх насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувь нэмэр оруулна гэж үзсэн байна.

### ***Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд талуудын оролцоо***

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах, саналыг авахад төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага, орон нутаг, төрийн захиргааны байгууллага зэрэг олон талт хамтын ажиллагаа шаардлагатай байдаг бөгөөд байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах асуудлыг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд хариуцдаг.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах” журмын дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах ажлыг 2 үе шаттай байх, үе шат тус бүрийн арга хэлбэрийг зохицуулсан байдаг. Үүнд:

<p><b>Үе шат 1 – Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ боловсруулах шатанд хийгдэх уулзалт, асуумж судалгаа</b></p>	<p><b>Үе шат 2 – Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ боловсруулж дууссаны дараа Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх</b></p>
<p>Тус журмын 2.5.2 дах заалтыг үндэслэн БОННУ боловсруулж буй хийх эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгаагаар нөлөөллийг тогтоох, таамаглах, үнэлэх үе шатан дахь олон нийтийн оролцоог хангах шаардлагатай. Ингэхдээ,</p> <ul style="list-style-type: none"> <li>• иргэдтэй уулзалт хийх,</li> <li>• иргэдийг оролцуулан нөлөөллийг үнэлэх аргачлалыг ашиглах,</li> <li>• уулзалт хэлэлцүүлэг хийх,</li> <li>• бичгээр санал асуулга явуулах зэрэг арга хэлбэрээр иргэдийн саналыг авна.</li> </ul>	<p>Тус журмын 2.7 дох заалтыг үндэслэн төсөл хэрэгжүүлэгч болон БОННУ боловсруулж буй хийх эрх бүхий аж ахуйн нэгж хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, үе шат 1-д заасан олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авах шаардлагатай байдаг.</p>

**Оролцогч талуудын тэгш, хүртээмжтэй байдлыг хангах**

1. Оролцогч талуудыг зураглалын аргыг ашиглан тодорхойлох нь төслийн шууд болон дам нөлөөнд өртөж болзошгүй, тухайн төслийн үйл ажиллагааг сонирхсон эсвэл нөлөөлөлд өртөж магад гэж өөрийгөө үзэж буй оролцогч талуудыг орхигдуулахгүй байхад тусалдаг.
2. Оролцогч талуудыг тодорхойлохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх. Мөн хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн эмзэг бүлгийн төлөөллийг тэгш хамруулах
3. Оролцогчдын сонирхол, нөлөөллийг харгалзан үзэж, тэдний дэмжлэгийг авахын тулд юу хийх хэрэгтэйгээ төлөвлөх нь асуудлыг шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ. Хэн, ямар үндэслэлээр дэмжиж байна, хэн сонирхож байна, хэн эсэргүүцэж байна вэ гэдгийг тодорхойлсноор оролцогч бэртэй хамтран ажиллах, нөлөөлөх арга замаа мэдэж авна.



#### **Хичээл 4: Жендэрийн дүн шинжилгээ**

Хичээлийн төлөвлөгөө

Зорилт: Сургагч багш нарын жендэрийн дүн шинжилгээ хийх чадварыг дээшлүүлэх

Хэрэглэгдэхүүн:

- Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь дүн шинжилгээ, ЖҮХ, 2021
- Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь, сургагч багшийн гарын авлага, 2014
- Тогтвортой амжиргаа II төслийн тайлан
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2025)

Хугацаа: 90 минут

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Хугацаа /минут/	Хичээлийг чиглүүлэх алхам	Аргачлал
30 мин	Мэдлэг олгох: Жендэрийн дүн шинжилгээ, түүний ач холбогдол болон жендэрийн дүн шинжилгээ хийх арга: жендэрийн дүн шинжилгээний матриц аргын талаар оролцогчдод танилцуулна	Мэдээлэл Сайн туршлага
40 мин	Мэдлэг бататгах: Оролцогчдыг гурван багт хувааж дасгал ажил хийлгүүлнэ. <ul style="list-style-type: none"> <li>- Тогтвортой Амжиргаа II төслийн мэдээллийг багуудад тараана</li> <li>- Жендэрийн дүн шинжилгээний матриц аргын хуудсыг тараана</li> <li>- Багууд мэдээллийн дагуу жендэрийн дүн шинжилгээний матриц аргыг ашиглан төслийн үр дүн нь үр шим хүртэгчдэд хэр өгөөжтэй байсан тал дээр дүн шинжилгээ хийнэ</li> <li>- Багууд дүн шинжилгээгээ танилцуулна: Баг тус бүрийн дүн шинжилгээ юугаараа ижил төстэй, юу нь ялгаатай байгааг чиглүүлэгч дүгнэж танилцуулна</li> </ul>	Багаар ажиллах Кейс дээр ажиллах
20 мин	Дүгнэлт хийх: “Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ” судалгааны тайлангийн кейсийг ашиглан дараах асуудлын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлнэ. <ul style="list-style-type: none"> <li>- Таны эргэн тойрны хүмүүст ийм байдал үүсч байгаа юу, та түүнийг хэрхэн таньж мэдэж байна?</li> <li>- Жендэрийн дүн шинжилгээний дараа юу хийвэл илүү үр дүнтэй вэ?</li> </ul> Хэлэлцүүлгийн дараа жендэрийн дүн шинжилгээ хийх үе шатыг товч танилцуулах бөгөөд дүн шинжилгээний зөвлөмж боловсруулах, бодлогыг сурталчлах, дүн шинжилгээний чанарыг үнэлэх хэсэг нь хэр чухал болохыг тайлбарлаж өгнө	Мэдээлэл Оюуны дайралт Хэлэлцүүлэг Мэдээлэл

Мэдлэг олгох хэсэгтэй холбоотой унших нэмэлт мэдээлэл:

**Нэр томъёоны тайлбар**

**Жендэрийн дүн шинжилгээ (Gender analysis)** гэдэг нь бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилсан эсэхийг, оролцох болон үр ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц юм.

Жендэрийн дүн шинжилгээ нь хөгжлийн үйл явц дахь жендэрийн хүчин зүйлс болон жендэрийн харилцаанд өнгөрсөн хугацаанд олж авсан сургамж, одоо гарч буй болон ирээдүйд гарч болзошгүй өөрчлөлтүүдийг олж харах замаар бодлого, үйл ажиллагааны хүрээнд жендэрийн асуудлыг шийдвэрлэх арга зүйн дэмжлэг юм.

Жендэрийн дүн шинжилгээний хүрээнд дараах асуудлуудыг илүү тодорхой болгодог. Үүнд:

1. *Юу сайжирч, юу улам дордож байна вэ?* гэсэн асуултанд хариулж аливаа салбар дахь хөгжлийн нөхцөл байдлыг тодорхойлдог.
2. *Хэнд ямар нөөц байна вэ?* гэсэн асуултанд хариулж, төрөл бүрийн салбарууд дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг роль, үйл ажиллагааг тодорхойдог.
3. *Хэнд юу байна вэ? Хэнд юу хэрэгтэй вэ?* гэсэн асуултанд хариулж, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дундах хөрөнгө нөөцийн хүртээмж, эрх мэдлийг тодорхойлдог.
4. *Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээг хангахад гарч буй ялгааг арилгахын тулд юу хийх хэрэгтэй вэ? Хөгжлөөр тэдэнд юуг хүргэж, түгээх хэрэгтэй вэ?* гэсэн асуултад хариулж, шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлно. Тодорхой бодлого, хөтөлбөрийн агуулгад жендэрийн асуудлыг тусгаж өгснөөрөө төлөвлөгчид давхар суралцаж байдаг бөгөөд үүгээр жендэрийн дүн шинжилгээ хийх аргын практик шинж илэрч байдаг.

**Жендэрийн дүн шинжилгээ хийх арга зам**

Жендэрийн дүн шинжилгээ нь ашиглахад хялбар, энгийн, тодорхой байдаг. Ийм ч учраас жендэрийн дүн шинжилгээ хийх арга зам нь бодлого боловсруулагчдыг мэргэжлийн хувьд чадавхижуулж, жендэрийн асуудлаарх мэдлэгийг дээшлүүлдэг.

### Жендэрийн дүн шинжилгээний матриц

Жендэрийн дүн шинжилгээний матриц нь тухайн хөтөлбөр үйл ажиллагаа орон нутгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүст ямар нөлөө үзүүлж болохыг түргэн хугацаанд тогтооход тусалдаг оролцооны аргачлал буюу дүн шинжилгээний хэрэгсэл юм. Энэ аргыг хэрэглэснээр тухайн олон нийтийн өөрсдийнх нь нөлөөгөөр бий болсон жендэрийн асуудал юу болох, түүнийг дүгнэн шинжлэх боломжтой болно.

### Аргачлалын эерэг талууд:

- Энгийн бөгөөд дэс дараалалтай. Түгээмэл хэрэглэгддэг ангилал, үзэл баримтлалыг ашигладаг. Хувьсах боломжтой (суралцах үйл явцыг эхлүүлдэг).
- Олон нийтийн оролцоог хангаснаар доороос дээш чиглэсэн буюу иргэдийн санаа бодолд тулгуурласан судалгааны хэв шинжийг бэхжүүлнэ.
- Оролцогч талууд хөтөлбөрийн зорилтууд болон дүн шинжилгээ хийх талбаруудыг тодорхойлж байгаагаараа энэ нь бодитой оролцооны үйл явц болдог.
- Жендэрийн үнэлгээний матриц нь эрх мэдлийн харилцааг өргөн хүрээнд зураглах, тэгш бус байдлыг үүсгээд байгаа хүчин зүйлсийг илрүүлэх, улмаар тухайн олон нийт дэх жендэрийн үүрэг, байр суурь, нөөцүүдийн талаарх суурь ойлголтуудыг авахад тусалдаг.
- Эрэгтэй, эмэгтэй эсхүл улс төрийн бүлэглэл гэх зэрэг өөр өөр оролцогч талуудын дүн шинжилгээнд төвлөрсөнөөр тухайн олон нийтийн өвөрмөц, зөвхөн тэдэнтэй хамааралтай мэдээллүүдийг гаргаж ирдэг.
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын жендэрийн харилцааг онцолж үзэхээс гадна туулсан туршлагыг тус тусад нь судлан үздэг.
- Үр нөлөөг оролцооны аргаар үнэлэх судалгааны ажилд ашиглаж болно.
- Тоо баримт хурдан цуглуулахад ашиглаж болно.



Жендэрийн дүн шинжилгээний матрицийг ашиглах нь орон нутгийн хамгийн анхан шатны нэгжид жендэрийн дүн шинжилгээг хийхээс гадна асуудлууд хоорондоо хэрхэн уялдаж байгааг илрүүлэх ач холбогдолтой. Жендэрийн дүн шинжилгээний матриц нь дараах зарчмууд дээр тулгуурладаг. Үүнд:

- Жендэрийн дүн шинжилгээг хийхэд шаардлагатай бүх мэдлэг, мэдээлэл нь судлагдахуун болж байгаа хүмүүсийн амьдрал дунд оршиж байдаг.



- Жендэрийн дүн шинжилгээнд оролцсон хүмүүс л дүн шинжилгээний дүгнэлтэнд дахин саналаа хэлэх, өөрчлөх боломжтой.

Жендэрийн дүн шинжилгээний матриц нь тухайн олон нийтэд хандан хэрэгжүүлэх хөндлөнгийн үйл ажиллагаа буюу төсөл хөтөлбөрийн үр нөлөөг (эдгээрийн үр дүнд бий болно хэмээн төсөөлж байгаа өөрчлөлтүүд) эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өрхийн болон олон нийтийн гэсэн дөрвөн түвшинд шинжлэн дүгнэдэг (нас, нийгмийн давхарга, яс үндэс гэх зэрэг бусад түвшний үзүүлэлтүүдийг тухайн төслийн зорилго, зорилтоос хамааран нэмж оруулж болно. Энэ нь бусад хүчин зүйлсийн үйлчлэлийг харуулах давуу талтай байж болно).

Энэ аргачлал нь шинжилгээний дөрвөн хүрээ, дөрвөн чиглэлтэй. Үүнд:

Дөрвөн хүрээ:

1. **Эмэгтэйчүүд:** Зорилтот бүлэгт багтаж буй бүх насны эмэгтэйчүүд
2. **Эрэгтэйчүүд:** Зорилтот бүлэгт багтаж буй бүх насны эрэгтэйчүүд
3. **Өрх:** Нэг өрх гэр бүлээс хамаарахгүй байсан ч хамтдаа амьдарч байгаа эмэгтэй, эрэгтэй хүмүүс, хүүхдүүд
4. **Олон нийт:** Төслийн зорилтот орон нутгийн бүх ард иргэд

Дөрвөн чиглэл:

1. **Хөдөлмөр:** Тухайн санал болгож байгаа хөндлөнгийн оролцоо буюу төсөл хөтөлбөрийн үүрэг зорилтуудтай холбогдон гарах өөрчлөлтүүдэд хамаарна. Хэдий хэрийн хөдөлмөр шаардагдах (мэргэшсэн эсхүл туслах ажил, албан боловсрол, сургалт), тухайн ажлын цар хүрээ (хэдэн хүн тухайн ажлыг гүйцэтгэх, хэр ихийг тэдгээр хүмүүс хийж чадах, хүн хөлсөөр ажиллуулах зайлшгүй шаардлагатай эсхүл өрхийн гишүүд хийх боломжтой)
2. **Цаг хугацаа:** Тухайн төсөл, үйл ажиллагаатай холбогдон гарах ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хугацааны өөрчлөлттэй хамааралтай.
3. **Хөрөнгө нөөц:** Төслийн үр нөлөөгөөр бий болох хөрөнгө нөөцийг (орлого, газар, зээл) хүртэхтэй холбоотой өөрчлөлтүүд, тэдгээр нөөцийг захиран зарцуулах байдал нь бүлгүүдийн хувьд хэрхэн (ихсэх эсхүл багасах) өөрчлөгдөж байгаа г.м

4. **Нийгэм-соёлын хүчин зүйлс:** Тухайн төслийн үр нөлөөгөөр оролцогчдын нийгмийн байдалтай холбоотой өөрчлөлтүүд (жэндэрийн үүрэг, байр сууринд орж байгаа өөрчлөлтүүд мөн судлагдана).

Төслийн зорилго:				
Жендэртэй холбоотой зорилт:				
Дүн шинжилгээний түвшин	Дүн шинжилгээний үзүүлэлт			
	Хөдөлмөр	Хугацаа	Нөөц	Нийгэм, соёлын хүчин зүйлс
Эмэгтэйчүүд				
Эрэгтэйчүүд				
Өрх айл				
Олон нийт				
Өрх толгойлсон эмэгтэйчүүд				
Ажилгүй эрэгтэйчүүд				
Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд				

### **Дасгал ажлын кейс**

Тойм: Тогтвортой Амжиргаа Төсөл II нь (2008-2012) гурван үе шаттай хөтөлбөрийн хоёр дахь хэсэг юм. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Монгол улсын нийгмийн эмзэг бүлгүүдийн ядуурлыг бууруулах институцийн тогтолцоог бэхжүүлсэнээр амьжиргааны аюулгүй ба тогтвортой байдлыг дээшлүүлэхэд оршиж байна.

Уг төсөл нь 2008 онд эхэлсэн бөгөөд түүний үр шимийг 1763432 хүн буюу 505745 айл өрхүүд хүртээд байна: үүний 50 гаруй хувь нь эмэгтэйчүүд, 16 хувь нь амьжиргааны доод түвшингээс доогуур амьжиргаатай хүмүүс, 19 хувь нь малчид байна.

Сорилтууд: Түүхий эдийн салбарын өсөлтийн үр дүнд Монголын эдийн засаг сүүлийн хэдэн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа ч аливаа гэнэтийн хүчин зүйлд нийт эдийн засаг эмзэг хэвээр байна. 2010 оны зудаар нийт малын 20 гаруй хувь нь хорогдсон. Үүнээс өмнө 1999 ба 2001 онууд болсон ган, зудны улмаас нийт малын 30 гаруй хувь нь мөн хорогдсон.

Хэдийгээр ядуурал ерөнхийдөө буурсан боловч, өсөлтийн хүртээмж харилцан адилгүй байна. Хөдөө орон нутагт ядуурал 46,6 хувьтай байхад хот суурин газарт 26,9 хувьтай байна.

Нийгмийн салбарын үйлчилгээний хүртээмж хангалтгүй хэвээр байна. Хүртээмж хангалтгүй, боловсролын чанар сул мөн ядуурлын улмаас, хөдөөгийн хүүхдүүд сургуульд хамрагдах нь сул байна.

Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутаг дахь санхүүгийн үйлчилгээ сайжирсан хэдий ч олон тооны хөдөө орон нутгийн оршин суугчид ялангуяа малчин айл өрхүүд санхүүгийн үйлчилгээ хүртэх боломжгүй хэвээр байна. Үүнд жишээ нь зээлийн үйлчилгээ хамаарч байгаа бөгөөд энэ нь эмзэг өрхүүдийн ядуурлыг бууруулах мөн тэдэнд өөрсдийн хөрөнгийг бий болгоход тустай юм.

Төслийн үндсэн хэсэг, хандлага: Энэ төсөл нь үндсэн гурван хэсэгтэй: (1) Бэлчээрийн мал аж ахуйн Эрсдэлийн Удирдлага, (2) Олон Нийтийн Санаачлага, (3) Бичил Санхүүгийн Хөгжил.

Бэлчээрийн мал аж ахуйн Эрсдэлийн Удирдлага хэсгийн зорилго нь хөдөө орон нутгийн айл өрхүүдийг ялангуяа малчин айл өрхүүд байгаль орчны, санхүүгийн, нийгмийн болон бусад эрсдэлүүдийг даван туулах улмаар эдгээр эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх чадварыг бэхжүүлэхэд оршино.

Олон Нийтийн Санаачлага хэсгийн зорилго нь иргэдэд нийтийн эзэмшлийн жижиг байгууламжуудыг сайжруулах төслүүдийг орон нутгийн хэмжээнд тодорхойлох ба хэрэгжүүлэх эрх олгох үр бүтээлтэй, ил тод болон нийгэм рүү хандсан арга барилуудыг бий болгоход оршино.

Бичил Санхүүгийн Хөгжил зорилго нь Монголын хөдөө орон нутгийн ядуу иргэд болон эмзэг бүлгийнхэнд санхүүгийн ба байгууллагын талаас тогтвортой бичил санхүүгийн үйлчилгээг хүртэх боломжийг өргөжүүлэхэд оршино.

Үр дүн:

Бэлчээрийн менежмент

- Өвлийн бэлтгэлээ хангадаг малчин өрхийн тоо 57 хувь өссөн.
- 36,000 гаруй малчин өрхүүд бэлчээрийн менежментийн ур чадвараа дээшлүүлсэн.

### Бичил санхүү

- 2011 оны 3-р сарын байдлаар 39389 бичил зээл олгогдсон бөгөөд 181470 хүнд шууд болон шууд бусаар ашиг тусаа өгсөн байна.
- Бичил санхүү Хөгжүүлэх Сангийн тайланд зээл авсны үр дүнд зээлдэгчдийн 96 хувийн амьжиргаа нь сайжирсан гэсэн байна.

### Эрүүл мэнд

- Орон нутгийн 1088 эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулж шинэ тоног төхөөрөмж авах ажлыг нь санхүүжүүлсэн байна. Энэхүү тоног төхөөрөмжүүд нь өмнө зөвхөн аймгийн төвүүдэд байдаг байсан байна. Одоо иргэд үзлэгт орох болон эмчилгээ хийлгэхээр холын зам туулах хэрэггүй болсон байна.

### Боловсрол

- Хөдөө, орон нутагт чухал асуудал болох дотуур байранд амьдрах хүүхдүүдийн тоо 169 хувиар өссөж; сургууль завсардах явдал 82 хувиар буурч, цэцэрлэгийн бүртгүүлэлт 69 хувиар өссөн байна.

### Дэд бүтэц

- Ундны усны 68 худаг баригдсан; 13 худаг шүүлтүүрийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон; 97 худагийг сэргээн засварласан.
- Эрчим хүчний төслүүдийг мөн хэрэгжүүлсэн. Үүнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох нар ба салхийг ашиглан олон нийтийн байгууламжуудыг эрчим хүчээр хангах төслүүд орж байна

### ***“Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ” судалгааны тайлангаас***

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011 он)-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг баталсан.

Тус хөтөлбөрт “Залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн нөхцөл байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийх” талаар тусгагдсан. Энэ хүрээнд Жендэрийн үндэсний хороо Азийн Хөгжлийн Банктай хамтран “Иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” техник туслалцааны төслийн хүрээнд “Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ” хийх судалгааны ажлыг 2021 оны 3-7 дугаар сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ. Дүн шинжилгээ нь бэлчээрийн болон хагас бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг 15-34 насны эрэгтэй, эмэгтэй малчдын хөдөлмөрийн хуваарь, амьжиргаа, хэрэгцээ, мал болон бусад нөөцийн өмчлөл, эзэмшил, ашиглалт дахь жендэрийн ялгааг тодруулах,

боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээ авахад үүсэж буй хүндрэл бэрхшээл болон цаашид залуу малчдыг бэлтгэх асуудлыг тодорхойлж, гарсан үр дүнг бодлого төлөвлөлтөд тусгуулан хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

#### Судалгааны кейс 1.

Аймаг, сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаар залуу малчин гэр бүл үр хүүхдүүдээ сургуульд суулгахаар ээж нь төв суурин газарт, аав нь хөдөө малаа маллаад амьдарч байна. Ингэснээр залуу малчин ээжүүд мал аж ахуйгаасаа хөндийрөх хандлага ихсэж байгаагаас гадна үүнтэй холбоотойгоор гэр бүлийн зөрчил, үл ойлголцол бий болж гэр бүл салалтыг нэмэгдүүлэх эрсдэлийг дагуулж байна. Мөн эмэгтэйчүүд мал аж ахуйгаа эрхлэх нь багассаны улмаас нэгж малаас авах бүтээгдэхүүн үйлдвэрлэл төдий хэмжээгээр буурч байна. Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийг бодвол ямар нэгэн боловсрол эзэмших байдал илүү байдаг бөгөөд үүнээс шалтгаалан мал маллан амьдрах эмэгтэйчүүдийн тоо цөөрч байна.

*Нэг хүүхэд маань 5-р анги, дунд маань энэ жил 1-р ангид орох юм. Манай эхнэр багш мэргэжилтэй. Хүүхдүүдтэйгээ төв дээр байдаг. Би хоёр гэрийн хооронд л явж байна даа. Манай хөдөө бол эхнэрүүд хүүхдээ харна, эрчүүд малаа маллана гэсэн амьдралтай л байна. Ихэнх нь хоёр тусдаа л байна. Өвөрхангай аймаг, гэрлэсэн залуу эрэгтэй малчин.*

#### Судалгааны кейс 2.


Өрхийн орлого, мал хөрөнгөө хувааж хуваарилах (74.5 хувь) болон мал, бүтээгдэхүүн, эд зүйлээ худалдах (73.1 хувь) өрхийн шийдвэр гаргалтад эрэгтэй малчид эмэгтэйчүүдтэй харьцуулахад арай илүү оролцоотой байгаа бол харин өрхийн орлогыг зарцуулахад (77.7 хувь) эмэгтэйчүүд илүү оролцоотой байна. Гэрлэсэн залуу малчдын 80 орчим хувь нь өрхийн шийдвэр гаргалтад байнгын оролцоотой байдаг бол гэрлээгүй эцэг эхтэйгээ хамт амьдарч байгаа залуу малчдын оролцоо харьцангуй доогуур байна. Гэрлээгүй залуу малчид аав ээж, ах дүү нартайгаа мал аж ахуйн ажил үүргээ хувааж гүйцэтгэдэг боловч өрхийн шийдвэр гаргалтад эцэг эх оролцоо голлодог байна.

#### Судалгааны кейс 3.

Бэлчээрийн доройтол, даацын талаар эрэгтэй, эмэгтэй малчид харилцан адилгүй мэдээлэлтэй байгаа бөгөөд малчдыг үнэн зөв мэдээллээр хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх ажлыг малчин залуусын өөрсдийн санаачилга, оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Бэлчээрийн доройтол, хомсдол залуу малчдын дунд удаан хугацаагаар эрэгтэйчүүд дангаар буюу гэр бүлээсээ тусдаа амьдрахад

хөтөлж байна. Отрын үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн ачаалал эмэгтэйчүүдийнхээс давамгайл байна. Гэрлээгүй, бэлэвсэн, гэрлэлтээ цуцалсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү хол зайд оторлодог энэ нь нийгмийн харилцаанд оролцох, гэрлэхэд нь сөргөөр нөлөөлж, БЗДХӨөөр халдварлах эрсдэлийг өсгөж болзошгүй юм.

### Зураг 1. Жендэрийн дүн шинжилгээ хийх алхамууд



<p>Алхам 1. Асуудлыг тодорхойлох</p>	<p>Бодлогын дүн шинжилгээ хийхдээ эхлээд ихэвчлэн бодлого боловсруулах эсвэл дүн шинжилгээ хийх шаардлагатай аливаа бэрхшээлтэй асуудал, эсхүл боломжийг тодорхойлно. Энэ үе шатанд уг асуудлын мөн чанар, цар хүрээ, ач холбогдлыг өнөөгийн бодлогын орчинд нь авч үзэж, тодорхойлдог.</p>
<p>Алхам 2. Хүрэх зорилго, үр дүнгээ тодорхойлох</p>	<p>Энэ үе шатанд бодлогоор хүрэх зорилго, үр дүнг санал болгодог. Хүрэхийг зорьж буй/хүрэхийг зориогүй үр дүнг судлах замаар тухайн бодлого нь бусад бодлого, Засгийн газрын зорилтуудыг хэр дэмжиж эсхүл тэдэнд саад болж байгааг олж тогтооно. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт, мониторингийн үйл явц, үр дүнд хүрэхэд хэнтэй түншлэх болон ямар үүрэг хариуцлагатай ажиллахыг энэ үе шатанд тодорхойлдог.</p>
<p>Алхам 3. Шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг тодорхойлох</p>	<p>Энэ алхмыг ихэвчлэн судалгааны үе шатанд хэрэгжүүлдэг. Ямар мэдлэг, мэдээлэл шаардлагатай, тэдгээрийг хамгийн сайн хангах боломжтой эх сурвалжуудыг судалж, холбогдох мэдээ, мэдээллийн эх сурвалж болон мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийх түншүүдийг тодорхойлно.</p>
<p>Алхам 4. Судалгаа хийх</p>	<p>Судалгааны загвар, дүн шинжилгээний хэлбэр (тухайлбал, зардал/үр ашиг, нийгмийн нөлөө, засгийн газарт чиглэсэн харилцаа гэх мэт)-ийг энэ үе шатанд тодорхойлно. Дүн шинжилгээний зорилго, арга, мэдээ, мэдээллийг танилцуулах аргачлалыг энэ үе шатанд боловсруулдаг.</p>
<p>Алхам 5. Хувилбаруудыг боловсруулан, дүн шинжилгээ хийх</p>	<p>Хувилбарууд болон одоо хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжид үзүүлж буй нөлөө хоорондын харилцааг, тухайлбал эдийн засаг, нийгэм, тэгш байдал, олон нийт болон хүрээлэн буй орчны хүрээнд судалдаг. Хувилбар тус бүрээр нөлөөллийн дүн шинжилгээг боловсруулахын сацуу хэрэгжүүлэх үүрэг хариуцлага, шаардагдах нөөцийг тогтооно.</p>



<p>Алхам 6. Зөвлөмж боловсруулах</p>	<p>Хувилбаруудын зөвлөмжийг ихэвчлэн хамтын хүчин чармайлтаар боловсруулдаг бөгөөд заримдаа олон нийтийн санал, зөвлөмжийг тусгадаг. Хувилбаруудын дүн шинжилгээнд үндэслэн зөвлөмжүүдийн үндэслэлийг тодорхойлж, таатай, таагүй нөлөө, үр дагавар, бодлогын орчны асуудлаар зөвлөмжийг танилцуулна.</p>
<p>Алхам 7. Бодлогыг сурталчлах</p>	<p>Санал болгож буй бодлогыг сурталчлах нь түүнийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газрын зорилго, бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийн нөлөөг ойлгуулахдаа цаг хугацаа, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэллэгийг зөв сонгож, олон нийтийн оролцоог хангах нь чухал. Түншүүд болон зөвлөлдөх бүлгүүдийн оролцоог хангаж, ажиллах нь Засгийн газрын дотор төдийгүй олон нийтэд бодлогыг таниулж, сурталчлахад чухал ач холбогдолтой.</p>
<p>Алхам 8. Дүн шинжилгээний чанарыг үнэлэх</p>	<p>Энэ үе шатанд дүн шинжилгээний үйл явцыг хянаж, үнэлэх нь чухал.</p>

**4.1.6. Загвар: Барилга, хот байгуулалт, орон сууцны (БХБОС) чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл дээр жендэрийн дүн шинжилгээ хийхэд ашиглах арга, цуглуулах тоо баримт**

<b>Жишээ</b>	
Барилга, хот байгуулалт, орон сууцны (БХБОС) чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл дээр жендэрийн дүн шинжилгээ хийхэд ашиглах арга, цуглуулах тоо баримт	
<b>Хэрэглэх арга, аргачлал</b>	<p><u>Бэлэн байгаа бичиг баримт дээр үндэслэн дүн шинжилгээ хийх:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- БХБОС-ын чиглэлээр урьд хэрэгжиж байсан төслүүдийн талаарх мэдээлэл, түүнчлэн төслийн зорилтот бүлгүүдийн нийгэм-эдийн засгийн байдлын талаарх танилцуулга зэрэг материал, мэдээллийг хянаж үзэх (жишээ нь: статистикийн мэдээ, ядуурлын талаарх судалгаа, жендэрийн судалгаа, хандивлагч байгууллагуудаас санхүүжүүлсэн БХБОС-ийн өмнөх төслүүдийн бичиг баримт).</li> <li>- Холбогдох хууль эрх зүйн (гэр бүлийн тухай хууль, банк, зээлийн зохицуулалт г.м.), бодлогын (ус, хог хаягдал буюу орон сууцны төлбөрийн, татаасын тухай бодлого г.м.) болон бүтэц зохион байгуулалтын тогтолцоо (дэд бүтцийн үйлчилгээг үзүүлэхэд тухайн хот суурин газрын одоогийн засаг захиргааны тогтолцоо), жендэрийн үр дагаврыг хянаж үзэх.</li> </ul> <p><u>Өрхийн судалгаа</u> Жендэрийн ялгавартай нийгэм-эдийн засгийн бүтцийн зургийг гаргаж зорилтот хүн амын БХБОС-ны практик үйл ажиллагаанд оролцож байсан туршлага, шаардлага, хэрэгцээ болон төлбөрөө төлөх эрмэлзэлтэй эсэх зэрэг асуудлыг тодорхойлох.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тоон мэдээлэл цуглуулах</li> </ul> <p><u>Оролцооны аргачлалууд(оролцооны аргаар үнэлгээ хийх, зорилтот бүлгүүдийн хэлэлцүүлгүүд, түүвэрчилсэн ярилцлага, сонирхогч талуудтай очиж уулзах)</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Судалгаагаар цуглуулах боломжгүй чанарын мэдээллийг цуглуулах</li> <li>- Эрэгтэй, эмэгтэй төслийн үр шим хүртэгчид болон бусад сонирхогч талууд, ялангуяа ядуу эмэгтэйчүүдэд төсөлд оролцох боломжийг бий болгох арга замыг хайх</li> <li>- Зорилтот газар нутгийн зургийг гаргаж, үйлчилгээний хүртээмж ба ядуурлын түвшний хувьд хамгийн их эмзэг газрууд хаа байгааг тодорхойлох</li> <li>- Сонирхогч талуудын гол бүлгүүд болон тэдний оролцоог тодорхойлох</li> </ul>

<p><b>Цуглуулах тоо баримт</b></p>	<p><u>Макро түвшний бүтэц зохион байгуулалт, тогтолцоо</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Салбарын бодлого болон хууль эрх зүй, бүтэц зохион байгуулалтын тогтолцоонд жендэрийн үзүүлэх нөлөө</li> <li>- Хэрэгжүүлэгч агентлагийн чадавхи болон жендэрийн асуудлыг анхаарч үзэх хүсэл эрмэлзэл</li> </ul> <p><u>Нийгэм эдийн засгийн танилцуулга</u></p> <p><i>Хүн амын судалгаа:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дэд бүс, хүйс, үндэс угсаа, нас</li> <li>- Шашны байдал ба ялгаа</li> <li>- Шилжин ирж байгаа болон явж байгаа хандлага (эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд)</li> <li>- Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн эзэлж буй хувь</li> <li>- Өрхийн хэмжээ, хамаарлын харьцаа</li> <li>- Гэрлэх насыг хүйсээр ялгавартайгаар судлах</li> </ul> <p><i>Ядуурал ба хөдөлмөр эрхлэлт:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Өрхийн орлогын түвшин болон хувь хүмүүсийн орлогын эх үүсвэр, хүйсээр, насаар</li> <li>- Өрхийн зарлагын хэв маяг ба шийдвэр гаргалт, хүйсээр</li> <li>- Ядуурлын дүр зураг (ядуурлын түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын эзлэж буй хувь, орлогын хуваарилалт, ядуурлын түвшин өндөр дүүрэг, хороолол, ядуурлын шинж чанар ба шалтгаан, ядуучуудын амьжиргааг дэмжих стратеги)</li> <li>- Ядуурал ба жендэрийн харилцан хамаарал (эмэгтэйчүүд толгойлсон өрх, ядуурлын түвшин хоорондын холбоо, ядуурлын эмэгтэйчүүдэд үзүүлж буй ачаалал, үр дагавар)</li> <li>- Гэртээ ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзэлж буй хувь ба ажлын төрөл</li> <li>- Гэрээсээ гадуур ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн хувийг тогтоож, ямар ажил эрхэлж буйгаар нь судалгааг гаргах</li> <li>- Ажилгүйдлийн түвшин, хүйсээр</li> </ul> <p><i>Газар ашиглалт ба түрээс:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Түрээс болон эзэмшлийн байдал (эзэмшлийн ба түрээсийн орон сууцны харьцаа)</li> <li>- Түрээс эсвэл эзэмшлийн үндсэн дээр байгуулсан иргэдийн оролцоотой бүлгүүд</li> <li>- Орон сууц эзэмшдэг эсвэл түрээслэгчээр бүртгүүлсэн эмэгтэйчүүдийн хувь</li> <li>- Зөвшөөрөлгүй оршин суугчдын тоо ба байршил (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд)</li> <li>- Оршин сууж байгаа хугацаа</li> </ul> <p><i>Эрүүл мэнд:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүн амын өсөлтийн хувь</li> </ul>
------------------------------------	--

	<ul style="list-style-type: none"> <li>- Нярайн ба эхийн эндэгдлийн хувь (эрэгтэй, эмэгтэй)</li> <li>- Үйлчилгээний хүртээмж ба газар зүйн тархалт</li> <li>- Төрөлтийн түвшин ба шийдвэр гаргалт</li> <li>- Өрхийн хоол хүнсний хуваарилалт болон тэжээллэг байдал, хүйсээр</li> <li>- Гэр бүлийн хүчирхийлэл</li> </ul> <p><i>Боловсрол ба хүүхдүүд:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Бичиг үсэгт тайлагдалт ба сургуульд элсэгчдийн байдал, хүйсээр</li> <li>- Сургууль завсардсан хүүхдийн тооны харьцаа, хүйсээр</li> <li>- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, гэр оронгүй гудамжны хүүхдийн тоо, хүйсээр</li> </ul> <p><i>Эмэгтэйчүүдийн аж байдал/статус:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийллийн цар хүрээ</li> <li>- Улс төрд эмэгтэйчүүдийн төлөөлөл болон мэдлэг чадвар</li> <li>- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн нийгэм-соёлын ойлголт ба бодит байдал</li> <li>- Хүйсээр ялгаварлан гадуурхахын эсрэг бодлого ба хууль тогтоомжууд</li> <li>- Хууль эрх зүй, шударга ёс, тэр дундаа хүчирхийлэл, эрүүгийн гэмт хэрэг</li> </ul> <p><i>Жендэрийн үүрэг ба хариуцлага:</i></p> <p>Үйлдвэрлэл (хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хөдөлмөрийн жендэрийн хуваарь, орлого хуримтлуулах үйл ажиллагаа.) болон нөхөн үржихүй (өрхийн гэрийн ажил), хүүхэд харах, халамжлах г.м)-н үүрэг хариуцлагын жендэрийн хуваарилалт, уг ажилд зарцуулж буй цаг хугацаа</p> <p><u>БХБОС-ны дэд бүтэц ба үйлчилгээний хүртээмж(ус хангамж, бохир ус ба хатуу хог хаягдлын менежмент, зам, цахилгаан, орон сууцны хүртээмж, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, нийтийн гэрэлтүүлэг, тээвэр г.м.)</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлчилгээг хэн үзүүлдэг вэ? (орон нутгийн засаг захиргаа, ТББ, хувийн хэвшил г.м.)</li> <li>- Өрхүүдийн хэдэн хувь нь дээрхи үйлчилгээнүүдэд хамрагдах боломжтой вэ?</li> <li>- Үйлчилгээнд хамрагдахад хүйсийн ялгаварлал бий эсэх</li> </ul> <p><i>Үйлчилгээний чанар, үйлчилгээний төрөл тус бүрээр:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлчилгээ нь тогтмол эсэх</li> <li>- Үйлчилгээний хүртээмж, тоо буюу чанар нь улирлын байдлаас шалтгаалдаг эсэх</li> <li>- Үйлчилгээнд сэтгэл ханамжтай эсэх</li> </ul>
--	--

	<p><i>Үйлчилгээний өртөг, хэлбэр болон хэрэглэгчдийн төлбөрийн чадвар:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлчилгээний төлбөр</li> <li>- Төлбөрийг хэн (өрхийн эрэгтэй гишүүн үү эсхүл эмэгтэй нь) хэнд (хэрэглэгчдийн хооронд, орон нутгийн засаг захиргаанд, хувийн компанид г.м. ) төлдөг вэ?</li> <li>- Үйлчилгээний хөлс ямар байна вэ? Төлбөрийн хэмжээ бодитой эсэх, хүмүүс төлөх боломжтой эсэх</li> <li>- Үйлчилгээний чанар сайжрахад хүмүүс төлбөрөө төлөх сонирхол нь хэр зэрэг нэмэгдэх бол?</li> </ul> <p><i>Хувийн болон хувь хүмүүсийн, эсхүл хууль бусаар хүртэж буй үйлчилгээ:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Усан хангамж: Албан ёсны үйлчилгээнээс гадна усны өөр ямар эх үүсвэр байдаг вэ (дундын булаг шанд, горхи, гол, усан сан, хувийн усан сан, дундын худаг г.м)? эдгээр нь хэр зэрэг хол байрладаг вэ? Усыг хэн (эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд) хэрхэн зөөвөрлөх, тээвэрлэх, хадгалдаг вэ? Үүнд ямар хугацаа зарцуулагддаг вэ?</li> <li>- Хог хаягдлыг зайлуулах: хатуу хог болон бохир усыг зайлуулах талаар авч буй арга хэмжээ? Үүнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ямар үүрэг гүйцэтгэх вэ?</li> <li>- Цахилгаан: Хууль бусаар цахилгаан ашиглаж байгаа эсэх? Ямар аргаар?</li> </ul> <p><i>БХБОС-ны менежмент, жендэрийн хөдөлмөрийн хуваарь:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн өрхийн эрэгтэй эсхүл эмэгтэйн хэн нь БХБОС-ийг удирдан зохион байгуулахад оролцдог вэ?</li> <li>- Тухайн өрхөд хэн нь (эрэгтэй/эмэгтэй) ус, цахилгаан ба орон сууцны ашиглалт болон хуваарилалтын талаар шийдвэр гаргадаг вэ?</li> </ul> <p><i>Эрүүл ахуй ба Байгаль орчны талаарх мэдлэг, хандлага, дадал:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл ахуй ба байгаль орчны талаарх боловсрол: Эрүүл ахуй болон байгаль орчны талаар гэр бүл, сургууль болон орон нутгийн иргэдэд сургалт, сурталчилгааны ажил явуулдаг эсэх?</li> <li>- Мэдээлэл түгээх нийтийг хамарсан өргөн хүрээтэй ямар ажил зохиогддог вэ?</li> <li>- Эмэгтэйчүүд,эрэгтэйчүүд асуудлыг хэрхэн ойлгож хүлээж авч байгаа вэ?</li> </ul> <p><i>Эрүүл ахуй, ариун цэвэр сахиулах арга хэмжээнүүд:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрэгтэй, эмэгтэй хүмүүст зориулж бие засах газрын асуудлыг шийдсэн эсэх</li> <li>- Хувийн нууцыг хэрхэн хамгаалдаг вэ? Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хооронд болон гэр бүлийн гишүүдийн дундын ариун цэврийн газрыг ашиглахад ямар нэгэн буруу ташаа ойлголт байдаг эсэх.</li> </ul>
--	---

	<ul style="list-style-type: none"> <li>- Хатуу хогийн хаягдлыг хэн цуглуулж хаядаг вэ?</li> <li>- Хогийг дахин боловсруулдаг эсэх. Хогийг хэн цуглуулдаг вэ (нийтээрээ, жижиг дунд боловсруулах үйлдвэр г.м.).</li> </ul> <p><u>Нөөц эх үүсвэр, үйлчилгээний хүртээмж ба хяналтад гардаг хүндрэл бэрхшээлүүд - (БХБОС -ны бус асуултууд):</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэлийн нөөц эх үүсвэр болон үйлчилгээний хүртээмж</li> <li>- Ажлын байртай болох, орлогоо нэмэгдүүлэх боломж, зээл авах ба зах зээлд хүрэх боломжоороо эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хооронд ямар ялгаа байна вэ?</li> <li>- Үйлчилгээний хүртээмж буюу хяналтыг сайжруулахад гадны ямар нэг нөлөө бий эсэх. Тийм бол хэн нөлөөлж байгаа вэ?</li> <li>- Нийгмийн үйлчилгээний боломж ба хүртээмж (эрүүл мэнд ба эрүүл ахуйн асуудлууд, бичиг үсэг тайлагдах хөтөлбөр): гадны тусламж буй эсэх?</li> </ul> <p><u>Хэрэгцээ, эн тэргүүний асуудал ба хүлээгдэж буй үр дүн:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэрэгцээ: Одоогийн нөхцөл нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, өндөр настнууд болон хүүхдүүдийн эрэлт хэрэгцээг хангаж чадаж буй эсэх? Ямар хэрэгцээ байна вэ? Эдгээр ялгаатай байдлын шалтгаан нь юу вэ?</li> <li>- Нэн тэргүүний асуудал: БХБОС-ны төрөл бүрийн үйлчилгээнүүдийн алинд нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд илүү их ач холбогдол өгч байгаа вэ? Ялгаатай хандаж байгаагийн шалтгаан юу вэ?</li> <li>- Төслөөс хүлээгдэж буй үр дүн, хүйсээр: Дараахи асуудлууд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд хэрхэн ялгаатай тусч байна вэ? Үүнд: Цаашдын төлөвлөлт, төсөл боловсруулах болон хяналт үнэлгээнд оролцох оролцоо. Барилга, хог хаягдал цуглуулах болон дахин боловсруулалт хийдэг аж ахуйн нэгж, барилгын материалын үйлдвэр, төслийн газруудад ажиллах боломж. Эдгээр үйл ажиллагаанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн хуваарилалт хэрхэн хийгдсэн бэ? Орон сууцны хөгжил ба жижиг дунд үйлдвэр болон орлого хуримтлуулах бусад үйл ажиллагаанд зориулсан зээл.</li> <li>- Төсөлд өөрсдийн хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзэл, хүйсээр: эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хоорондын ялгаа дараахи үйл ажиллагаан дээр харагддаг:             <ul style="list-style-type: none"> <li>○ Барилга, нягтлан бодох бүртгэл, бараа материал нийлүүлэлт, хоол хүнс бэлтгэл, байнгын засвар үйлчилгээ г.м. хөдөлмөр эрхлэлт дээр.</li> <li>○ Бага хэмжээний газрыг ашиглах, орон нутгийн нөөц боломжийг ашиглах зэрэг дээр харагддаг.</li> </ul> </li> </ul> <p><u>Төслийн үр нөлөө</u></p>
--	---

<p>Жендэрийн ялгавартай нөлөө:</p> <ul style="list-style-type: none"><li>- Төслийн үр дүнд гарч болох сайн үр нөлөө болон сөрөг үр дагавар? Энэ нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд хэрхэн ялгаатай тусах вэ? Жишээ нь: гэрээрээ аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй эмэгтэйчүүдэд “Бүсэд хуваах журам” сөргөөр нөлөөлж болох эсэх.</li><li>- Төслийн үр ашгийг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд адил тэгш хүртэж чадаж байна уу?</li><li>- Сөрөг үр нөлөөг хэрхэн бууруулах вэ?</li></ul> <p>Нийгмийн эмзэг бүлгүүд:</p> <ul style="list-style-type: none"><li>- Нийгмийн ямар эмзэг бүлгүүд байна вэ?</li><li>- Тэд хэн бэ? Хаана амьдардаг вэ? Тэдний нийгэм-эдийн засгийн байдал?</li><li>- Төсөл эдгээр бүлгүүдэд хэрхэн нөлөөлөх вэ?</li></ul> <p><u>Нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөх:</u></p> <ul style="list-style-type: none"><li>- Газар худалдан авах эсхүл нүүн суурьших гэж буй эсэх. Хэр их эрчимтэй?</li><li>- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд үзүүлэх нөлөө нь юу байх вэ?</li><li>- Эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд нүүлгэн суурьшуулах газрын талаар өөр саналтай эсэх.</li><li>- Эмэгтэйчүүд толгойлсон ядуу өрхүүдэд нэмэлт дэмжлэг шаардлагатай эсэх.</li></ul> <p><u>Хөршийн холбоо/Олон нийт</u></p> <ul style="list-style-type: none"><li>- Үндсэн асуудал: Ойролцоо газарт нь нягт уялдаа холбоотой орон нутгийнхан бий эсэх? Түүний зохион байгуулалтын үндэс суурь юу вэ?</li><li>- Ард иргэд суурьшаад хэдэн жил болж байгаа вэ?</li><li>- БХБОС-ны тодорхой үйлчилгээ хүргэхэд олон нийтийн оролцоо чухал гэдэгт төслийн үр шимийг хүртэгч эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд итгэж байгаа эсэх? Яагаад?</li></ul> <p><u>БХБОС-ны үйлчилгээг хэрэглэх талаарх олон нийтийн бүлгүүдийн хоорондын зөрчлүүд</u></p> <p>Нийтийн аж ахуйн үйлчилгээ (ус түгээлт г.м.)-ний түгээлт буюу түүний менежментийн үүрэг хариуцлагын хуваарилалт (хог цуглуулах үүрэг г.м.)-ын талаар олон нийтийн бүлгүүдийн дотор ямар нэг зөрчил бий эсэх. Хэрэв байгаа бол эдгээр зөрчил нь жендэрийн ялгаа, орлогын түвшний ялгаа, яс үндэстэн буюу кастын ялгаанаас хамаарч байна уу? Эдгээр зөрчлийг хэрхэн шийдвэрлэх вэ? Зөрчлийг шийдвэрлэхэд эмэгтэйчүүд оролцдог эсэх?</p> <p><u>Оролцоо</u></p> <p>Оролцооны хүчин зүйлс: Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлс юу вэ? Ямар хөшүүрэг, ямар бэрхшээл байдаг вэ?</p> <p>Хэлбэр: Төслийн үйл ажиллагаанд оролцох ямар хэлбэрийг эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд илүүд үздэг вэ? (Тухайлбал:</p>
---



	<p>төлөвлөлтийн шатанд гаргадаг шийдвэр, дэд бүтцийн талаар санал боловсруулах, бэлэн мөнгө хандивлах, барилгын ажил, сургалт, үйл ажиллагаа ба засвар үйлчилгээ, санхүүгийн удирдлагын зохион байгуулалт, зохион байгуулалтын менежмент г.м.). Яагаад?</p> <p><u>Олон нийтэд түшиглэсэн байгууллагуудад /ОНТБ/ ба ТББ</u></p> <ul style="list-style-type: none"><li>- Түрээслэгчдийн холбоо, эд хөрөнгө эзэмшигчдийн холбоо, ус хэрэглэгчдийн бүлгүүд эсхүл хог хаягдлын менежментийн хөршүүдийн холбоо зэрэг албан ёсны, албан бус ОНТБ бий эсэх? Тэд ямар үүрэгтэй байдаг вэ? Тэд төслийн үйл ажиллагаанд оролцоход тохиромжтой эсэх.</li><li>- Эдгээр бүлгүүдэд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалттай байгаа эсэх.</li><li>- Ядуурлыг бууруулах, эмэгтэйчүүдийн санаачлагыг дэмждэг олон улсын буюу үндэсний ТББ байдаг эсэх. Төсөл бидэнтэй хэрхэн холбогдож болох вэ?</li><li>- Төслийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийг идэвхитэй оролцуулахын тулд ямар механизмыг ашиглаж болох вэ?</li><li>- Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийг дайчилж сургахад ямар байгууллагатай хамтран ажиллаж болох вэ?</li></ul>
--	--



### **Хичээл 5: Жендэрийн үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт ба хэрэгжилтэд тусгах**

Хичээлийн төлөвлөгөө

Зорилт: Сургагч багш нар жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд хэрхэн тусгадаг талаар ойлголттой болох ба түүний үе шат тус бүр дээр юуг анхаарах тал дээр мэдлэгтэй болох

Хэрэглэгдэхүүн:

- Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь, сургагч багшийн гарын авлага, 2014
- Жендэр ба бодлого төлөвлөлт, модуль сургалт, ЖҮХ, 2018
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт баримтлах жендэрийн бодлого
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт баримтлах жендэрийн бодлогын хэрэгжилтийн үнэлгээний тайлан (эхний үе шат 2018-2021)
- Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал

## ЖЕНДЭР БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/, ЖҮХ

Хугацаа: 90 мин

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Хугацаа /минут/	Хичээлийг чиглүүлэх алхам	Аргачлал
20 мин	Мэдлэг олгох: <ul style="list-style-type: none"> <li>▪ Жендэрийн үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгахын ач холбогдлыг ойлгуулах</li> <li>▪ Жендэрийн үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах үе шатыг зургаар үзүүлэн товч тайлбар хийх</li> </ul>	Мэдээлэл Сайн туршлага
30 мин	Мэдлэг олгох: <ul style="list-style-type: none"> <li>▪ Жендэрийн хууль болон бусад бодлогын хэрэгжилтийн үнэлгээний дараа хийвэл зохих ёстой зүйлийн нэг буюу Жендэрийн нөлөөлөл хэрхэн хийх тухай мэдээлэл өгнө</li> </ul>	Мэдээлэл Ярилцлага
30 мин	Мэдлэг бататгах: <ul style="list-style-type: none"> <li>▪ Хоёр багт хуваагдана</li> <li>▪ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний “уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход жендэрийн тэгш оролцоог хангана” гэсэн 5 дугаар зорилгыг тараана</li> <li>▪ Багууд тараасан материалыг уншиж төлөвлөгөөнд тусгасан ажлын үйл явц, үр дүн өөрийн амьдарч буй орон нутагт ямар байгаа тухай хоорондоо ярилцана</li> <li>▪ 5-р зорилгын хүрээнд хэрэгжээгүй, биелэгдээгүй асуудлыг сонгон авч асуудлыг шийдүүлэхийн тулд орон нутгийн удирдлагад хандсан сошиал сувгаар түгээх нөлөөллийн зурагт хуудас хийх</li> </ul>	Багаар ажиллах Үзүүлэн материал ашиглах Оюуны дайралт
10 мин	Дүгнэх хэсэг: Жендэрийн үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах хичээлийн дүгнэлтийг хийх	Жишээ

Мэдлэг олгох хэсэгтэй холбоотой унших нэмэлт мэдээлэл:

**Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах (Gender mainstreaming)** гэдэг нь бүх хүрээ, бүх түвшний аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны, түүний дотор хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээ болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарах үйл явц, стратеги юм.

*Жендэрийн үзэл баримтлалыг бодлого, үйл ажиллагаанд тусгах гэдэг нь НҮБ-ын тодорхойлсноор “Хууль, бодлого, хөтөлбөр зэрэг аливаа төлөвлөгөөт үйл ажиллагаанаас эмэгтэй болон эрэгтэй хүмүүст гарах үр нөлөөг бүх салбарт болон бүх түвшинд үнэлэх үйл явц юм. Энэ нь эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн санаа зовниж буй асуудал болон тэдний амьдралын туршлагыг бодлого, хөтөлбөрийн загварчлал, хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд тусгах стратеги юм. Ингэснээр эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд үр шимийг адил тэгш хүртэж, тэгш бус байдлыг бий болгохгүй байх зорилгыг агуулдаг.” (ECOSOC, 1997).*

Жендэрийн үзэл баримтлалыг бодлогод тусгах гэдэг нь цогц стратеги болохынхоо хувьд бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх орчныг өөрчлөх асуудлыг хамардаг. Иймээс тус стратеги нь түүний хэрэгжих орчинг жендэрийн мэдрэмжтэй, эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдэд тэгш боломж олгох, ижил тэгш хандсан байлгах стратегитай хамт хэрэгжих ёстой. Түүнчлэн жендэрийн үзэл баримтлалыг бодлого, үйл ажиллагаанд бүрэн тусгахын тулд хангалттай техник арга зүйн чадавхи, шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх ёстой. Түүнчлэн зөвхөн нийгмийн шударга ёсны асуудал болоод зогсохгүй хамгийн үр ашиг, үр дүнтэй арга замаар хүний хөгжлийг тэгш шударгаар, тогтвортойгоор хангах шаардлагатайг ч харуулж байгаа юм.

Төсөл, хөтөлбөрүүдэд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг яагаад тусгах шаардлагатайг дараах зургаан үндэслэлээр тайлбарлаж болно. Үүнд:

- Нийгмийн шударга ёс, тэгш байдал
- Хүлээн зөвшөөрөгдөхүйц, хариуцлагатай байдал
- Үр ашигтай байдал, тогтвортой үргэлжлэх чадвар /макро түвшинд/
- Амьдралын чанар /микро түвшинд/
- Олон талт хамтын түншлэл
- “Гинжин урвал”, түүний үр нөлөө

Нийгмийн шударга ёс, тэгш байдлын тайлбар: Энэ нь жендэрийн эрх тэгш байдлын үр дагавар болох ардчиллын зарчим, хүний үндсэн эрхүүдийг илүү чухалчилж авч үздэг. Нийгмийн шударга ёсны тайлбар нь хүний эрхийн нийтлэг зарчимд үндэслэн өөр өөр нөхцөл байдалд хоёр хүйсийн тэгш төлөөлөл, тэгш оролцоо байх ёстой гэж тайлбарладаг.

Ихэнх улс орон жендэрийн эрх тэгш байдлыг суурь зарчмаа болгон авч үзсэн Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци, Бээжингийн, Копенгагены болон Кайрийн олон улсын бага хурлаас гаргасан олон улсын стандарт баримт бичгүүдэд нэгдэн орсон байдаг. ба үүнийг үндэсний хууль, тогтоомжиндоо үндсэн зарчим болгон хэрэглэх үүргийг хүлээдэг. Энэ үндэслэл нь нийгмийн шударга ёс, хүний хөгжлийг тогтвортой хангахад Засгийн газрын хүлээх үүргийг сануулж байдгаараа онцлогтой.

Хүлээн зөвшөөрөгдөхүйц, хариуцлагатай байдал: Хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлын тайлбар нь шийдвэр гаргагчдаас “тооны хувьд” тэнцвэртэй байдлыг хангахыг шаарддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хүн амын тал хувийг эзэлдэг учраас жендэрийн тэгш байдлыг авч үзээгүй аливаа тоо баримт, бодлого, зөвлөмж нь учир дутагдалтай бөгөөд энэ нь хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлыг бууруулдаг гэж үздэг. Энэ тайлбар нь жендэрийн үр нөлөөний үнэлгээг хийх үндэслэл гаргахад /тухайн үйл ажиллагаа, нөхцөл байдлын хүчин зүйлс нь эрэгтэй, эмэгтэйчүүдэд хэрхэн ялгаатай нөлөөлж байсныг судлах судалгаанууд/ болон шийдвэр гаргахад жендэрийн тэнцвэртэй байдлыг хангахыг уриалахад хэрэгтэй байдаг.

Үр ашигтай байдал, тогтвортой үргэлжлэх чадвар /макро түвшний хэмжигдэхүүн/: Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хөгжлийн бүхий л үйл явцад тэгш оролцуулах нь улс оронд үр өгөөжөө өгнө гэдгийг хөдөлшгүй нотолгоогоор гаргаж ирдэг. Үр ашигтай байдлын тайлбартай салшгүй холбоотой өөр нэг тайлбар нь тогтвортой байдлыг хангах явдал юм. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал нь “хүний хөгжил”-ийн үзэл баримтлалд суурилдаг ба энэ нь урт хугацаанд нийгмийг илүү шударга, тогтвортой байлгах зорилготой. Жендэрийн үзэл баримтлалыг бодлогод тусгах нь өөрөө тогтвортой байдлыг хангах нэг арга болдог. Энэ нь бодлого боловсруулахад цогц байдлаар хандахыг шаарддаг ба ингэснээр хамтын ажиллагаа, уялдаа зохицуулалт сайжирч, тухайн арга хэмжээ илүү тогтвортой үргэлжлэх чадвартай болдог.

Амьдралын чанарыг сайжруулах тайлбар: Жендэрийн эрх тэгш байдалд анхаарлаа хандуулснаар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алины амьдрал сайжирна. Хэдийгээр жендэрийн тэгш байдалд анхаарлаа хандуулах нь эмэгтэйчүүдэд илүү ашигтай гэж үздэг боловч амьдралын чанарыг сайжруулах тайлбар нь эрэгтэйчүүдэд болон гэр бүлд тусах үр нөлөөг илүү тод харуулдаг. Энэ нь нийгмийн харилцааны ач холбогдол, нийгмийн гишүүдийн харилцан хамааралтай байдлыг чухалчилж өгдөг. Жишээ нь:

эмэгтэйчүүдийг чадваржуулахад түүний эргэн тойрны хүмүүсийн чадавхи ч мөн дээшилнэ. Харин аль нэг хүйсийн тэгш бус байдал, хүндрэл бэрхшээл нь нийгмийн бусад гишүүдэд мөн сөргөөр нөлөөлдөг. Жишээ нь: эрэгтэйчүүдийн сэтгэл гутрал, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжгүй байдал нь гэр бүл, хүүхэд, эхнэр, нөхрүүдэд аль алинд нь нөлөөлдөг.

Олон талт хамтын түншлэл: Энэ тайлбар нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлаар бусад улс орнуудтай хамтран ажиллах, харилцан түншлэх суурь болдог гэж үздэг. Зүүн болон Төв Европын улс орнуудын хувьд Европын Холбооны жишээг авч үзэж болно. Европын Холбоонд элсэх хүсэлт гаргасан улс орнууд нь гишүүн болохын тулд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

“Гинжин” урвал, түүний үр нөлөө: Дээрх бүх тайлбаруудын хоорондын уялдаа холбоог гаргаж өгсөн тохиолдолд үр нөлөө нь нэмэгддэг. Жендэрийн тэгш байдал нь маш олон “гинжин хэлхээс” бүхий үр ашгуудыг авчирдаг. Түүнчлэн жендэрийн тэгш байдал нь хувь хүнээс гэр бүл, олон нийт рүү дамжин нөлөөлж байдаг. Гинжин үр дагаврын тайлбар нь богино хугацааны үр дүнг авчрахаас гадна нийгэмд болон улс үндэстнийг бэхжүүлэх дунд болон урт хугацааны үр ашгийг давхар авчирдаг.

Үүний зэрэгцээ жендэрийн тэгш байдлыг хангах үйл явцад сөрөг гинжин үр дагаврууд гарах магадлалтайг санаж байх хэрэгтэй. Жишээ нь, гэр бүлд ээлтэй ажлын байрыг бий болгохыг “дээрээс” шууд шаардах нь эмэгтэйчүүдийн ажлын байран дахь дарамтыг улам нэмэгдүүлж болно. Үүнтэй адилаар эмэгтэйчүүдийг чадваржуулах үйл ажиллагаа нь эрэгтэйчүүдийн дунд сэтгэл гутрал, сөрөг зан үйлийн асуудлуудыг нэмэгдүүлж болно. Иймээс жендэрийн үзэл баримтлалыг бодлогод тусгахдаа бие биенээ харилцан дэмжсэн, цогц стратегийг бий болгох шаардлагатай байдаг.

### ***Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах үе шат***


Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь өөрөө зорилго бус, харин жендэрийн тэгш байдалд хүрэх арга зам юм.

Жендэрийн тэгш байдлыг дэмжих тусгай арга хэмжээ нь зөвхөн эмэгтэйчүүдэд, эсвэл эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хэн хэнд нь, эсвэл зөвхөн эрчүүдэд чиглэсэн байж болно. Энэ хоёр стратегийн хооронд зөрчил байхгүй бөгөөд харин ч жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгахад тодорхой зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээ зайлшгүй шаардлагатай.

Жендэрийн дүн шинжилгээнд суурилсан, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үйл бодлого төлөвлөлт, ажиллагаанд тусгах стратегийг дараах нөхцөл байдалд хэрэглэнэ. Үүнд:

- Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ба чадавхи бүрдүүлэх үйл ажиллагаанд;
- Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээний үе шатуудыг болон бодлого хөтөлбөрийн эмэгтэй эрэгтэй хүмүүст нөлөөлөх байдлыг анхааран тооцоход;
- Хүний болон санхүүгийн нөөцийг зөв зохистой хуваарилан байршуулахад;
- Эмэгтэй эрэгтэй хүмүүсийг бүх хүрээ, бүх түвшний шийдвэр гаргах үйл явцад оролцуулахад;
- Жендэрийн үзэл баримтлал яаж, хэдий хэмжээгээр, хэр үр дүнтэй тусгагдсаныг үнэлэхэд хэрэглэх мониторингийн арга хэрэгсэл, механизмыг бий болгоход.

**Зураг 1. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах үе шат**





Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах үе шатуудад юу хийх вэ?

Үе шат 1: Жендэрийн дүн шинжилгээ хийх

Энэ үе шатанд жендэрийн гол асуудал нь юу байна вэ? гэдгийг тодорхойлох үүднээс жендэрийн нөхцөл байдлыг судалж, тоон болон чанарын мэдээлэл цуглуулна.

Жишээ 1: МОНЭС нь Импакт төслийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт баримтлах жендэрийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх судалгаа хийсэн байна.

Үе шат 2: Бодлогын зорилтоо тодорхойлох

Жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын баримт бичиг боловсруулж, бодлого, хөтөлбөрийн зорилго, зорилтоо тодорхойлно.

*Бодлогын бичиг баримтад жендэрийн асуудлыг тусгасан эсэхийг шалгах түлхүүр асуултууд:*

- *Үндэслэл:* Арга хэмжээний талаархи үндсэн мэдээллийг өгөхдөө жендэрийн олон талт асуудлыг тодорхой тусгасан уу? Үндэслэл хэсэг нь жендэрийн асуудлыг бодлогод тусгах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх хангалттай үндэслэл болж чадах уу?
- *Зорилго:* Санал болгож буй үйл ажиллагаа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай онцлог хэрэгцээг тусгаж чадсан уу? Үйл ажиллагааны зорилго нь тэдний практик хэрэгцээг хангах замаар жендэрийн ялгаатай байдлыг засаж залруулахад чиглэгдсэн үү? Жендэрийн тэгш бус байдлыг өөгшүүлж буй тогтолцоог өөрчлөхөд чиглэсэн үү?
- *Зорилтот бүлэг:* Үр шимийг хүртэгсдийн дунд жендэрийн тэнцвэрийг хангасан уу,
- *Зорилтууд:* Үйл ажиллагааны зорилтууд нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн аль алиных нь хэрэгцээг хангаж чадаж байна уу?

Жишээ 2:

Бодлогын зорилго: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт үнэлгээгээр дэмжинэ.

Бодлогын зорилт, хүрэх үр дүн

№	Зорилт	Хүрэх үр дүн
1	Салбарын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг дэмжих жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлэх	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээг жендэрийн мэдрэмжтэй хийх арга хэрэгсэл, мэдлэг чадавхи бүрдэж, жендэрийн тэгш байдлыг хангах тогтолцоо хөгжинө.
2	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжин жендэрийн тэгш оролцоо, тэгш хариуцлагыг бүх түвшинд нэмэгдүүлэх	Салбарын ажиллагсдын ажлын орчин нөхцөл, тэдэнд чиглэсэн төрийн үйлчилгээ ба хүний нөөц бэлтгэх тогтолцооны жендэрийн мэдрэмж сайжирч, эмэгтэй, эрэгтэй хүмүүс салбарын хөгжилд хувь нэмэр оруулах боломж, чадавхи сайжирна.
3	Үндэсний ба олон улсын түвшин дэх жендэрийн түншлэл, хамтын ажиллагаагаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих	ХХААХҮ-ийн салбарт тулгамдаж буй жендэрийн асуудлыг шийдэх салбар дундын зохицуулалт, түншлэл хамтын ажиллагаа үндэсний 7 болон орон нутгийн түвшинд сайжирч, олон улсын түвшинд салбарын жендэрийн асуудлаар манлайлан ажиллах чадавхи бүрдэнэ.

Үе шат 3: Төлөвлөлт хийх

Бодлого, хөтөлбөрийн төлөвлөгөөнд жендэрийн асуудлыг тусгасан эсэхийг шалгах түлхүүр асуултууд:

- *Үйл ажиллагаа:* Төлөвлөгдсөн үйл ажиллагаанууд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн аль алиныг нь оролцуулах уу? Жендэрийн тэгш байдлыг хангахын тулд ямар нэг нэмэлт үйл ажиллагаа төлөвлөх шаардлагатай юу? Жишээ нь: жендэрийн асуудлаар сургалт, нэмэлт судалгаа хийх гэх мэт
- *Шалгуур үзүүлэлтүүд:* Зорилт тус бүрийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан уу? Эдгээр нь зорилт тус бүрийг жендэрийн тэгш байдлын үүднээс хэмжиж чадаж байна уу? Шалгуур үзүүлэлтүүд нь жендэрийн ялгаатай байна уу? Зорилтууд нь үйл ажиллагаан дахь жендэрийн тэнцвэртэй байдлыг баталгаажуулж чадах уу? Жишээ нь: эрэгтэй, эмэгтэй оролцогчдод квот тогтоох гэх мэт

Жишээ 3:

Зорилт 1: Салбарын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг дэмжих жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлэх		
Үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд
1.2. ХХААХҮ-ийн салбарын бодлого төлөвлөлтөд жендэрийн дүн шинжилгээ, жендэрийн үнэлгээ, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх;	<p>1. Хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийн төсөлд жендэрийн үнэлгээ хийх аргачлалыг ХХААХҮ-ийн салбарт нэвтрүүлж хэрэглэх</p> <p>2. Бэлчээрийн тухай хуулийн төсөлд жендэрийн үр нөлөөний үнэлгээ хийх</p> <p>3. ЖДҮ болон мал аж ахуй, газар тариалангийн ерхийн үйлдвэрлэлийг дэмжих бодлого, үйл ажиллагаанд жендэрийн дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, шийдвэр гаргагчдад зөвлөмж хүргүүлэх</p> <p>4. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, ЖДҮ-ийг дэмжих сангийн төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийж жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх боломжийг тодорхойлох</p> <p>5. Дэд салбар бүрт сонгогдсон байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хэрэглэгчдээс авах жендэрийн мэдрэмжтэй судалгаа хийх, үр дүнг шинжлэх, тайлагнах</p> <p>6. Салбарын бүтээгдэхүүн үйлчилгээнд мөн ядуурлын эсрэг, нийгмийн оролцоот ногоон хөгжлийн хандлагыг нэвтрүүлэх бодлогын арга хэмжээг тодорхойлох хэлэлцүүлэг хийх</p>	<p>- Жендэрийн үнэлгээ хийгдсэн хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн төслийн тоо</p> <p>- Бэлчээрийн тухай хуулийн төсөлд хийсэн жендэрийн үр нөлөөний үнэлгээний тайлан, зөвлөмж</p> <p>- ЖДҮ-г дэмжих бодлого, үйл ажиллагаанд хийсэн жендэрийн дүн шинжилгээний тайлан</p> <p>- Тариалан эрхлэлтийг дэмжих сан, ЖДҮ-ийг дэмжих сангийн төсөвт хийсэн жендэрийн дүн шинжилгээний тайлан</p> <p>- Хэрэглэгчдээс судалгаа авч, үр дүнг хүйс, бусад үзүүлэлтээр ангилан шинжилсэн байгууллагын тоо, хамрагдсан хэрэглэгчдийн тоо</p> <p>- Салбарын бүтээгдэхүүн үйлчилгээнд мөн ядуурлын эсрэг, нийгмийн оролцоот ногоон хөгжлийн хандлагыг нэвтрүүлэх бодлогын арга хэмжээг тодорхойлох хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, байгууллагаар</p>

Үе шат 4: Хэрэгжүүлэх

Хэрэгжүүлэх үе шатанд төсөвлөсөн бодлогоос жендэрийн тэгш байдлыг хангах баталгаа, нотолгоотой дүн шинжилгээ хийсэн, зорилго, зорилт нь тодорхой, цаг хугацаа, нөөцийг зөв тооцоолсон бодлого, хөтөлбөрийг сонгох. Хэрэгжүүлэхэд жендэрийн асуудлыг тусгасан эсэхийг шалгах түлхүүр асуултууд:

- Төлөвлөгдсөн арга хэмжээг хэн хэрэгжүүлэх вэ? Эдгээр түншлэгч талууд нь хэрэгжилтийн бүхий л явцад жендэрийн асуудлыг байнга тусгаж байхын тулд энэ чиглэлээр сургалтанд хамрагдсан уу? Эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид, хөвгүүдийн аль аль нь хэрэгжилтэнд оролцох уу?

Жишээ 4:

Бодлогын хэрэгжилтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дахь Жендэрийн Үндэсний Хорооны салбар зөвлөл удирдан зохион байгуулна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бодлогын хэрэгжилтэнд байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хяналт-шинжилгээний дүнг Жендэрийн салбар зөвлөл хэлэлцэн, салбарын холбогдох бодлого төлөвлөлт, төсөвлөлт, үйл ажиллагаанд тусгана.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу бодлогын хэрэгжилтийг Жендэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 02 дугаар сарын 20-нд багтаан тайлагнана. Бодлогын эхний үе шатны хэрэгжилтийн үр дүнг 2022 оны эхний улиралд багтаан үнэлж, хоёрдугаар шатанд авах арга хэмжээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргана.

Үе шат 5: Хяналт, шинжилгээ хийх

Бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тавих хяналт нь төсөвлөлтэй холбоотойгоор санхүүгийн хөрөнгө нөөц, тэдгээрийн үр шимийг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд адил тэгш хүртэхүйцээр төлөвлөж чадсан уу? Жендэрийн сургалт, эсхүл богино хугацааны жендэрийн зөвлөх ажиллуулах зардлууд төсөвт тусгагдсан уу?

Жишээ 5:

Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр нарийвчлан гаргаж, голлон хэрэгжүүлэгч болон оролцогч талуудыг тодорхойлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх олон улсын болон бусад байгууллагуудын салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл,

хөтөлбөр, дэмжлэгийнхээ хоёроос доошгүй хувийг тус бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлнэ.

Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө
- Хандивлагч улс, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгө
- Хувийн хэвшлийн хандив, тусламжийн хөрөнгө
- Бусад

#### Үе шат 6: Үнэлгээ хийх

Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд үнэлгээ хийхдээ бодлогодоо жендэрийн асуудлыг тусгасан эсэхийг шалгах түлхүүр асуултууд:

- Нийгэмд оршин буй жендэрийн үүрэг, харилцааны асуудал эрсдэлд тооцогдох уу? Жишээ нь: аль нэг хүйсийн бүрэн оролцоог хангахад саад болж буй хэвшмэл ойлголтууд болон бүтэц, зохион байгуулалтын саад бэрхшээлүүд
- Тухайн арга хэмжээний гарч болзошгүй сөрөг үр нөлөөг тооцоолсон уу? Эмэгтэйчүүдийн ачааллыг нэмэгдүүлэх, эрэгтэйчүүдийг нийгмээс тусгаарлагдмал болгох гэх мэт.
- Хавсралтанд холбогдох судалгааны тайлангууд байна уу? Ялангуяа жендэрийн асуудалд яагаад анхаарах шаардлагатайг нотолсон нотолгоо болохуйц гэх мэт
- Бодлого, хөтөлбөр, түүний үр дүн, ахиц дэвшлийг жендэрийн нүдээр олон нийтэд тайлбарлах мэдээлэл харилцааны арга зам, сувгийг зөв тодорхойлсон уу?

#### Жишээ 6:

2022 оны байдлаар Монгол Улсын 21 аймаг жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрөө боловсруулан, хэрэгжүүлж байна. Судалгааны баг үнэлгээний зорилтот аймаг болох Архангай, Хэнтий аймгийн 2020 онд батлагдсан дэд хөтөлбөр ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлоготой хэрхэн уялдаж байгаа, ХАА дахь жендэрийн асуудалд анхаарсан эсэх, малчин, тариаланчдад чиглэсэн эсэх, тус салбарт шууд болон ерөнхийлөн хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэхийг авч үзсэн байна.

Дээрх хөтөлбөрүүдэд ХАА, тэр дундаа МАА, газар тариалангийн үйлдвэрлэл дэх орон нутгийн онцлогийг харгалзсан асуудал дэвшүүлээгүй, зорилтот бүлэгт малчин тариаланчдыг тусгайлан анхаараагүй, малчин, тариаланч эрэгтэй, эмэгтэйчүүдэд шууд чиглэсэн ямар нэг арга хэмжээ тусгаагүй байна. ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлого дахь малчин, тариаланчдад хамаарах ажлын нөхцөлийг сайжруулахад чиглэсэн ХАБЭА-г

сайжруулах, ажилтнуудын нийгмийн хамгааллыг сайжруулах, эмэгтэй малчин, тариаланчдын ажиллах нөхцөл, ур чадварыг сайжруулах арга хэмжээ тусгагдаагүй, харин ерөнхий утгаараа “жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх ажил” тусгагдсан онцлогтой байна.

*Үйл ажиллагааны чиглэл 1-ийн хүрээ буюу ХХААХҮ-ийн салбарын бодлого төлөвлөлтийг дэмжих жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйн хүрээнд хийсэн үнэлгээ:*

ХХААХҮ-ийн салбарын бодлого, төлөвлөлтийг дэмжих жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтийн эхний үе шатны зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байна. Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх бүтэц бүрэлдээгүй бөгөөд уг тогтолцоог хөгжүүлэхэд ХХААХҮЯ, харьяа байгууллагуудын удирдлагын манлайлал, оролцоо хангалтгүй байна. Шинээр боловсруулан баталж буй салбарын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, ХШҮ-нд жендэрийн дүн шинжилгээ хийгээгүй ба жендэрийн статистик мэдээлэл цуглуулах, ашиглах тогтолцоо бүрдээгүй байна. Үндэсний болон орон нутгийн бодлого төлөвлөлтөд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлээгүй, салбарын жендэрийн бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд зохих төсөв хуваарилдаггүй байна. Орон нутгийн ХХААГ, тасгийн хүний нөөцийн дутмаг, нэг мэргэжилтэн хоёр ба түүнээс дээш орон тоонд ажиллаж байгаагаас жендэрийн асуудлыг нэмэлт ажил үүрэг болгон хүлээн авах хандлага сул байхад хүргэж байна.

Зөвлөмж:

- Салбарын яам, харьяа байгууллагууд, аймгийн ХХААГ, сумдын ХХАА-н тасгийн удирдах, гүйцэтгэх ажилтнууд, мэргэжилтнүүдийн жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний тоо, давтамжийг нэмэгдүүлэх, холбогдох төсөв хуваарилах
- Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд удирдах ажилтны манлайлал, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор албан тушаалын тодорхойлолт, ажлын үр дүнг үнэлэх шалгуурт тусгах
- Сайд, ТНДБ-ын тушаал зэрэг яамны шийдвэрийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах, орон нутагт ажиллаж буй мэргэжилтнүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэн ХХАА мэргэжилтэн бэлтгэх, тус салбарын чиглэл тус бүрийг хариуцаж байгаа мэргэжилтнүүдийн жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, ажлын байрны тодорхойлолтод жендэрийн холбогдох үүргийг тусгах нь сэлгэн ажиллуулахаас илүү оновчтой хувилбар гэж үзэж байна. Салбарын жендэрийн статистик мэдээллийн сан бий болгох талаар ҮСХ-той хамтран ажиллаж, үндэсний болон салбарын хэмжээнд мэдээлэл цуглуулах загваруудыг шинэчлэн боловсруулах, үүнд хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулахаар тусгах
- Салбарт хэрэгжүүлж буй гадаад улс орнууд, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэй хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд жендэрийн эрх тэгш

байдлыг хангах талаар бий болсон сургамж, туршлагаас суралцан салбарын үндэсний болон орон нутгийн бодлогод нэвтрүүлэх

**Жендэрийн мэдрэмжтэй нөлөөлөл**

Жендэрийн мэдрэмжтэй нөлөөлөл гэдэг нь жендэрийн холбогдолтой бодлого, хууль тогтоомж, стратеги, үйл ажиллагаа зэргийг шинээр нэвтрүүлэх, өөрчлөх эсвэл тэдгээртэй холбоотой дэмжлэг авахыг зорьсон санаа нэгтэй, тууштай бүлэг хүмүүс, байгууллагаас хэрэгжүүлж буй зорилтот үйл ажиллагаа юм (НҮБХАС, 2008). Өөрчлөлт хийхийн тулд багийн гишүүд нөлөөллийн ажлыг яагаад, хэрхэн хийх ёстой талаар нэгдмэл ойлголттой болох, хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны үзэл баримтлалаа тогтооход идэвхтэй хамтын ажиллагааг бий болгох нь ихээхэн чухал юм (Plan International, 2016).

Жендэрийн мэдрэмжтэй нөлөөллийн үйл ажиллагааг дараах алхамтайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

*Алхам 1. Нөлөөлөл явуулах асуудлыг тодорхойлно.*

Жишээ нь, *ОНЖДХ-ийг баталсан атлаа төсвийн төлөвлөлтөд үйл ажиллагааны зардал зохих ёсоор багтаагүй тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг төлөвлөлтөд тусгуулах шийдвэрт нөлөөлөх* зайлшгүй шаардлага гарна.

*Алхам 2. Нөлөөллийн ажлын зорилго, зорилтуудыг тодорхойлно.*

Нөлөөллийн ажлын зорилго бол ямар үр дүнд хүрсэн байх вэ гэсэн асуултын хариултаар тодорхойлогдоно.

Богино хугацааны зорилт	Орон нутгийг хөгжүүлэх нийгэм-эдийн засгийн үндсэн чиглэлд ЖБ-ын үйл ажиллагааны зардлыг тусгуулах
Дунд хугацааны зорилт	
Урт хугацааны зорилт	

*Алхам 3. Нөлөөллийн ажлын оролцогч тал, зорилтот бүлгийг тодорхойлох.*

Оролцогч тал бүрт тохирсон нөлөөллийн аргуудыг ашиглах хэрэгтэй. Тийм учраас оролцогч талуудын зураглал гаргах нь чухал байдаг.

*Алхам 4. Нөлөөллийн үйл ажиллагаанд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх түнш, хамтран ажиллагч, тэдгээрийн сүлжээг бий болгон идэвхжүүлэх*



Нөлөөллийн үйл ажиллагаанд хамтран ажиллах субъектүүдээ тодорхойлон, сүлжээнд нэгдсэнээр техник арга зүйн тусламж, хүн хүч болон хөрөнгө нөөцийг дайчлах, оновчтой зохион байгуулахад чухал ач холбогдолтой. ОНЖДХ-ийн хувьд бодлогыг боловсруулагч, хэрэгжүүлэгч, үр шим хүртэгч, бусад дэмжлэг үзүүлэгч нарын нягт хамтын ажиллагаа бүхий сүлжээг бий болгох нь чухал үүрэгтэй.

**Алхам 5. Шийдвэр гаргагч нарт хүргэх мессэжийг бэлтгэх**

Зорилтот бүлэгт ямар мэдээллийг хүргэх гэж байгаагаа мессэждээ тусгадаг. Мессэжийг тодорхой, энгийн ойлгомжтой, оновчтой томъёолох хэрэгтэй. Мессэжийн агуулга нь юуг өөрчилснөөр ямар үр дүнд хүрэхээр зорьж байгааг бүрэн тусгасан байна.

**Алхам 6. Нөлөөлөл хийх тохиромжтой аргыг сонгох**

Нөлөөллийн мессэжийг зорилтот бүлэгт хэн, мэдээллийн ямар суваг илүү богино хугацаанд, үр дүнтэйгээр хүргэж чадах вэ гэдгийг сайтар нягтлан сонгодог. Дараах сувгуудыг ашигладаг.

Үүнд:

- a. Хэвлэл мэдээлэл (сэтгүүл, сонин, радио, ТВ)
- b. Нийгмийн сүлжээ (фейсбүүк, инстаграмм, твиттер, ютүүб г.м)
- c. Дижитал хэрэгсэл ашиглах
- d. Байгууллагын дотоод сүлжээ
- e. Тараах материал, постер, зурагт хуудас, штёрк, богино хэмжээний видео, аудио
- f. Эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлэг, форум
- g. Аян, чуулган, флаш моби, жагсаал, захидал илгээх зэрэг олон нийтийг хамруулсан үйл ажиллагаа г.м

**Алхам 7. Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах.**

Нөлөөллийн асуудал	Нөлөөллийн зорилт	Зорилтот бүлэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэзээ	Хаана	Хэн хариуцах

Алхам 8. Хүлээгдэж буй үр дүн, амжилтын үзүүлэлтийг тодорхойлон үнэлэх

Нөлөөллийн үйл ажиллагааны алхам буюу үе шат бүр амжилттай хэрэгжсэн эсэхийг үнэлэн тодорхойлох нь чухал үүрэгтэй. Бид одоогоор юу хийгээд байна вэ? Юу энэ ажлыг илүү сайн үр дүнд хүргэх боломжтой байсан бэ? Бидний үйл ажиллагаанд хэн, хэн хамрагдсан бэ? Нөөц адил тэгшээр хуваарилагдсан уу гэх мэт асуултад хариулан, нөлөөллийн ажлыг сайжруулахад анхаарах асуудлыг тодруулна.

5.1.6. Дасгал ажлын кейс

Зорилго 5. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход жендэрийн тэгш оролцоог хангана.	Арга хэмжээний хэрэгжилт	Хариуцах байгууллага
Зорилт 5.1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох /харгалзан зохицуулах бодлого, түүний удирдлагыг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөн хэрэгжүүлнэ.	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлого төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал нэвтэрсэн эсэх	Бүх шатны ИТХ, Засаг дарга
Зорилт 5.2. Байгаль орчныг хамгаалах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэхэд жендэрийн тэгш оролцоог хангана	Ногоон ажлын байр	Бүх шатны ИТХ, Засаг дарга
Зорилт 5.3. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чадавхыг эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдэд бүрдүүлнэ.	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оролцогчдын тоо, хүйсийн тэнцвэртэй байдал нэмэгдсэн эсэх	Бүх шатны ИТХ, Засаг дарга
Зорилт 5.4. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагааг жендэрийн тэгш оролцоогоор дэмжих сайн туршлага гаргаж түгээн дэлгэрүүлнэ	Сайн туршлага	Бүх шатны ИТХ, Засаг дарга
Зорилт 5.5. Бүх шатны онцгой комиссын бүрэлдэхүүнд эмэгтэйчүүд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, залуучууд, аж ахуйн нэгж, ТББ-ын төлөөллийг оролцуулах замаар иргэдийн шийдвэр гаргах түвшний оролцоог нэмэгдүүлнэ	Бүрэлдэхүүний өөрчлөлт, хүйсээр	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга



## МОДУЛЬ 2. “УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ДАСАН ЗОХИЦОХ НЬ”

### Зорилго:

Уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн шалтгаан болон хүний үйл ажиллагааны нөлөөлөл, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, өөрчлөлтөд дасан зохицох жендэрийн мэдрэмжтэй бодлого, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд мэдлэг олгох сургагч багш нар сургалт явуулах арга зүйн чадамжтай болно.

### Зорилт:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, нөлөөллийн талаар мэдээлэл өгөх, бодит жишээн дээр суралцах;
2. Уур амьсгалын өөрчлөлтийн нийгэм, эрүүл мэнд, боловсролын үр нөлөө болон байгаль орчин, нийгэм, эдийн засгийн төлөвлөлтөд жендэрийн оролцоог хангах тухай хэлэлцүүлэг хийх, оролцогчдын оролцоо хангах сургалтын арга зүйн зөвлөмж өгөх;
3. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, өөрчлөлтөд дасан зохицох жендэрийн мэдрэмжтэй бодлого, арга хэмжээний талаар таниулах, холбогдох сайн жишээг түгээн дэлгэрүүлэх;

### Ач холбогдол:

Энэхүү модулийг судалснаар уур амьсгалын өөрчлөлтийн талаарх дэлхий нийтийн өмнө тулгамдаж байгаа гол асуудлууд, Монгол орны уг өөрчлөлтөд өртөх эмзэг байдал, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, түүнд дасан зохицох жендэрийн мэдрэмжтэй нийтлэг бодлого, арга хэмжээ, Монгол улсаас хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй арга хэмжээний сайн туршлагын талаарх мэдлэг болон сургалт явуулах арга зүйг эзэмших ач холбогдолтой.

### Хичээлийн сэдэв:

Хичээл 1: Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр нөлөө

Хичээл 2: Уур амьсгалын өөрчлөлт ба эрүүл мэнд

Хичээл 3: Уур амьсгалын өөрчлөлтийн нийгмийн үр дагавар ба жендэрийн ялгаатай байдал

Хичээл 4: Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн байгаль орчин, эдийн засаг, нийгмийн төлөвлөлт, жендэрийн оролцоо

Хичээл 5: Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, өөрчлөлтөд дасан зохицох жендэрийн мэдрэмжтэй бодлого, арга хэмжээ

## Хичээл 6. Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр нөлөө

Хичээлийн төлөвлөгөө

Зорилт: Уур амьсгалын өөрчлөлтөд хүргэж болохуйц байгалийн хүчин зүйл, уур амьсгалын хэлбэлзэл, уур амьсгалын системд үзүүлэх байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөллийн талаарх мэдлэг олгох сургалтын арга зүйд суралцана.

Товч агуулга:

- Уур амьсгалын систем бүрдүүлэгч хүчин зүйлс, тэдгээрийн харилцан уялдаа
- Уур амьсгалын системийн гадаад, дотоод зүйчин зүйлс
- Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй байгалийн хүчин зүйлс
- Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй хүний хүчин зүйлс

Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Үзүүлэн (PowerPoint илтгэл)
- Youtube бичлэг: ГАГГА, МОНЭС “Уур амьсгалын өөрчлөлт” (<https://www.youtube.com/watch?v=PLdMH40HuYA>)
- Самбарын цаас, үзэг

Хугацаа: 60 минут

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Хугацаа /минут/	Үйл ажиллагаа	Аргачлал
30 мин	Уур амьсгалын өөрчлөлт, шалтгааны талаарх ойлголт өгөх	Илтгэл, танилцуулга хийх
25 мин	Уур амьсгалын өөрчлөлт мэдрэгдэж байгаа эсэхийг үнэлэх <ul style="list-style-type: none"> <li>• Оролцогчид нутгийнхаа уур амьсгалын 10 жилийн өмнөх болон одоогийн нөхцөл байдлыг харьцуулан хистограм дээр ажиллаж үнэлэх</li> </ul>	Уур амьсгалын өөрчлөлтийн хистограм багаар ажиллах
5 мин	Оролцогчдоос бататгах асуулт асуух. Сэдэвтэй холбоотой асуултад хариулах.	Бататгах асуулт, нэгдсэн дүгнэлт хийх.

Мэдлэг олгох хэсэгтэй холбоотой унших мэдээлэл:

Тодорхой хугацаа агшинд буюу тодорхой хугацааны хоорондох агаар мандлын физик төлөв байдлыг **цаг агаар (weather)** гэнэ. Тухайн газар нутгийн газарзүйн онцлог, нарны цацраг, агаар мандлын ерөнхий орчил урсгал өөрөөр хэлбэл агаар мандал, усан мандал, газар бүрхэвч хоорондын харилцан үйлчлэлээр бий болсон цаг агаарын нөхцөлийн хэдэн арван жилийн дундаж статистик горимоор илэрхийлэгдэх агаар мандлын үзэгдэл, процессын зүй тогтлыг тэр газар нутгийн **уур амьсгал** гэнэ. Уур амьсгал үүсэн бий болох зүй тогтол, тэдгээрийн дэлхийн бөмбөрцгөөр тархах хуваарилагдалт, мөн уур амьсгалын өнгөрсөн ба ирээдүйн өөрчлөлт, хандлагыг судалдаг цаг уурын салбар шинжлэх ухааныг **Уур амьсгал судлал (Climatology)** гэнэ. Тухайн газар нутгийн уур амьсгал бол нүүрс, газрын тос, ой мод шиг байгалийн нэг баялаг, гэхдээ нөхөн сэргээгдэж байдаг баялаг хэмээн эрдэмтэд тодорхойлсон байна. Мөн аливаа улс орны хүн амын амьдралын түвшин, нийгэм - эдийн засгийн хөгжилд уур амьсгалын нөөцийг үр дүнтэй ашиглах явдал нь уур амьсгал судлалын чухал зорилтын нэг болдог.

Уур амьсгалыг бүрдүүлэх хүчин зүйл гэдэгт уур амьсгалын системд нөлөөлдөг гадаад хүчин зүйл болон энэ системийн бүрдүүлэгчийн харилцан үйлчлэлийн физик механизмыг ойлгоно.




**Астрономийн хүчин зүйлд** нарны цацрагийн эрчимшил, түүний боломжит өөрчлөлт, нарны систем дэх дэлхийн байрлал, орбитын хавтгайд дэлхийн эргэлтийн тэнхлэгийн үүсгэх өнцөг, дэлхийн орбитын үзүүлэлт, дэлхийн тэнхлэгээ тойрон эргэх эргэлтийн өнцөг хурд зэрэг орно. Дэлхийн уур амьсгалд нөлөөлж болох **геофизикийн хүчин зүйл гэдэгт** дэлхийн өөрийнх нь хэмжээ, масс, дэлхийн татах хүчний болон соронзон орон, дэлхийн дотоод дулаан, галт уулын идэвхжил зэрэг багтана. Уур амьсгал бүрэлдэн тогтоход нөлөөлөх **дотоод хүчин зүйлд** агаар мандлын хий, далайн усны найрлага, масс, далай - эх газрын хуваарилагдалт, хуурай газрын хотгор гүдгэр (рельеф), эх газар болон далайн идэвхтэй үе давхаргын бүтэц зэрэг багтана.

Дундажлалын хугацаатай жишихүйц буюу түүнээс удаан хугацаанд уур амьсгал эргэж буцахгүй шинжтэй өөрчлөгдөхийг **уур амьсгалын өөрчлөлт** гэж нэрлэх ба эргэж буцах буюу хуучин төлөвтөө эргэн орох шинжтэй өөрчлөгдөхийг **уур амьсгалын хэлбэлзэл** гэж нэрлэнэ.

Дэлхий үүсэн бүрэлдсэнээс хойш олон зуун сая жилийн хугацаанд уур амьсгалын хэлбэлзэл урт хугацаанд явагдаж ирсэн. Бага мөстлөгийн үе XIX зууны сүүлчээр үндсэндээ дуусч бага зэргийн дулааралт болсныг XX зууны дулааралт гэдэг. XX зууны дулааралтын туйл 1930-1940-өөд оны хавьд тохиосон. Эх газрын бараг бүх бүсэд өндөр уулын цас мөс татарч ирсэн. XX зууны дулааралт 1940-өөд оны сүүлчээр зогсож 1970-аад оны дунд үе хүртэл бага зэрэг сэрүүссэн боловч энэ нь бага мөстлөгийн үетэй жишихээргүй уур амьсгалын ердийн богино үет хувирал байв. **Орчин үеийн гэх энэ дулаарлын эрчимшлийг** дэлхийн аж үйлдвэржилтийн (1850 оноос) хувьсгалаас үүдэлтэй хяналтгүй газар, ой ашиглалт, хатуу шингэн түлшний дутуу шатаалт, хүн, малын тооны тасралтгүй өсөлт, тэдгээрийн хэрэгцээтэй холбоотой хүлэмжийн хий нэмэгдэж байгаа (гадаад хүчин зүйл)-тай шууд холбоотой гэж үзэх болсон.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд хамгийн эхэнд өртөх байгалийн бүрэлдэхүүн хэсэг бол гадаргын ус, усан гадарга, усан мандал буюу гол мөрний урсац, мөстөлт, нуур, цэвдэг байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нь усан гадаргын ууршилт, усны тэнцлийн бүрэлдэхүүн хэсгүүд, дулааны горим, усны температур хийгээд усны чанарт нөлөөлөх байдлаар илэрнэ.





**Хүлэмжийн хий гэж юу вэ?**

Нарны цацраг дэлхийн газрын гадаргад хүрээд эргэж ойх ёстой боловч нүүрс хүчил, метан зэрэг хийнд шингэж агаар мандалд үлддэг. Ингэснээр агаар мандалд хүлэмжтэй адил орчин үүсч байдаг бөгөөд үйлдвэрлэл, хүний үйл ажиллагаанаас хамааралтай ялгарч байгаа эдгээр хийг хүлэмжийн хий гэж нэрлэжээ.

**Монгол орны жилийн дундаж агаарын температур сүүлийн 80 жилд ойролцоогоор 2.25°C-ээр дулаарсан болохыг эрдэмтэд тогтоосон. 1990 оноос хойш агаарын дундаж температурын өсөлт эрчимжсээр хамгийн дулаан жил 2007 онд тэмдэглэгджээ. Цаашид хүлэмжийн хийн ялгарлаас үүдсэн уур амьсгалын удаан хугацааны өөрчлөлт нь агаарын температурыг нэмэгдүүлээд зогсохгүй үер ус, байгалийн гаралтай аюулт үзэгдлийн эрсдэлийг улам нэмэгдүүлнэ гэж судлаачид анхааруулдаг.**





### **Уур амьсгалын өөрчлөлтийн төлөв байдал**

Монгол Улс нь газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд 19-р байрт, далайд гарцгүй орнуудын дотор 2-рт орох хэмжээтэй бөгөөд эх газрын эрс тэс уур амьсгалтай, говь цөл, уул нуруу, тал хээр, гол нуур, ой хөвч агуулсан уур амьсгалын хувьд өвөрмөц онцлог шинжтэй орон юм. Хур тунадасны жилийн дундаж хэмжээ нутгийн хойд уулархаг хэсгээр 350 мм байдаг бол өмнөд хэсэг болох говийн бүсэд 80 мм орчим байдаг (ADB, 2020). Жилийн 257 өдөр нь нарлаг байдаг, уур амьсгалын улирлын хэлбэлзэл ихтэй бөгөөд өвөлдөө (11-2 сард) цельсийн -40 хэм, зундаа (7-9 сард) +35 хэмийн дулаан байдаг онцлогтой.

Газар зүйн болон уур амьсгалын нөхцөлийг харгалзан үзвэл уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд хамгийн өртөмтгий улс орнуудын нэг гэж үздэг бөгөөд Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлт хэдийн ажиглагдаж эхэлсэн. Агаарын хэм, хур тунадасны хэмжээнд өөрчлөлт орсон нь бэлчээр муудах, мал аж ахуйн бүтээмжид сөргөөр нөлөөлж байна (Дэлхийн Банк, 2020). Дулааны хэм нэмэгдэж, хур тунадасны хэлбэлзэл өссөнөөс усны ууршилт ихэссэн нь голын усны түвшин буурах, улирлын өөрчлөлт, хэлбэлзэл нэмэгдэх, нөхөн сэргээлт явагдахгүй байгаагаас бэлчээр, усан хангамж доройтох олон сөрөг үр дагаварыг бий болгож байна (ADB, 2020). Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаагаар 1940 оноос 2015 оны хооронд жилийн дундаж температур 2.2°C хэмээр өссөн байна. Энэхүү өгөгдлийн үнэлгээгээр уулархаг бүс нутгаар дулаарал илүү өндөр явагдаж, харин тал хээр, говийн бүсэд бага өөрчлөлттэй байна. Үүнээс авч үзвэл богино хугацааны таамаглалаар 2016-2035 онд улирлын температур 2.0°C-2.3°C, урт хугацаанд буюу 2081-2100 онд 2.4°C-6.3°C хэмээр нэмэгдэх хандлагатай бөгөөд энэ нь тухайн үеийн нөхцөл байдал, хүний үйл ажиллагаанаас шууд шалтгаалах болно.

Температурын өсөлт нь хөрс, бэлчээр, ойн экосистем, амьтан, ургамлын бүтцэд шууд нөлөөлдөг тул Монгол оронд явагдаж буй бэлчээрийн доройтолд хүчтэй нөлөөлж буй хүчин зүйлийн нэг нь уур амьсгалын өөрчлөлт байна (Чулуун, 2014). НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн хүрээнд гаргаж буй уур амьсгалын хэтийн төлөвөөр Монгол Улсад зундаа ган, өвөлдөө зуд болох давтамж нэмэгдэх хандлагатай байна. (Жендэр судлал №4, 2021 хуудас 57-58)

### **Нэмэлт ашиглах материал:**

1. UN-REDD үндэсний хөтөлбөрийн талаарх олон нийтийн санаа бодол, ойлголтыг тодруулах суурь судалгаа-2016, ММCG
2. Тогтвортой хөгжлийн зорилго: 2016-2030, Үндэсний Статистикийн Газар

### **Дасгалын хэрэглэгдэхүүн:**

“Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөл байдлыг үнэлэх” хистограм үнэлгээ

1. Оролцогчдыг дасгалд урьж 4 баг болгон хуваана.
2. Баг тус бүр 4 үзүүлэлтийг хуваарилан, “Өөрийн нутаг орны жишээн дээр дараах асуудалд уур амьсгалын ялгаа бий болсон эсэхийг 20 жилийн өмнө ба одоо гэсэн харьцуулалтаар үнэлнэ үү” хэмээн багийн ажлыг эхлүүлнэ.
3. Хананд байрлуулсан 4 төрлийн цаасанд 20 жилийн өмнөх, одоо гэсэн багана үүсгэнэ.
4. Багийн оролцогчид тухайн үзүүлэлтийг 20 жилийн өмнөх нөхцөл байдлаа эргэн санаж, өнөөгийн байдалтай харьцуулж бичнэ.
5. Багийн гишүүд дасгал ажилд тэгш оролцон 20 минут ажиллана.

Үзүүлэлт	20 жилийн өмнөх	Одоо
Нэг. Зун, өвлийн температур		
Хоёр. Хур тунадас		
Гурав. Салхи, шуурга		
Дөрөв. Ган, зуд гэх мэт байгалийн гамшигт үзэгдэл		

*Дасгалын дүгнэлт.* Баг тус өөр өөрсдийн ажлаа 2-3 минутад багтаан танилцуулна. Харьцуулсан танилцуулгын дараа сургагч нэгдсэн дүгнэлт хийх бөгөөд үзүүлэлт бүрд 20 жилийн хугацаанд ямар өөрчлөлтүүд гарсан байгааг гол, гол үр дүнгүүдээр жишээ татан тодруулна. Тухайлбал салхи шуурга элбэгшиж, шороон шуурга хавар намрын улиралд ихэссэн. Үүнтэй холбоотой түймрийн аюул, эрсдэл нэмэгдэж айл өрхүүд хөрөнгө, мал, эрүүл мэндээр хохирох үзэгдэл бий болж байгааг оролцогчдын жишээгээр, тухайн сургалт явагдаж буй орон нутгийн нөхцөл байдалд үндэслэн дүгнэн хэлэлцэнэ.

*Дасгал ажлын жишээ:*

Үзүүлэлт	20 жилийн өмнөх	Одоо
Нэг. Зун, өвлийн температур	<ul style="list-style-type: none"> <li>- Зуны сар урт байсан. 3 сар</li> <li>- Зуны халуун 30<sup>0</sup>С-с дээш гарч байгаагүй.</li> <li>- Хавар, намрын улирал хэвийн байв.</li> <li>- Өвөл шинэ жилээр их хүйтэн байсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Зуны сар богиноссон. 2 сар</li> <li>- Зуны халуун 30<sup>0</sup>С-с дээш гарах тохиолдол ихэссэн.</li> <li>- Хавар, намрын улирал уртассан.</li> <li>- Шинэ жилийн үеэр их хүйтэнгүй болсон.</li> </ul>

**Мэдлэг бататгах, дүгнэх зөвлөмж.**

Сэдвийн төгсгөлд тодруулж асуух асуулт бий эсэхийг лавлан, асуултад хариулт өгөх нь орхигдсон мэдлэг, мэдээллийг тодруулах боломж бий болгоно. Асуултад хариулж дууссаны дараа сэдвийн нэгдсэн дүгнэлт хийнэ.

“Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхийн хүн бүрийн анхаарах ёстой тулгамдсан асуудлын нэг бөгөөд бидний өдөр тутмын амьдралд нөлөө үзүүлж байгаа бодитой өөрчлөлт юм” гэсэн санааг илүү ойлгуулах үүднээс сургалт явагдаж буй аймаг, сумын жишээгээр баяжуулахыг зөвлөж байна. Үүний тулд аймгийн байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтан, мэргэжилтнээс тодорхой мэдээлэл авч, үзүүлэн материалдаа тусгаж өгвөл сайн. Энэхүү мэдээлэл нь дүрс бичлэг, статистик тоон мэдээ, нийтлэл мэдээ зэрэг ямар ч хэлбэртэй байж болох бөгөөд оролцогчид ойлгоход илүү хялбар байх талыг харгалзах нь зүйтэй.

Багаар дасгал ажиллан, нэмэлт мэдээлэл өгсний дараа оролцогчдоос дараах асуултыг асуух.

1. Сүүлийн 20 жилийн хугацаанд цаг агаарын өөрчлөлтийг бодитоор мэдэрсэн үү?
2. Энэ нь зүгээр цаг агаарын өөрчлөлт байв уу, эсвэл таны амьдрал, амьжиргаанд нөлөөлсөн өөрчлөлт байв уу?
3. Яагаад энэ бүхэн өөрчлөгдөв, юунаас болсон гэж та бодож байна вэ?

Энэ бүхний эцэст “Уур амьсгалын өөрчлөлт бидэнд хамаатай юу, нөлөөтэй юу?” гэдгийг дүгнэснээр, хэлэлцэж буй асуудалд илүү бодитой, ач холбогдол өгч оролцох оролцоог хангаж өгнө.

**Хичээл 7. Уур амьсгалын өөрчлөлт ба эрүүл мэнд**

Хичээлийн төлөвлөгөө

*Зорилт:* Уур амьсгалын өөрчлөлтийн хүн амын эрүүл мэндэд үзүүлэх шууд болон шууд бус нөлөө, эрүүл мэндийн жендэрийн ялгаатай байдлын талаар мэдлэг олгох сургалтын арга зүйд суралцана.

Товч агуулга:

- Био цаг уур, уур амьсгалын нөхцөл
- Уур амьсгалын өөрчлөлтийн эрүүл мэндийн үр дагавар
- Уур амьсгалын өөрчлөлт ба нийгмийн эрүүл мэнд

Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Үзүүлэн (PowerPoint илтгэл)
- “Уур амьсгалын өөрчлөлт ба эрүүл мэнд” бичлэг (<https://fb.watch/8APUnNy7p/> / )
- Ханын цаас, өнгийн цаас (наадаг), бал

Хугацаа: 60 минут

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Хугацаа /минут/	Үйл ажиллагаа	Аргачлал
20 мин	Уур амьсгалын өөрчлөлтийн эрүүл мэндийн үр дагаварын асуудал	Илтгэл, танилцуулга
30 мин	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг таниулах <ul style="list-style-type: none"> <li>• Оролцогчдыг багт хуваан “Уур амьсгалын өөрчлөлт ялгаатайгаар нөлөөлдөг үү?” сэдвийн дор хэлэлцүүлэг хийх.</li> </ul>	Багаар ажиллах. Үр дүнг танилцуулах
10 мин	Оролцогчдоос бататгах асуулт асуух. <ul style="list-style-type: none"> <li>• Сэдэвтэй холбоотой асуултад хариулах.</li> <li>• Сэдвийг дүгнэж хэлэлцэх.</li> </ul>	Бататгах асуулт, нэгдсэн дүгнэлт хийх.

Мэдлэг олгох хэсэгтэй холбоотой унших мэдээлэл:

Агаар мандлын процесс хүний амьдрал, үйл ажиллагаа, эрүүл мэндэд нөлөөлдөг асуудлыг эрт үеэс судалж ирсэн бөгөөд эрүүл мэнд болон цаг уурын мэргэжлийн судалгааны “**Био цаг уур**” гэсэн бие даасан салбар үүссэн. Био уур амьсгал нь хүний биед цаг агаар, уур амьсгал хэрхэн нөлөөлөх, энэхүү нөхцөлийг ашиглан эмчлэн сувилах арга, био тунг тогтоох, хүн өөр орчинд амьдран сууж цаг агаар, уур амьсгалд дасан зохицох, эмгэг өвчин үүсгэх зэргийг судална.


Монголчууд бэлчээрийн мал аж ахуй эрхэлж, нүүдэл, отор, жин тээхдээ бие организмаа байгалийн хүчин зүйлээр чийрэгжүүлэн, эмгэг хууч өвчнөө рашаан усаар болон шавар засал хийж эдгээж ирсэн баялаг уламжлалтай. Уур амьсгал, цаг агаарын тааламжтай нөхцөлд рашаан усанд орох, дэг гам хийхдээ хурц нар, хүйтэн бороо уснаас хамгаалах, сүү, цагаан идээ, борц, эмийн ургамал, жимс, төрөл бүрийн хүнсний ногоо хэрэглэж зохицсон.

Монголчууд гэр сууцаа жилийн 4 улиралд тохируулан дулаалж буух газраа улирлын цаг агаарт зохицуулан сонгож, цаг агаарын элдэв эрсдлээс амь нас, эрүүл мэнд, мал хөрөнгөө хамгаалж ирсэн.

Уур амьсгалын өөрчлөлт нь агаарын чанар, ундны усны эх үүсвэрийн чанарт нөлөөлж, нийгмийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадлал өндөр юм. Уур амьсгалын өөрчлөлт нь цэвэр агаар, ус, хоол хүнсний хангамж, тохиромжтой орон байр гээд хүний эрүүл амьдрахад шаардлагатай үндсэн эх үүсвэрт нөлөөлж байгааг судлаачид анхааруулж байна. Дэлхийн хэмжээнд:

- Хотын агаарын бохирдлын улмаас 1.2 сая хүн,
- Цэвэр усны хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл хангалтгүйн улмаас суулгалт халдвараар 2.2 сая хүн
- Хоол хүнсний дутагдлаас шалгаалан 3.5 сая хүн
- Байгалийн гамшгийн улмаас 60,000 орчим хүн жил бүр нас барж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс эмэгтэйчүүдийн нөөц баялгаас хүртэх хүртээмж хязгаарлагдмал, шийдвэр гаргах чадвар сул зэрэг нөлөө багатай байр суурь нь эмэгтэйчүүдийг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд нэн эмзэг болгож, одоо байгаа тэгш бус байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй гэж дүгнэсэн.



Уур амьсгалын өөрчлөлтийн шууд үр дагавар нь:

- уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй үер, гамшиг,
- ган гачиг,
- хэт хүйтэн юмуу халуун урсгал,
- урьдчилан таамаглах боломжгүй цаг агаарын нөхцөл байдал, гамшиг.

Энэ нь (богино эсвэл урт хугацаанд) дараах нөхцөл байдалд хүргэдэг.

- орлогын эх үүсвэр/амьжиргааны тодорхойгүй байдал,
- эрүүл мэндийн болон эд материалын хохирол,
- байгалийн нөөц ашиглалтын хязгаарлалт,
- ус, эрчим хүчний хомсдол,
- дэд бүтцийн гэмтэл,
- биологийн олон янз байдлын өөрчлөлт,
- хүний эрүүл мэндэд үзүүлэх үр дагавар,
- шилжилт хөдөлгөөн,
- бэлчээр, соёл, байгалийн өвийн эвдрэл, гэмтэл гэх мэт юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр дэлхийн агаарын дундаж температур 0.8 градусаар өссөн бол Монгол Улсад сүүлийн 70 жилийн дотор 2 градусаар нэмэгдсэн. Тийм ч учраас манай улс уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг эхний 10 улсад багтсан бөгөөд хүн амын амьжиргааны 80-аас дээш хувь нь цаг агаарын төлөвөөс шууд хамааралтай байгаа тул энэ асуудалд анхаарах зайлшгүй шаардлагатай байна.

Хэт халалтын үед зүрх судас, амьсгалын тогтолцооны өвчлөлийн улмаас эмзэг бүлгийн хүн амын цаг бусаар эндэх тохиолдол нэмэгдэх хандлагатай. Мөн зоонозын өвчин, уснаас шалтгаалах өвчин зэрэгт хүүхэд, өндөр настан илүүтэй өртөх эрсдэлтэй байна.

№	Уур амьсгалын нөлөө	Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, эрсдэл
1	Агаарын халуун урсгал, агаарын даралт	- Наранд цохиулах, багтрах (настай хүмүүс) - Амьсгалын замын өвчлөл нэмэгдэх - Зүрх судасны өвчлөл нэмэгдэх
2	Агаарын хүйтэн урсгал, цасан шуурга	- Биеийн дулаан алдагдах - Хөлдөж бээрэх - Архаг, хууч өвчин сэдрэх, хүндрэх
3	Дулаан цаг агаар, хур тунадасны горимын өөрчлөлт	- Хумхаа, халуун хумхаа

## ЖЕНДЭР БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

		- Тархи нугасны өвчин зэрэг шумуул, хөртөн мэрэгч, шимэгчээр дамждаг халдварт өвчний гаралт, тархалт
4	Хүчтэй аадар бороо, үер	- Баталгаагүй ундны ус, хүнсний хэрэглээнээс үүдэлтэй өвчлөл
5	Ган	- Хоол тэжээлийн дутагдал - Стресс (тариаланчид)
6	Цаг агаарын бусад эрс тэс үзэгдлүүд (хүчтэй салхи, шуурга гэх мэт)	- Амь эрсдэх, гэмтэж бэртэх, тахир дутуу болох - Хүчээр нүүлгэн шилжүүлэх→стресс

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт нь хүн төрөлхтний соёл иргэншлийн бусад аль ч өөрчлөлтөөс илүү эрчимтэй явагдаж байгаа бөгөөд эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллүүд нь хурцаар мэдрэгдэж байна. Уур амьсгалын өөрчлөлт хөгжиж буй оронд хамгийн хүнд эрсдэл учруулж, эрүүл мэндийн тэгш байдлыг хангахад сөргөөр нөлөөлж байгаа.



Агаарын температурын хэт өөрчлөлт, агаарын бохирдол, үер, хуурайшилт, бохирдсон ус, хөрс, хөдөө аж ахуйд үзүүлж байгаа уур амьсгалын өөрчлөлт нь Монгол улсын хүн амын биеийн болон сэтгэцийн эрүүл мэндэд шууд, шууд бусаар нөлөөлж байгааг сүүлийн жилүүдийн гамшигт үзэгдлээс харж болно. Тодруулбал, үер, аадар бороо, зуд, хүчтэй салхин болон цасан шуурга зэрэг байгалийн гамшигийн давтамж ихэссэнээс иргэд амь насаа алдах, сэтгэхүйн



хямралд орох, орон гэргүй болох, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч чадахгүй саатах эрсдэл нэмэгдэж байна.

"Эмзэг байдал" гэж нэрлэгддэг янз бүрийн хүчин зүйлүүд байх бөгөөд энэ нь ядуурал, нийгмийн тэгш бус байдал, онцгой байдлын үеийн эмзэг байдалд хүргэдэг.

Эдгээр нь:

- Биологийн (нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, түүний дотор жирэмслэлт);
- Нутаг дэвсгэрийн болон биет байдал (хөдөө, орон нутгийн хүн ам хот, төв суурин газрын хүн амаас илүү эмзэг байдаг);
- Эдийн засгийн (ядуу хүмүүс эрсдэлд илүү өртдөг, тэд нөөц баялаг багатай, эргэн сэргэх боломж багатай байдаг);
- Нийгмийн (хэм хэмжээ, гэр бүлийн амьдралын хэв маяг, ялгаварлан гадуурхалт, үйлчилгээний хүртээмж гэх мэт);
- Мэдлэг, мэдээлэл (ур чадварууд, усанд сэлэх гэх мэт, мэдээллийн суваг, анхны тусламжийн сургалт гэх мэт);
- Улс төрийн - улс төрийн эрх мэдэл, шийдвэр гаргахад оролцох, нийгмийн үйл ажиллагаанд тэгш хамрагдах.

Зарим бүлгүүд, ялангуяа эмэгтэйчүүд, өндөр настан, үндэсний цөөнх илүү эмзэг байдаг. Ихэвчлэн ядуу, ганц бие, ялангуяа хөгшин эмэгтэйчүүд эсвэл өрх толгойлсон эмэгтэйчүүд машин, трактор, завь, хадгаламжтай байх нь ховор; тэд усанд сэлэх чадвар багатай; эрэгтэй хүнгүйгээр (нөхөр, аав, ах) бие даан шийдвэр гаргах чадамж сул байдаг. Энэ нь мэдээж бүх эмэгтэйчүүдэд хамаарахгүй ч жендэрээс хамааралтай эмзэг байдал бий болоход нөлөөлдөг.

“Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ” судалгааны тайлангаас:

... Жирэмсэн, амаржсан эмэгтэйчүүдийн дийлэнх (98 хувь) нь жирэмсний хяналтад орж байгаа ч цөөн тооны эмэгтэйчүүд энэ үйлчилгээний гадна үлдсэн байна. 500-аас дооу тооны малтай эмэгтэйчүүд жирэмсний хяналтад орж чадаагүй байдал ажиглагдав. Газарзүйн байршлын хувьд гол төлөв өндөр уулын болон хангайн бүсийн сумдын эмэгтэйчүүдэд энэ асуудал түлхүү илэрсэн байна. Жирэмсний хяналт эхийн эсэн мэнд амаржихад нөлөөтэй бөгөөд эндэж буй эхчүүдийн дунд малчид, тэр дундаа алслагдмал нутгийн малчид зонхилох хандлагатай байдаг (хуудас 88).

... Судалгааны явцад судлагдсан аймаг, сумдаас осол гэмтлийн болон байгалийн гамшгийн шалтгаантай залуу малчдын нас баралтын талаарх мэдээллийг цуглуулахад, албан бус мэдээллээр гол төлөв эрэгтэйчүүд илүү



өртдөг байна. 2021 оны 3 дугаар сарын 13-14-нд болсон салхин шуурганы улмаас Архангай аймагт 1, Дундговь аймагт 8 хүн (голдуу малчид) нас барсан байна (хуудас 90).

Олон улсын хэд хэдэн судалгаанаас үзэхэд гамшгийн улмаас нас барсан тохиолдлын эрэгтэйчүүдийн тооноос эмэгтэйчүүдийн тоо илүү өндөр байдаг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эмзэг байдлын нийгмийн ялгаатай байдлаас шалтгаалж байгааг илтгэдэг. Тухайлбал, 2004 оны Азийн цунамигийн дараа Индонез, Энэтхэгийн тосгодод хохирогчдын 70 гаруй хувийг эмэгтэйчүүд байсныг тогтоожээ. 1991 оны хар салхины улмаас Бангладеш улсад 140,000 хүн амиа алдсаны 90% нь эмэгтэйчүүд, залуу охид байсан.

Жендэр ба гамшгийн талаарх судалгааг дэлхийн 141 орны мэдээлэлд үндэслэн явуулсан бөгөөд эрэгтэйчүүдээс илүү олон эмэгтэйчүүд гамшигт өртөж, ялангуяа ядуу бүлгийн залуу эмэгтэйчүүд их өртдөг болохыг тогтоожээ. Энэ нь онцгой байдлын үед эмэгтэйчүүдийн эмзэг байдал өндөр, харин чадамж (мэдээллийн суваг, биеийн хүч чадал, ур чадвар, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж гэх мэт) багатай байна гэсэн үг юм. Түүнчлэн эмэгтэйчүүдийн эмзэг байдал нь жендэрт суурилсан байдаг, энэ нь жендэрийн хэм хэмжээ, үүргээс үүдэлтэй гэсэн үг юм. Эдгээр тэгш бус байдал нь бүтцийн түвшинд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байр суурь дээр суурилж байгаа мэт боловч онцгой байдлын үед хувь хүний түвшинд голлон илэрдэг. Онцгой нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлтийн шууд үр дагаврыг арилгах, шууд бус үр дагаварт дасан зохицоход жендэр чухал үүрэг гүйцэтгэдэг. НҮБ-ын Дүрвэгсдийн комиссын мэдээлснээр, дэлхийн цагаачдын 80% нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байдаг нь охид, хөвгүүдийн боловсрол эзэмшихэд сөрөг нөлөө үзүүлдэг.

***Нэмэлт ашиглах материал:***

1. Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ, 2021, Жендэрийн үндэсний хороо
2. UN-REDD үндэсний хөтөлбөрийн талаарх олон нийтийн санаа бодол, ойлголтыг тодруулах суурь судалгаа-2016, MMCG

***Дасгалын хэрэглэгдэхүүн:***

“Уур амьсгалын өөрчлөлт ялгаатайгаар нөлөөлдөг үү?” хэлэлцүүлэг

1. Оролцогчдыг 3-4 хүнээр бүлэглэн 4-6 баг болгож хуваах (баг бүр эрэгтэй, эмэгтэй аль жишээн дээр ажиллахаа шодно).
2. Багууд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн жишээг сонгох.
3. Баг бүр ахлагч сонгох.
4. Багийн ахлагч өгөгдсөн тодорхойлолтыг гишүүддээ уншиж өгөх

5. Баг бүр өөрсдийн сонгосон бүлэгт (эрэгтэй юмуу эмэгтэй хүмүүст) тухайн асуудал хэрхэн нөлөөлөхийг сонгосон жишээн дээр үндэслэн хэлэлцэх. Сургагч нар багийн ажиллагааг идэвхжүүлэн, оролцогчдын бодит амьдралын жишээг дасгал ажилд оруулах тал дээр дэмжлэг өгч, идэвхжүүлэхэд анхаарах.
6. Хэлэлцүүлгийн төгсгөлд багийн ахлагч үр дүнг танилцуулна.
7. Дасгалаас юу суралцсанаа дүгнэнэ.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө (эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн жишээгээр)		
Болзошгүй эрсдэл	Жишээ	Сонгосон бүлэгт үзүүлэх нөлөө
<b>Шууд нөлөө</b>		
Ган гачиг олширч, бэлчээр, усны эх үүсвэр хомсдох		
Цаг агаарын эрс тэс үзэгдэл нэмэгдэх		
<b>Шууд бус нөлөө</b>		
Халдварт өвчин нэмэгдэх		
Амьтан, ургамалын төрөл зүйл цөөрөх		

*Дасгалын дүгнэлт.* Эрэгтэй, эмэгтэй хүмүүст болзошгүй эрсдэл хэрхэн нөлөөлөхийг багууд өөрсдийн ажлаараа танилцуулсны дараа, уур амьсгалын өөрчлөлтийн шууд болон шууд бус нөлөө нь харилцан адилгүй нөлөөлж байгааг багуудын ажлын үр дүнгээр харьцуулан хэлэлцэнэ. Оролцогчдын бодит жишээг харьцуулж, жендэрийн хамааралтай эмзэг байдлыг тодруулан дүгнэхэд дасгалын ач холбогдол оршино.

**ЖЕНДЭР БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ**

Дасгалын жишээ:

УАӨ-ийн нөлөө	Болзошгүй эрсдэл	Жишээ	Эмэгтэйчүүдэд нөлөөлөх нөлөө
<b>Шууд нөлөө</b>			
	Зун хэт халж, ган болох	Хэт халалтаас улбаатай бэлчээр доройтох, малын идэш тэжээл хомсдох	Нүүдлийн мал аж ахуй эрхлэгч айл өрхүүдийн амьжиргаа буурах, эмэгтэйчүүдийн орлого буурах.
	Усан хангамж багасах	Булаг, шанд ширгэх, худгийн ундрага татрах	Хөдөө, орон нутагт усны гол хэрэглэгч эмэгтэйчүүд байдаг тул тэдний өрх гэртээ хийх ажлын ачаалал нэмэгдэнэ.
	Цаг агаарын эрс тэс үзэгдэл нэмэгдэх	Салхи, шороон шуурга, үер, түймэрийн давтамж олшрох	Дэлхийн 141 улс орнуудад явуулсан судалгаагаар эрэгтэйчүүдээс, эмэгтэйчүүд илүү гамшигт өртөж, амь насаар хохирсон байдаг.
<b>Шууд бус нөлөө</b>			
	Халдварт өвчин нэмэгдэх	Гэдэсний халдвар, холер, нийтийг хамарсан цар тахал	Халдварт өвчлөлийн үед гэр бүлээ арчлах, халдвараас сэргийлэх зэргээр эмэгтэйчүүдийн ачаалал нэмэгддэг. Халдварт өвчнөөр өвчилсөн өрх, өрх толгойлсон эмэгтэйчүүд УАӨ-ийн нөлөөнд илүү өртөмтгий байна.
	Амьтан, ургамалын төрөл зүйл цөөрөх	Олон улсын судалгаагаар 2050 гэхэд биологийн төрөл зүйл УАӨ-с шалтгаалан 18-35 хувь цөөрнө.	Температурын өөрчлөлтийн улмаас бэлчээр доройтох, үр тариа хүнсний ногооны гарц багасна. Үүний улмаас хүнсний аюулгүй байдал, эрүүл мэнд доройтох эрсдэлтэй. Эмэгтэйчүүд амьжиргаагаа сайжруулах үүднээс нэмэлт хөдөлмөр эрхэлдэг. Тухайлбал гар урлал хийх гэх мэт.

**Мэдлэг бататгах, дүгнэх зөвлөмж.**

Хичээлийн агуулга дахь олон улсын жишээгээр эмэгтэйчүүд, охид байгалийн гамшигт үзэгдэлд өртөх эрсдэл өндөр байдгийг тайлбарлаж, уур амьсгалын өөрчлөлтийн шууд болон шууд бус нөлөө жендэрийн хамааралтай эмзэг байдлыг үүсгэж байгаа талаар багуудын ажлын үр дүнгээр тодруулан дүгнэнэ. Мөн аливаа гамшигын үед яагаад охид, эмэгтэйчүүд илүү өртдөг талаар оролцогчдоос асуулт асууж ярилцаж дүгнээрэй.

**Хичээл 8. Уур амьсгалын өөрчлөлтийн нийгмийн үр дагавар ба жендэрийн ялгаатай байдал**

Хичээлийн төлөвлөгөө

Зорилт: Уур амьсгалын өөрчлөлтийн нийгмийн үр дагавар, боловсрол, хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн ялгаатай байдлын талаарх мэдлэг олгох сургалтын арга зүйд суралцах.

Товч агуулга:

- Уур амьсгалын өөрчлөлтөөс бий болсон нийгмийн асуудлууд: боловсрол, нийгмийн хамгаалал, эрх тэгш байдал
- Уур амьсгалын өөрчлөлтөөс ба иргэдийн амьжиргаа

Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Үзүүлэн (PowerPoint илтгэл)
- Ханын цаас, өнгийн цаас (наадаг), бал

Хугацаа: 60 минут

Үйл ажиллагааны төлөвлөлт:


Хугацаа /минут/	Үйл ажиллагаа	Аргачлал
20 мин	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй нийгмийн хамгааллын асуудал	Илтгэл, танилцуулга хийх
30 мин	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө ба жендэрийн үүрэг Амьжиргааны үндсэн чиглэл бүрт жендэрийн үүргийг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөн дор тодорхойлж эвлүүлэх	Карт эвлүүлэх дасгал
10 мин	Уур амьсгалын өөрчлөлт ба жендэрийн эмзэг байдал - Жендэрийн гүйцэтгэх үүргийн ялгаа, тэдгээрт нөлөөлж буй уур амьсгалын өөрчлөлтийг дүгнэх.	Сэдэв, дасгал ажлыг дүгнэх.

Мэдлэг олгох хэсэгтэй холбоотой унших мэдээлэл:

Үндэсний статистикийн хороо, олон улсын судалгааны тайлангаар Монгол улсын хүн амын 30 хувь нь ядуу ангилалд хамрагдаж байгаа бөгөөд ядуурал

нэмэгдэхэд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшиг ихээхэн нөлөөлж байна. Сүүлийн 20 гаруй жилд тохиолдсон ган, зудны уршгаар хөдөө, орон нутгийн малчин өрхүүд малаа олноор алдаж, амьжиргаагаа залгуулах үүднээс хот, төвлөрсөн газар бараадах явдал олширсон (NDC, 2020). Уур амьсгалын өөрчлөлтөд зөвхөн хөдөөгийн иргэд төдийгүй хот суурин газрын иргэд адил өртдөг. Тухайлбал үер усны гамшиг, хөрсний гулсалт, хэт хуурайшилт, бохирдол зэрэг олон эрсдэлүүдтэй нүүр тулдаг. Энэ бүхэн нь хот, хөдөөгийн иргэд гэр орон нь сүйдэх, амьжиргаа доройтох, хүнсний аюулгүй байдал алдагдах зэргээр шууд сөрөг нөлөө үзүүлдэг бол өөрсдийн болон хүүхдүүдийн сурч боловсрох нөхцөл алдагдаж, эрүүл мэндийн аюулгүй байдалд эрсдэл учрах зэрэг шууд бус үр дагавар бий болно. Хэрэв одоогийн байдлаар шинээр бий болох уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилт, цөлийн нөхцөлд зохицуулан өөрчилж чадахгүй бол уур амьсгалын дулааралт монгол орны эдийн засаг, нийгмийн амьдрал, нүүдлийн соёл иргэншилд хүчтэй цочрол үзүүлж болзошгүй ажээ.

Байгалийн үр өгөөжөө шүтэж амьдардаг манай хөдөөгийн иргэд уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг өртөмтгий бөгөөд цаг агаарын гамшигт үзэгдэл, олон жил дараалсан ган зуд зэрэгт өртөн амьжиргаа орлогынхоо гол эх үүсвэр болсон мал сүргээ алдах, улмаар зам харгуй цасанд боогдох зэргийн улмаас эрүүл мэнд, эмнэлгийн наад захын тусламж үйлчилгээ авах



боломжгүй болох, хүүхдүүд нь сургуулиас завсардах, бүр цаашлаад хүнсний хангамж, дутагдалд орж эрүүл мэндээрээ хохирох, хот суурин газар руу шилжилт хөдөлгөөн бий болох эрсдэлийг дагуулах магадлал өндөр байгаа юм. Хот, суурин газарт шилжин ирэгсдийн тоо нэмэгдсэнээр:

- Нийгмийн үйлчилгээний хүндрэл үүсэх
- Хүн амын өвчлөл ихсэх
- Агаар, хөрсний бохирдол нэмэгдэх
- Хот орчмын бэлчээр доройтох
- Ажилгүйдэл нэмэгдэх зэрэг асуудлууд хүндэрсээр байна.

“Боловсролд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөлөл” тайлангаас...

Монгол орны цаг уурын эрс, тэс нөхцөл байдал, (өвөлдөө зудын байдал хүндрэх, түүхий нүүрсний хэт их хэрэглээнээс шалтгаалсан агаарын бохирдол), зуны улиралд хур тунадас ихээр орох (үер ус) эсвэл ган гачиг нүүрлэх (ган гачгаас шалтгаалсан хүндрэлтэй зуд) зэрэг уур амьсгалын чиг хандлага Монгол Улсын боловсролын салбарт сөрөг нөлөө үзүүлдэг болохыг энэхүү судалгаагаар тодорхойлсон. Уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн үр нөлөө нь өвлийн улиралд халтиргааны улмаас зорчиход хүндрэл үүсэх, дулааны улиралд үер, усны улмаас зам эвдрэх улмаар эрүүл мэндийн шалтгаанаар (өвлийн улиралд) хичээл таслах, сургууль завсардах зэрэг нь боловсролын хамран сургалтад сөрөг үр дагавар үүсдэг болохыг тодорхойлсон. Эдгээр хүчин зүйлс нь сургуулийн хамран сургалт буурах хүчин зүйл болж улмаар сурлагын амжилтад шууд нөлөө үзүүлдэг. Малчин өрх хүүхдээ сургуульд сургах, орлого олох нь цаг уурын нөхцөлөөс хамааралтай байна. Мөн сургуулийн цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, хоол хүнсний аюулгүй байдал хангалтгүй, эрчим хүчний хангамж зэрэг асуудал уур амьсгалаас шалтгаалсан гамшгийн үед сурагчдын суралцах, эрүүл амьдрахад нөлөөлөх хүчин зүйл гэж сургуулийн удирдлагууд үзсэн байна.

Дэлхийн хүний хөгжлийн тайланд тодорхойлсноор уур амьсгалын өөрчлөлтөөс хүний хөгжилд нөлөөлж, хөгжлийг зогсоож сааруулах таван гол нөхцөл байна гэж үзжээ. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, хүнсний аюулгүй байдал
2. Усны хомсдол, аюулгүй байдал
3. Далайн түвшний нэмэгдэх, уур амьсгалаас үүдэлтэй гамшигт өртөмтгий байдал
4. Экосистем ба биологийн олон янз байдал
5. Хүний эрүүл мэнд багтана.

Монгол улсын эдийн засгийн голлох салбаруудад мал аж ахуй, газар тариалан, дэд бүтэц, эрчим хүч, уул уурхай болон аж үйлдвэрийн салбарыг хамруулдаг. Уг салбаруудын үйл ажиллагаа уур амьсгалын өөрчлөлтөөс хараат болох нөхцөл жилээс жилд илүү нэмэгдэж байна. Монгол орны хувьд бэлчээрийн мал аж ахуй нь улс орны эдийн засгийн чухал салбар төдийгүй хөдөөгийн иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр болдог. Улсын хэмжээнд 2018 оны байдлаар нийт 67.8 сая мал байгаагийн 98.9% нь бэлчээрийн маллагаатай. Уур амьсгалын өөрчлөлт, хэт халуун цаг агаарын улмаас бэлчээрийн ургац хомсдож бэлчээрлэх нөхцөл муудан, малын тарга хүчээ авахад сөргөөр нөлөөлөх нь мал аж ахуйн бүтээмж буурахад хүргэж байна.

Амьжиргаа. Хөдөөгийн иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй бөгөөд нутгийн уулархаг хойд хэсэгт сарлаг, хонь, ямаа; төвийн бүс тал нутагт үхэр, хонь, ямаа; говийн бүсэд гол төлөв тэмээ малладаг. Ер нь зудын үеэр ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд (ялангуяа хөвгүүд) гэр бүлдээ туслах хүлээлттэй байдаг. Зудын үед (2000, 2010 оны) хүүхдүүд найман долоо хоног хүртэл сургуульдаа явж чадаагүй байна. Хүүхдүүд уламжлал ёсоор мал төллөлтийн үеэр (3 дугаар сард) гэр бүлдээ тусалдаг. Тэд ихэвчлэн ундны ус зөөх, мал услах, ус татах, гэр орны ажил, дүү нараа асрах, мал аж ахуйд туслах зэрэг ажил хийдэг байна. Эдгээр ажлыг хүүхдүүд сурагчдын улирлын амралт (нэгээс хоёр долоо хоног хүртэл үргэлжлэх)-ын үеэр хийдэг тул хичээл тасардаггүй байна. Гэсэн хэдий ч хүйтний улирал удаан үргэлжилснээр цас, мөсний хайлалт удааширч сургууль руу зорчиход эрсдэл учруулж байна. Мөн өвөлжилт хүндэрсэн үед хүүхдүүд гэртээ ажлын их ачаалалтай байсны улмаас сургуульдаа ядарсан байдалтай ирдэг нь тэдний сурах үйлд нөлөөлдөг гэжээ.

*Боловсролд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөлөл, 2019*

**Нэмэлт ашиглах материал:**

1. UN-REDD үндэсний хөтөлбөрийн талаарх олон нийтийн санаа бодол, ойлголтыг тодруулах суурь судалгаа-2016, MMCG
2. Монгол Улсын бэлчээрийн тогтвортой байдал: Малчдын амьжиргаа ба уур амьсгалын өөрчлөлт, 2014, Азийн хөгжлийн банк
3. Боловсролд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөлөл, 2019, Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан

**Дасгалын хэрэглэгдэхүүн:**

Дасгал 1. “Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө ба жендэрийн үүрэг” карт эвлүүлэх

1. Гишүүн бүрт хоёр өнгийн наалддаг цаас (карт) тараах
2. 1 өнгөнд эрэгтэй хүмүүсийн ажил үүрэг, тэдгээрт нөлөөлж байгаа уур амьсгалын өөрчлөлтийг тодорхойлно. Нөгөө өнгөөр эмэгтэй хүмүүсийн ажил үүрэг, тэдгээрт нөлөөлж байгаа уур амьсгалын өөрчлөлтийг тодорхойлно.
3. Дараах хүснэгтэнд хуваасны нэгэн адилаар бүлэглэсэн ханын цаас (флипчарт)-нд оролцогчид картаа байршуулна.
4. Жендэрийн гүйцэтгэх үүргийн ялгаа болон тэдгээр нөлөөлж байгаа уур амьсгалын өөрчлөлтийг харьцуулан хэлэлцэх.

Салбар	Жендэрийн үүрэг		Уур амьсгалын нөлөө	Жендэрийн эмзэг байдал
Усны нөөц	Эрэгтэй			
	Эмэгтэй			
Хүнсний хангамж	Эрэгтэй			
	Эмэгтэй			
Амьжиргаа	Эрэгтэй			
	Эмэгтэй			

**Дасгалын жишээ:**

Үр дүн	Жендэрийн асуудал
Амьжиргаа, орлогын эх үүсвэрийн тодорхойгүй байдал	Хөрөнгө мөнгө бага, аюулгүй байдал (эрүүл мэнд, нийгмийн даатгал) дутмаг, хүүхэд асрах, өндөр настны болон өвчлөлийн үйлчилгээ байхгүй тохиолдолд ажиллах боломж хомс, хөдөө орон нутаг болон буурай хөгжилтэй бүс нутагт хөдөлмөр эрхлэх боломж хомс зэргээс шалтгаалан эмэгтэйчүүд ядууралд өртөх эрсдэл өндөр байна.
Ундны ус, эрчим хүчний дутагдал	Цалингүй, гэрийн ажил хийдэг эмэгтэйчүүд эрчим хүч, усны нөөцөөс шууд хамааралтай: жишээлбэл, цахилгаангүй бол эмэгтэйчүүдийн гар ажиллагаа нэмэгддэг, ус байхгүй бол



	эмэгтэйчүүд хоол хийх, угаалга хийхдээ зөөврийн ус хэрэглэнэ; Ганцаараа амьдардаг хөгшин, настай эмэгтэйчүүд өвлийн улиралд түлээ бэлтгэхэд бэрхшээлтэй.
Шилжилт хөдөлгөөн	Нүүдэллэж, шилжин суурьшиж байгаа эмэгтэйчүүд, хүүхдүүд эрэгтэй хүмүүстэйтэй харьцуулахад эмзэг, хүн худалдаалах, бэлгийн болон бусад төрлийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэл өндөртэй, боловсрол эзэмших, үйлчилгээ авах ямар ч боломжгүй байдаг. Нөгөөтэйгүүр, эрэгтэйчүүд эдийн засгийн шилжилт хөдөлгөөн хийх үед эмэгтэйчүүд хүүхдүүдтэйгээ ганцаараа үлддэг нь тэднийг ядуурал, нийгмээс тусгаарлагдмал байдалд өртөмтгий болгодог.

**Мэдлэг бататгах, дүгнэх зөвлөмж.**

Уур амьсгалын өөрчлөлт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд нь сөрөг үр дагавартай боловч зарим үр дагавар нь өөр байх тохиолдол байгааг агуулга, дасгалын үр дүнгээр дүгнэнэ. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дасан зохицох, нөхөн сэргэх хэрэгцээ, стратеги, боломжууд өөр өөр байдаг. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход эмэгтэйчүүд төдийгүй эрэгтэйчүүд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаар бэлтгэлтэй байх, тоног хэрэгслийн бэлэн байдлыг хангах, мэдээлэлтэй байх нь чухал бөгөөд дасан зохицох арга хэмжээний судалгаа, бэлтгэл ажил нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн сонирхол, хэрэгцээ, чадавхыг харгалзсан байх ёстой.

Сургалтын цаг хангалттай байх тохиолдолд сэдвийн хүрээнд Монгол орны нөхцөл, сургалт явагдаж буй аймаг орон нутгийн онцлогийг харгалзан, УАӨ-ийн нөлөө эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших нөхцөл хангагдаж байгаа эсэх талаар бодит жишээгээр хэлэлцэж болно.

## Хичээл 9. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн байгаль орчин, эдийн засгийн төлөвлөлт, жендэрийн оролцоо

Хичээлийн төлөвлөгөө

Зорилт: Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн байгалийн нөөцийн хомсдол, доройтол, гамшигт үзэгдэл болон байгалийн нөөц ашиглалтын төлөвлөлтөнд жендэрийн тэгш оролцоог хангах мэдлэг олгох сургалтын арга зүйд суралцана.

Товч агуулга:

- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй биосферийн асуудлууд
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэж байгаа гамшигт үзэгдлийн асуудлууд
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгаль орчны доройтол, эдийн засгийн асуудлууд
- Эдийн засгийн гол салбаруудад үзүүлэх үр нөлөө

Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Үзүүлэн (PowerPoint илтгэл)
- Ханын цаас, өнгийн цаас (наадаг), бал
- Уур амьсгалын өөрчлөлт ба гамшигт үзэгдэл  
<https://fb.watch/kNE3zXLhZ4/>

Хугацаа: 80 минут

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Хугацаа /минут/	Үйл ажиллагаа	Аргачлал
30 мин	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудал	Презентаци, танилцуулга хийх
30 мин	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө ба жендэрийн үүрэг Орон нутгийн бодлого төлөвлөлтөд жендэрийн оролцоог дээшлүүлэх талаар оролцогчдын санал цуглуулах	Оюуны бичиглэл дасгал
20 мин	Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай эдийн засгийн асуудал - Гамшигт нэрвэгдсэн мал аж ахуйн эрсдлийн үнэлгээ - Үүнээс улбаалсан нийгмийн асуудал, эрүүл мэнд	Бодит түүх ярих дасгал ажил Сэдвийн нэгдсэн дүгнэлт хийх.

Мэдлэг олгох хэсэгтэй холбоотой унших мэдээлэл:

**Биосфер** бол дэлхийн амьд бүхнийг агуулсан мандал юм. Биосферийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар ангилсан. Үүнд:

- Амьд бодис (амьд биес). Орчин үеийн бүх амьд организмын нийт биомасс бол биосферийн үндсэн гол бүрэлдэхүүн буюу амьд биес юм.
- Биоген бодисууд. Амьд организмаас шууд үүссэн биологийн гаралтай бодисууд хамаарна. Тухайлбал, амьд биесийн бүх төрлийн ялгадас, хүлэр, нүүрс, газрын тос гэх мэт.
- Биологийн бус гаралтай бодисууд. Амьд биесийн оролцоогүйгээр, дэлхийн геологийн хүчний үйлчлэлээр үүсч бүрэлдсэн уулын чулуулаг, эрдэс нэгдлүүд, хур тунадас зэрэг бодисууд багтана.
- Харилцан үйлчлэлийн гаралтай бодис. Амьд биесийн амьдралын үйл ажиллагаа болон биологийн бус гаралтай бодисын харилцан үйлчлэлээр үр дүнд үүссэн ус, хөрс, өгөршлийн давхрага зэрэг бодисууд орно.
- Цацраг идэвхт задралын бодисууд. Цацраг идэвхт задралын үр дүнд үүсэн бодисууд (Жишээ нь уран зэрэг цацраг идэвхт элемент, тэдгээрийн изотопууд) Солир, тоосонцор зэрэг хэлбэрээр тохиолдох сансрын гаралтай бодисууд, сансрын төрөл бүрийн цацраг, дэлхийн бөмбөрцөгөөс сарнисан атомууд, цацраг идэвхт задралын үр дүнд үүссэн бодисууд багтана.

Биосферийн бүрэлдэхүүнийг геологийн болон биологийн эргэлтийн үр дүнд оршин тогтнодог гэж үзсэн.

Дэлхийн экологийн тулгамдсан асуудал дотор биологийн олон янз байдал буурах, төрөл зүйл хомсдох, удамшил буюу генийн сан доройтох зэрэг асуудал онцгой байр эзэлж байна. Дэлхий дээрх биологийн төрөл зүйл 10-20 сая зүйлээр тооцогдох боловч энэ нь сүүлийн жилүүдэд эрс багасч байна. Америкийн эх сурвалжаас үзэхэд өнгөрсөн 200 жилийн хугацаанд дэлхий дээр 900 мянган ургамал, амьтны зүйл алга болжээ. XX зууны хоёрдугаар хагас, XXI зуунаас эхлэн генийн санг хамгаалах ажил эрчимтэй явагдаж ирлээ. Дэлхийн дундаж температур 1°C-ээр нэмэгдэхэд нийт зүйлийн 10 орчим хувь нь буурна гэж тооцсон байдаг (IPCC, 2007). Дэлхийн ургамал, амьтдын төрөл зүйл мөхөж үгүй болох болон тодорхой орчинд амьдарч буй төрөл зүйлийн бууралт, мөхөж үгүй болох бүхий л үйл явцыг нийтэд биологийн төрөл зүйлийн хомсдол гэнэ. Сүүлийн жилүүдэд биологийн төрөл зүйлийн хомсдол байгалийн хуулиас мянга дахин хурдтай явагдаж байна. Дэлхий дээр өдөрт 130 зүйл устаж байна.

Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай байгалийн гамшигт үзэгдлийн шинж чанар, давтамж өөрчлөгдөж байна. Гамшиг гэдэгт аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно. Байгалийн гамшиг



гэдэг нь харьцангуй томоохон нутаг дэвсгэрийг хамарсан байгаль, цаг уурын аюулт үзэгдэл тохиолдсоны улмаас хүний амь нас осолдох болон материаллаг баялгийн ихээхэн хохирол учирч нийгэм, эдийн засгийн хэвийн үйл ажиллагаанд ноцтой бэрхшээл учрахыг хэлнэ. Аюулт үзэгдэл гэдэгт хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэрэг багтана.

Байгалийн гамшигт үзэгдэл, ган, зудын давтамж ойртон, эрсдэл улам нэмэгдэж байгаа нь малын зүй бус хорогдол ихсэхэд хүргэнэ. Монгол орны газар тариалангийн үйл ажиллагаа усалгаагүй, хур борооноос хамааралтай учир уур амьсгалын өөрчлөлтөд маш эмзэг, өртөмтгий салбарын нэг болж байна. Ургамлын ургалтын үе шатны дулаан, чийгийн хангамж хэвийн хэмжээнд хүрэхгүй байх, эсвэл хэтрэх нь уур амьсгалын өөрчлөлтийн газар тариаланд үзүүлж буй нэг том нөлөө юм. Ган ихээхэн том талбайг хамарч

ажиглагдах тул үр тарианы ургацын хэмжээг 10-20%, онц их гантай жил 40% хүртэл алдагдуулна. Нөөлөг салхи, хүчтэй аадар хавсарч орвол таримал ургамал налах үр дагавартай. Мөндөр хүчтэй аадар борооны улмаас таримал ургамал сүйдэж ихээхэн хохирол амсана. Хавар, намар цочир хүйтрэлээс болж ихээхэн хөнөөл учруулна. Хүчтэй шороон нуурганы улмаас ургамал, элс шороонд дарагдаж механик гэмтэлд орох ба хавар намрын зүсэрсэн бороо суулгацыг угаах аюултай.

### **Уур амьсгалын өөрчлөлт ба байгаль орчин**

Байгаль болон нийгэмд шаардлагатай экосистемийн үйлчилгээ, гүйцэтгэх үүрэг, бүтээгдэхүүнээр хангах газрын чадамжийн буурсан өөрчлөлтийг газрын (эсвэл хөрсний) доройтол гэж тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл хөрсний үржил шим муудах, элэгдэл, эвдрэлд орох, бохирдох, бэлчээр талхлагдаж анхны шинж чанараа алдахыг хөрсний доройтол гэнэ. Газрын доройтлын байгалийн хүчин зүйлийн томоохон илрэл нь уур амьсгалын өөрчлөлт, дулаарал бөгөөд нийгмийн хүчин зүйлстэй хавсран бэлчээрийн доройтол, цөлжилтөд хүргэх том шалтгаан болно. Тухайлбал бэлчээрийн доройтол дараах шалтгаанаас үүснэ.

- Бэлчээрийн даац хэтэрсэн
- Бэлчээрт малыг удаан хугацаагаар сул чөлөөтэй бэлчээрлүүлдэг
- Бэлчээр нийтийн эзэмшилд байгаа
- Бэлчээр сэлгэх нүүдэл цөөрч, нүүх зай богиноссон
- Бэлчээрийн талхлагдлын төлөө хариуцлага хүлээлгэх, хүлээх хууль, эрх зүйн механизм бүрдээгүй
- Зах зээл бараадсан их нүүдлийг төрөөс зохицуулах арга хэмжээ авахгүй байгаа
- Бэлчээрийн усан хангамж дутмаг
- Алтны төлөөх улайрсан тэмцэл, үйлдвэржилт
- Авто замын эмх замбараагүй сүлжээ
- Тариалангийн талбайг хаяж ашиглалтгүй болгосон.

“Жендэр судлал” Эрдэм шинжилгээний сэтгүүл №4, 2021 хуудас 54-72

... Нүүдлийн мал аж ахуйн уламжлалд малчид хот айл, нэг голынхон зэрэг зохион байгуулалттай хөдөлмөрөөр хорших, нэгдэх, харилцан хамтран тусалж дэм дэмэндээ амьдарч ирсэн түүхтэй. Уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтол, байгалийн гамшиг, хөдөөгийн хүн амын шилжилт, амьжиргааны нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан малчид зохион байгуулалтад орж малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоо байгуулж

ажиллах болсон бөгөөд малчдын бүлгийн үйл явцыг хоёр бүсийн хэмжээнд харьцуулан судлав. Судалгааны үр дүнгээр хангайн бүсийн малчдын бүлгийн гишүүд оролцоо сайтай, хамтран ажиллаж орлогоо тэгш хуваарилан ажилладаг, бүлэг дүрэм журмаа сайтар тодорхойлж, түүнийгээ олонх нь мэддэг, мөрддөг гэжээ. Харин говийн бүсийн малчдын бүлгийн гишүүдийн идэвх, оролцоо, хамтран ажиллах байдал дутмаг, бүлэг дүрэм журмаа сайн боловсруулсан ч үүнийг мэдэж, дагаж мөрдөх нь учир дутагдалтай байна.

... Малын тоо толгойг цаашид хэрхэн төлөвлөж байгаа байдал нь бүлгийн зохион байгуулалтын хувьд ялгаатай байгаа ба аль, аль бүсийн экосистемд бүлгийн гишүүн бус эмэгтэй малчид илүү олон тооны малтай болохыг эрмэлзэж байгаагаа илэрхийлжээ. Харин аялал жуулчлалд оролцоотой хангайн бүсийн эмэгтэй малчид хамгийн бага малын тоо толгойг төлөвлөсөн байна.

### **Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ ба жендэрийн оролцоо**

Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавраас урьдчилан сэргийлэх нь эдийн засаг, ойн аж ахуй, хөдөө аж ахуй, хот төлөвлөлт, барилга байгууламж, эрчим хүч, усны менежмент болон бусад байгалийн нөөцийн салбарт баримтлах бодлого боловсруулан хэрэгжүүлэхийг хэлнэ.

#### *- Хөдөө аж ахуй*

Эмэгтэйчүүдийн цөөн хувь нь хөдөө аж ахуйн хөрөнгийн эзэд байдаг бөгөөд ихэнхдээ өрхийн гишүүдэд туслах үүрэгтэй. Уур амьсгалын өөрчлөлтийн мал аж ахуй, газар тариалан (хүнсний ногоо тариалалт)-гийн үйлдвэрлэлд үзүүлэх сөрөг нөлөөллийн улмаас эмэгтэйчүүд ядууралд ихээхэн өртөх болдог. Холбоо юмуу хоршооны гишүүн эмэгтэйчүүд дасан зохицох арга хэмжээний талаар чухал шийдвэр гаргах нь ховор (жишээ нь бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад оролцох).

#### *- Усан хангамж*

Эмэгтэйчүүд бие бялдын хувьд сул дорой тул ус хомсдох үед эрчүүдээс хамааралтай болдог. Усны хомсдол нь хоол хийх, ариун цэвэр сахих гэх мэт өдөр тутмын үйл ажиллагаанд нэмэлт хүчин чармайлт шаардах болдог тул эмэгтэйчүүдийн хувьд эрэгтэйчүүдээс илүү их үр нөлөө хүртдэг.

- Хот суурин газрын төлөвлөлт

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага, эмэгтэй зөвлөхүүд нийгмийн асуудалд оролцох явдал байдаг, хотын төлөвлөлт, ялангуяа дэд бүтэц, зам тээвэр, эрчим хүчний чиглэлээр ажлын хэсэгт эмэгтэй гишүүд маш ховор байдаг. Барилга, гудамж, гарц гэх мэт засварын ажлыг төлөвлөхдөө эмэгтэйчүүдийн голлон ашигладаг үйлчилгээнд тэргүүлэх ач холбогдол өгөх нь ховор.

**Нэмэлт ашиглах материал:**

1. UN-REDD үндэсний хөтөлбөрийн талаарх олон нийтийн санаа бодол, ойлголтыг тодруулах суурь судалгаа-2016, ММСГ
2. Youtube бичлэг: GAGGA, МОНЭС “Уур амьсгалын өөрчлөлтөд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг дээшлүүлэх нь” төсөл (<https://www.youtube.com/watch?v=d6ErPEqU2lo>)
3. “Жендэр судлал” Эрдэм шинжилгээний сэтгүүл №4, 2021 хуудас 54-72

**Дасгалын хэрэглэгдэхүүн:**

*Жич: Оролцогчдын оролцоо, орон нутгийн нөхцөл байдал, сургалтын хугацааг харгалзан гурван дасгалаас хамгийн боломжтойг сонгож ажиллана.*

**Дасгал 1.** Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай нийгэм-эдийн засгийн асуудал

Оролцогчид өөрсдийн болон нутгийн малчид юмуу тариаланчдын түүхийг ярилцаж дүгнэх. Үүний тулд сүүлийн 10 жилд нутагт нь болсон гамшигт үзэгдлийн үед бий болсон нийгэм, эдийн засгийн хохирлыг ярилцана. Жишээ нь:

- Үер, ус
- Салхи шуурга
- Цагаан, хар зуд
- Мөндөр, аадар
- Бэлчээр, тэжээлийн хомсдол гэх мэт

Эдгээр гамшгаас улбаатай малчин болон тариаланч өрхийн сэтгэл санаа, эрүүл мэндэд өөрчлөлт орсон эсэх талаар тодруулж дүгнэнэ.

**Дасгал 2.** “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах жендэрийн мэдрэмжтэй бодлого, арга хэмжээ” дүрд тоглох.

- Сургагч багшийн зүгээс <Уур амьсгалын өөрчлөлтийн сааруулах аливаа бүлэг (малчдын бүлэг), нэгдлийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн манлайллыг хэрхэн нэмэгдүүлэх вэ?> гэсэн асуултыг оролцогч нарт тавина.
- Сургалт явуулж байгаа орчны нөхцөлд тохируулан бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах малчдын бүлэг, гэр хорооллын бүсэд ногоон сууц байгуулах бүлэг, “Тайгын бэрүүд” байгаль хамгааллын зохион байгуулалтын жишээн дээр ажиллаж болно. (Оролцогчид хэд хэдэн бүлэг болон хуваагдаж жишээ тус бүр дээр ажиллах боломжтой.)
- Багууд аймаг, орон нутгийн түвшинд эмэгтэйчүүдийн манлайллыг бий болгоход тулгамдаж байгаа асуудал, үүнийг хэрхэн даван туулж болох талаар тухайн дүрд орж, шийдвэр гаргах байр сууриа хэрхэн дээшлүүлэх талаарх үндэслэл, боломжийг тодруулж хэлэлцэнэ.

**Дасгал 3.** “Бэлчээр төлөвлөлтөн дэх жендэрийн оролцоог тодорхойлох” оюуны бичиглэл дасгал

*Сургагчийн зүгээс чиглүүлэх мэдээлэл*

- Эмэгтэйчүүд, охид гамшгийн менежмент юмуу уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох орон нутгийн нэгдэл, бүлэгт оролцох нь хязгаарлагдмал байдаг. Ямар нэгэн хязгаарлалтгүй байлаа ч цаг зав хомс байдгаас оролцох боломжгүй байдаг.
- Малын данс бүртгэл, газар өмчлөл нь голдуу гэрийн эзний нэр дээр байдаг тул эмэгтэйчүүд шууд шийдвэр гаргаж чадахгүй байх ч явдал тулгарч болзошгүй.
- Байгалийн нөөц ашиглалтын бодлого, төлөвлөгөө боловсруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагаанд эмэгтэйчүүд эрчүүдээс илүү шийдвэр гаргах орон зай, нөлөөлөл багатай байдаг. Энэ нь эмэгтэйчүүдийн дасан зохицох чадварыг улам бүр сааруулна.

Оролцогчид бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулахад жендэрийн оролцоог тодорхойлж, тэгш оролцоог хангах боломж бий эсэхийг хэлэлцэх.

Дасгалыг ажиллахдаа өнгө өнгийн цаасанд дараах асуултыг бичиж, хүн нэг бүрээр санал бичүүлнэ.

1. **Бэлчээр ашиглалтын төлөвлөлтөд эмэгтэйчүүд хэрхэн оролцох вэ?**
2. **Мал аж ахуйг эрчимжүүлэх ажилд эмэгтэйчүүд хэрхэн оролцох вэ?**



3. Малчдын бүлэг, хоршоо хөгжүүлэхэд эмэгтэйчүүд хэрхэн оролцох вэ?
4. Өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд эрэгтэйчүүд хэрхэн оролцох вэ?
5. Өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд эмэгтэйчүүд хэрхэн оролцох вэ?

- Сургагч багшийн зүгээс оролцогч нарт асуулт бүхий цаасаа танилцуулж, 1-2 минутад багтаан оролцогч тус бүр нэг санаа бичнэ.
- Дараа нь оролцогч тус бүр санал бичсэн цаасаа өөрийн баруун гар талын хүндээ дамжуулж, зүүн талаас ирсэн цаасан дээрээ 1 минутад багтаан дахин нэг санааг давхардуулахгүй байдлаар бичиж даалгавар гүйцэтгэнэ. Ингэж аль болох олон шинэ санаа гаргах байдлаар ажиллуулах хэрэгтэй.
- Дасгалыг бүх санаагаа бичиж дуустал үргэлжлүүлэхийг зөвшөөрч болно.
- Оюуны бичиглэлийн дасгал ажилласны дараа дүгнэлт хийх нь маш чухал бөгөөд бүлгээрээ нийт хэчнээн санаа цуглуулснаа дүгнэж хэлэлцэнэ.

Дасгал ажилласны дараа өнгө, өнгийн цаас бүр дээр тодорхойлсон өөр, өөр санааг уншиж танилцуулах бөгөөд нийгмийн бүлэг бүр аливаа асуудалд идэвхтэй оролцоотой байх нь ямар ач холбогдолтой болохыг тодруулж өгөх нь чухал.

**Хичээл 10. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, өөрчлөлтөд дасан зохицох жендэрийн мэдрэмжтэй бодлого, арга хэмжээ**

Хичээлийн төлөвлөгөө

*Зорилт:* Уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний асуудал, уур амьсгалын өөрчлөлтийн сааруулах, уур амьсгалын өөрчлөлтөд нийгэм-эдийн засгийн салбарын дасан зохицох жендэрийн мэдрэмжтэй бодлого, арга хэмжээ явуулах талаар мэдлэг олгох сургалтын арга зүйд суралцана.

Товч агуулга:

- Уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэл
- Эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ
- Хүлэмжийн хийн ялгарлын голлох салбаруудын урт хугацааны төлөвлөлт
- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах жендэрийн мэдрэмжтэй бодлого, арга хэмжээ
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуй
- Дасан зохицохуйн стратеги
- Гамшгийн эрсдлийг бууруулах жендэрийн асуудал

Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Үзүүлэн (PowerPoint илтгэл)
- “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвах бүхий хотын шинэчлэл салбарын төсөл” МОНЭС, 2022
- Ханын цаас, өнгийн цаас, маркер

Хугацаа: 80 минут

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Хугацаа /минут/	Үйл ажиллагаа	Аргачлал
35 мин	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах бодлого, арга хэмжээ Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, арга хэмжээ	Презентаци, танилцуулга хийх
40 мин	Сааруулах бодлого, арга хэмжээ болон жендэр хоорондын уялдаа холбоог тодорхойлох,	Дүрд тоглох; Бие биедээ туслах арга ашиглан

	Уур амьсгалын өөрчлөлтийн сааруулах бодлогыг жендэрийн мэдрэмжтэй явуулах талаар дасгал ажиллах, Жендэрийн мэдрэмжтэй дасан зохицох бодлого, арга хэмжээ тодорхойлох.	тодорхой сорилтуудыг шийдвэрлэх.
5 мин	Бататгах асуулт	Сэдэвтэй холбоотой асуултад хариулах.

Мэдлэг олгох хэсэгтэй холбоотой унших мэдээлэл:

Хүн төрөлхтөний өмнө уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, сөрөг нөлөөллийг бууруулахын зэрэгцээ түүнд дасан зохицох зайлшгүй шаардлага тулгарч байгаа билээ.

Эрчим хүч, аж үйлдвэрлэл, хөдөө аж ахуй болон бусад салбарын хөгжилтэй үндсэндээ холбоотойгоор уур амьсгалд хамгийн хүчтэй нөлөөлөх хүний үйл ажиллагааны хүчин зүйл нь органик гаралтай түлшний шаталтын улмаас CO<sub>2</sub>, N<sub>2</sub>O, O<sub>3</sub> болон бусад хийнүүд хаягдсанаар агаарын хийн найрлагыг өөрчлөх боллоо. Хүний үйл ажиллагааны явцад агаарын хийн найрлагыг өөрчлөх замаар агаар мандлын цацрагийн горимыг өөрчлөн дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд хүргэж байгаа тухай асуудал орчин үеийн уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн асуудал болоод байгаа бөгөөд энэ нь цаашид хүн нийгмийн үйлдвэрлэлийн чиглэлийг ямар нэгэн хэмжээгээр тодорхойлох нийгэм – эдийн засаг, улс төрийн асуудал болоод байна.

Агаар мандалд ялгарах хүлэмжийн хийн хэмжээ нь үндсэндээ үйл ажиллагааны цар хүрээ болон бүтээгдэхүүний тоо хэмжээнээс хамаарна. Нэгж үйл ажиллагаа тутамд хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолохдоо ялгарлын коэффициент (emission factor EF) гэж нэрлэгдэх үржүүлэгчийг ашиглах шаардлагатай болно. Үйл ажиллагааны өгөгдлийг хүлэмжийн хийн ялгаралд хөрвүүлэх тэр үржүүлэгчийг ялгарлын коэффициент гэнэ. Энэ нь нэгж үйл ажиллагаа эсвэл процессийн үед өгөгдсөн эх үүсгүүрээс ялгарах хүлэмжийн хийн ялгарлын дундаж хэмжээ юм. Үйл ажиллагааны өгөгдлийг хүлэмжийн хийн ялгаралд хөрвүүлэх тэр үржүүлэгчийг ялгарлын коэффициент гэнэ. Энэ нь нэгж үйл ажиллагаа эсвэл процессийн үед өгөгдсөн эх үүсгүүрээс ялгарах хүлэмжийн хийн ялгарлын дундаж хэмжээ юм.

Цахилгаан болон дулааны үйлдвэрлэл (Дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 25 гаруй хувь). Цахилгаан, дулааны зориулалтаар нүүрс, байгалийн

хий, газрын тос шатаах нь дэлхийн хүлэмжийн хий ялгаруулах хамгийн том эх үүсвэр юм.

Хөдөө аж ахуй, ой болон газар ашиглалт (Дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 24%). Тус салбарын хүлэмжийн хийн ялгарлын дийлэнх хэсэг нь газар тариалан, мал аж ахуй эрхлэх, ой устгахаас үүдэлтэй байна.

Аж үйлдвэр (Дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 21 орчим хувь). Аж үйлдвэрийн салбараас ялгарч байгаа хүлэмжийн хий үндсэндээ эрчим хүчний зориулалтаар үйлдвэр дээр шатаасан органик түлшээс үүсэлтэй байна. Энэ салбарт хими, металлург болон эрдсийн үйлдвэрлэл зэрэг эрчим хүчний бус, цаашилбал эдгээр үйлдвэрлэлийн хог хаягдлаас үүсэх ялгарал багтана.

Тээвэр (Дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 14%). Тээврийн салбарын хүлэмжийн хий нь авто болон төмөр зам, агаарын, далайн тээвэрт зарцуулж буй түлшнээс ялгарна. Дэлхийн тээврийн эрчим хүч бараг бүхэлдээ (95 хувь нь) нефтийн бүтээгдэхүүн болох бензин, дизель түлшнээс бүрддэг.

Барилгын үйлдвэрлэл (Дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 6%). Энэ салбарын хүлэмжийн хийн ялгарал барилгын үйлдвэрлэл (барилга байгууламж барих, угсрах, барилгын материал үйлдвэрлэх зэрэг)-д шаардлагатай эрчим хүч үйлдвэрлэх, барилгын дотор халаалтын эсвэл айл өрхүүд хоол хийх зорилгоор шатаасан түлш зэргээс үүсэлтэй.

Эрчим хүчний бусад салбар (Дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 10 орчим хувь). Хүлэмжийн хийн ялгарлын энэ эх үүсвэр түлш олборлолт, боловсруулалт, тээвэрлэлттэй холбоотой, өөрөөр хэлбэл цахилгаан болон дулааны үйлдвэрлэлтэй шууд холбоогүй эрчим хүчний бусад салбараас ялгарах бүхий л ялгарлыг хэлнэ.

“Парисын хэлэлцээр” нь “Киотогийн протокол”-ын дараах дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар хууль ёсны хоёр дахь хэлэлцээр болсон. Хэлэлцээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулж, хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийг бий болгох, дэлхийн дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулахад 2.0 хэмээс хэтрүүлэхгүй байж улмаар 1.5 хэмд хязгаарлах зорилгыг дэвшүүлсэн түүхэн ач холбогдолтой олон улсын хэмжээний баримт бичиг юм.

**Эмзэг байдал** буюу гай гамшигт, өвчин зовлон гэх мэт эмзэг байх, өртөх, өртөмтгий гэсэн үг ойлголтууд бий. Эндээс мөн эмзэг байдлын өртөнгө гэж нэрлэх ч бий. Аль нэг системийн элдэв аюул, гай гамшгийн эвдэн сүйтгэх зэрэг сөрөг нөлөөнд өртөмтгий шинж чанар, нөхцөл байдлыг эмзэг байдал гэдэг. Тухайн системийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд өртөмтгий буюу сөрөг үр дагаварыг даван туулах чадваргүй байдлын зэрэг

юм. Нийгэм-эдийн засаг, хүн ам, экосистем, хөдөө аж ахуйн, бусад салбаруудын уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд өртөмтгий эсвэл сөрөг үр дагаварыг даван туулах чадамжгүй байдал юм. Эрсдэл (risk) гэдэг нь тухайн нөхцөл байдлаас үүсч болзошгүй үр дагаварыг тодорхойлох ойлголт юм. Аливаа аюул, гамшгийн тохиох магадлал ба тухай системийн эмзэг байдлын харилцан үйлчлэл, хам үр дагаварыг уур амьсгал, цаг агаараас үүдэлтэй гамшгийн эрсдэл (climate-related risk) гэнэ.

Эмзэг байдал, эрсдлийн үнэлгээний аргуудыг учир шалтгаанаас үр дагаварын дүн шинжилгээний арга буюу дээрээс доош чиглэсэн хандлагын арга (top-down approaches) болон доороос дээш чиглэсэн хандлагын арга (bottom-up approaches) гэж ангилна. Дээрээс доош чиглэсэн хандлагын аргын хувьд учир шалтгаан-үр дагаварын шууд харилцан хамаарлаар үнэлгээ хийнэ. Жишээ нь, хур тунадас ба ургацын хэмжээ гэх мэт хамаарлаар эмзэг байдлыг үнэлэх юм. Доороос дээш чиглэсэн хандлагын аргын хувьд тухайн өөрчлөлт, аюул гамшгийн учир шалтгаанд төвлөрөхөөс илүүтэйгээр энэхүү аюултай нөхцөлд хүмүүс яагаад эмзэг байна вэ, өртөмтгий байна вэ гэдгийг эхэлж авч үздэг.

Эмзэг байдал (vulnerability) гэдэг нь тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн байдал, иргэд (оршин суугчид)-ийн ахуй нөхцөлд учирч болзошгүй аюулд өртөгдөх, нэрвэгдэх нөхцөл байдал, байгаль орчны тэнцвэрт байдал алдагдсан, доройтсон байх нөхцөлийг илэрхийлсэн ойлголт юм. Уур амьсгалын эмзэг байдлын үнэлгээг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөх байдал (exposure), мэдрэмтгий байдал (sensitivity) ба өөрчлөлтийн нөлөөлийг зохицуулах дасан зохицох чадавх (adaptive capacity) гэсэн 3 хүчин зүйлсийн харилцан үйлчлэл болно.

Эмзэг байдал = Мэдрэмтгий байдал + Өртөмтгий байдал-Дасан зохицох чадавх

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг даван гарч улс орон нийгмийн хөгжлийг урагшлуулж, жирийн ард иргэдийн амьдрал ахуйг хөнгөвчлөхийн тулд **дасан зохицохуй** хэмээх нэр томъёо бий болж улмаар энэ нь бодлого, стратеги, бодит үйл ажиллагаа, арга хэмжээ, технологи болон хэрэгжих болсон байна.

- Дасан зохицохуй гэж уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаварыг даван туулах явцад нийгэм болон экосистемд туслах дэмжих зорилгоор авч явуулж (хэрэгжүүлж) буй үйл ажиллагаа, арга хэмжээ болно.
- Дасан зохицохуй гэдэгт өнөөдрийн бодит болон ирээдүйн уур амьсгалын хувьсал өөрчлөлт, түүний үр дагаварт хариу үйлчилж буй байгалийн болон хүний нийгмийн системийн зохицуулалт бөгөөд

энэхүү зохицуулалтаар сөрөг үр дагавар, хөнөөлийг багасгаж харин эерэг буюу таатай боломжийг үр ашигтай ашиглах явдал гэж ойлгоно.

- Дасан зохицохуй бол уур амьсгалын өөрчлөлт, уур амьсгалын хэлбэлзэлээс үүдэлтэй сөрөг, хөнөөлтэй үр дагавар, эрсдэлийг багасгах эсвэл боломжийг ашиглахад чиглэсэн үйл явц эсвэл үйл явцын үр дүн юм.

Биологийн төрөл зүйл болон экосистемийн үйлчилгээг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуйн бусад стратеги, арга технологитой нэгтгэн хэрэглэж буй дасан зохицохуйн нэгэн арга, хэлбэрийг *экосистемд түшиглэсэн дасан зохицохуй* хэмээн тодорхойлсон байдаг. Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээ гэдэгт экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүд (ус, бэлчээр, газар, ой гэх мэт)-ийн нөөц ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээх, хадгалах үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, зохион байгуулах, ашиглах замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бүрдүүлэх байдлаар хэрэгжүүлэх арга хэмжээ юм. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн арга хэмжээ авахын өмнө байгалийн юмуу, хүн нийгмийн аль нэг тогтолцооны уур амьсгалыг мэдрэх байдал, эмзэг байдлыг үнэлж, улмаар тухайн тогтолцоо уур амьсгалын өөрчлөлтөд хэр зэрэг дасан зохицож, нийцэн орших чадавхтай эсэхийг мэдэх шаардлагатай.

Мэдрэх байдал (sensitivity) буюу мэдрэмтгий байдал гэдэг нь уур амьсгалын өөрчлөлтийн үйлчлэлээр тухайн системд эерэг юмуу сөрөг ямар нэг өөрчлөлт гарах хэм хэмжээг хэлнэ. *Эмзэг байдал буюу өртөх байдал* гэж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаварт тухайн тогтолцоо өртөмтгий, өөрчлөгдөн хувьсах, эрс тэс шинжтэй уур амьсгалын өөрчлөлтийн таагүй нөлөөллийг даван туулах чадваргүй байдлыг ойлгоно.

Дасан зохицох чадвар (adaptive capacity) гэж уур амьсгалын өөрчлөлтөд тухайн тогтолцооны дасан зохицох чадавх буюу тухайн тогтолцоонд учирч болох болзошгүй хохирлыг багасгах, бий болсон аятай таатай нөхцөлийг илүү үр дүнтэй ашиглах, эсвэл сөрөг үр дагаврыг даван туулах чадвар юм. Дасан зохицохуйн стратегийн дараах хэлбэрүүд байж болно.

- учирч болох хохирлыг урьдчилан зайлуулах
- тодорхой хохирлыг хүлцэн зөвшөөрөх
- учирч болох хохирлыг хуваарилах буюу бүс нутгийн нэг хэсэгт нь хохирол учрахад нөгөө хэсэгт ашигтай байхаар зохицуулалт хийх
- үйл ажиллагааны хэлбэрээ өөрчлөх
- шилжилт: уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавар давагдашгүй болсон тохиолдолд нүүн шилжих, нөхөн сэргээх, уур амьсгалын

өөрчлөлтөд өртсөн объектыг хуучин хэвэнд нь оруулах эсвэл бага өртөхөөр төлөвлөх зэрэг болно.

Дасан зохицох арга хэмжээг ерөнхий байдлаар нь авч үзвэл:

- эрхзүйн зохицуулалт хийх
- санхүүгийн арга хэмжээ
- эдийн засгийн арга хэмжээ
- технологийн арга хэмжээ
- боловсрол, соён гэгээрүүлэх арга хэмжээ,
- шинжилгээ судалгаа, боловсон хүчин бэлтгэх гэж ангилж болно.

Уур амьсгалын өөрчлөлтөд нийгэм-эдийн салбарын дасан зохицолыг ус, эрчим хүч, газар тариалан, мал аж ахуй, дэд бүтэц, нийгмийн эрүүл мэнд гэж ангилж үзнэ.

Эрчим хүч: цөмийн болон дулааны эрчим хүч үйлдвэрлэдэг салбарын хувьд хөргөлтийн технологи, хуурай технологи зэрэг дасан зохицолын арга, технологийн асуудлыг хөнддөг. Салхи, нар зэрэг сэргээгдэх эрчим хүчний хувьд зөв оновчтой байршил сонгох, хамгаалалт, дизайн, технологитой холбоотой дасан зохицол шаардагдана.

Газар тариалан: газар тариалангийн үйлдвэрлэлийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төрийн бодлогын стратегийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийн эерэг нөлөөллийг үр ашигтай бүрэн ашиглах, сөрөг нөлөөллөөс гарч болох эрсдлийг аль болох сааруулах замаар тариалангийн гаралтай хүнс, малын тэжээлээр дотоодын хэрэгцээгээ тогтвортой, найдвартай хангахад оршино. Түүнчлэн технологиудын хувьд ган халуунд тэсвэртэй таримал, сортуудыг сонгон тариалах, тариалангийн талбайд хамгаалалтын зурвас байгуулах, усалгааны хэмнэлттэй технологиуд болох гадаргуугийн, намираа, дуслын, мананжуулах, нэвчүүлэх усалгааны систем гэх мэт арга технологиудыг ашиглана.

Мал аж ахуй: Бэлчээр, малын тоо толгой бусад онцлогийг харгалзан худаг засварлах, гадаргын усны ашиглалтыг сайжруулах түүнчлэн хөв цөөрмийн технологийн асуудлууд чухал. Мөн бэлчээр ашиглалтын зөв менежмент авч явуулах, зудын эрсдлээс сэргийлэх, байгалийн ургамлын сэргэн ургалтыг дэмжих зорилгоор бэлчээрийг аж ахуйн үйл ажиллагаанаас чөлөөлөх, хаших, өвөл болон хаврын нөөц бий болгох нь илүү үр ашигтай юм.

Нийгмийн эрүүл мэнд: Эрүүл мэндийн салбарын дасан зохицох стратеги нь анхан шатны урьдчилан сэргийлэх арга хэмжээ (халдварын эрсдэл, эмзэг байдлыг бууруулах) болон хоёрдогч шатны урьдчилан сэргийлэх арга хэмжээ (эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ)- ээс бүрдсэн байвал зохилтой. Уур



амьсгалын өөрчлөлтөөс үүдэн удаан хугацаагаар үргэлжлэх ган гачгийн үед ядуу эмзэг бүлэгт усны дутагдал, эсвэл эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаагүй ус хэрэглэсэн зэргээс шалтгаалан олон төрлийн өвчин эмгэгт өртөх магадлалтай. Эрүүл мэндийн салбарын дасан дасан зохицох ерөнхий хандлага бол нөөцийн эх үүсвэрийн сүлжээг зохион байгуулах, эмзэг байдлыг бууруулах, тулгарсан бэрхшээл хүндрэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэх зэрэг болно.

Дэд бүтэц: Дэд бүтцийн хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүргэсэн гамшиг, тухайлбал цанталт, мөстөлт, үер, цэвдгийн хайлалтаас болж зам, гүүр эвдрэх, өндөр хүчдэлийн, дулааны, цахилгааны зэрэг элдэв шугам, тулгуур, барилга байгууламжийн эвдрэл, гажилт, ган гачиг эсвэл үертэй холбогдон усан цахилгаан станцуудын хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүргэх гэх мэт нөлөөллийн эсрэг дасан зохицолын арга технологиуд байна.

Монгол улсын хувьд үр дүнтэй дасан зохицох боломж, чадавх нь экологи, нийгэм-эдийн засаг, техник технологи, засаглал, улс төрийн зэрэг олон хүчин зүйлсээс хамааран хязгаарлагдмал хэвээр байна. Уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицолтой холбоотой гарсан тогтоол шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө нь ихэнхдээ тунхаглалын шинжтэй, хэрэгжих санхүүгийн эх үүсвэргүй байдаг.



Үндэсний дасах зохицох төлөвлөгөө, Монгол улс





**Нэмэлт ашиглах материал:**

1. “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн мэдээлэл, Уур амьсгалын ногоон сан, 2022
2. “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх” NAP төсөл, 2019
3. Тогтвортой хөгжлийн зорилго (2016-2030), Үндэсний Статистикийн Газар

**Дасгалын хэрэглэгдэхүүн:**

**Дасгал 1.** “Улаан ба Цэнхэр” дүрд тоглох дасгал.

Зорилго: Асуудал хэлэлцэх, шийдвэр гаргах үйл явцад УАӨ-ийн нөлөөнд автсан бүлэг өөрсдөө оролцохын ач холбогдол болон бодлого төлөвлөлтөд жендэрийн асуудлыг тусгах шаардлага, хэрэгцээг оролцогчдод ойлгуулах.

**Алхам 1.** Оролцогчдыг гурван бүлэг болгон хуваана. Бүлгийг санамсаргүй байдлаар биш, сургагч өөрийн ажиглалтаар хуваана.

- Илүү идэвхтэй, санаа бодлоо тулгах сонирхолтой хүмүүсийг нэг бүлэг болгон “Улаан” баг гэнэ.
- Идэвх сул оролцогчдыг нэг баг болгон “Цэнхэр” баг гэнэ.
- Оролцогч дундаас дүн шинжилгээ хийх чадавхтай хүмүүсийг ажиглагчаар томилно.

**Алхам 2.** Оролцогчдад даалгаварыг танилцуулна. Тэд сумын иргэд бөгөөд Сумын Гамшгаас Хамгаалах Хороо (СГХХ) байгуулах асуудлыг хэлэлцэж,

онцгой байдлын анхаарах гол гурван чиглэлийг тодорхойлох юм. Улаан болон Цэнхэр багуудын үндсэн мэдээллийг тараах материал өгч танилцуулна. Ажиглагчид эдгээр багуудын талаарх мэдээллийг авах бөгөөд өөрийн сум, орон нутгийн нөхцөл байдалд тохируулан дүн шинжилгээ хийнэ.

<b>Улаан</b>	<b>Цэнхэр</b>
<ul style="list-style-type: none"> <li>○ Нэг гишүүн нь эрүүл мэндийн ажилтан, ажил үүргийн чиглэлийн дагуу гамшгийн менежментийн сургалтад хамрагдсан.</li> <li>○ Өөр нэг гишүүн нь газарзүйн багш, орон нутгийн гамшгийн талаар хичээл заахаар сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн.</li> <li>○ Багийн 3 гишүүн гурван жил тутамд үер болоход тариалсан хүнсний ногоо, ургацаа алдсан. Үер болсон жилд амьжиргаа муудан ажил хийж орлого олох зорилгоор өөр газар луу явах хэрэгтэй болдог.</li> <li>○ Багийн өөр 3 гишүүн сүүлийн дараалсан их үерт орон гэр, өмч хөрөнгөө алдсан. Өөрсдийн өрхийн үйлдвэрлэлд ашигладаг байсан жижиг тоног төхөөрөмж, түүхий эд зэргээ мөн алдсан.</li> <li>○ Ихэнх “улаан”-ууд сэлж чадахгүй, нэг гишүүн нь их усанд нэг хүүхдээ аварч чадалгүй алдсан эмэгтэй.</li> <li>○ Өнгөрсөн жилд хүчтэй шуурга болсны улмаас “Улаан” багийн гишүүд нэг долоо хоногийн хугацаанд сумын төвд байрласан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>○ Цэнхэр багийн нэг гишүүн нь сумын ахмад настан бөгөөд сумын төрийн албаны хүмүүстэй маш сайн харилцаатай.</li> <li>○ Нэг гишүүн нь голын далан, үерийн хамгаалалтын хана барих барилгын төсөлт ажилд орон нутгийг төлөөлөн гэрээ байгуулж ажилладаг.</li> <li>○ Багийн 3 гишүүн нь гурван жил тутамд босон үерт тарьсан хүнсний ногоо, ургацаа алдаж тодорхой нөхөн төлбөр авсан. Алдсан хохирлоо бүрэн нөхөөгүй тул өөр газар руу явж гэр бүлээрээ ажил хийх хэрэгтэй болсон.</li> <li>○ Өөр 3 гишүүн нь мөн өөрийн газарт ногоо тарьсан, гэхдээ үерт өртөөгүй. Тэдэнд гол тулгамддаг асуудал нь төв суурин газар луу хүнсний ногоогоо зарах үед зам, гүүр усанд автаж боогдох хүндрэл тулгардаг.</li> <li>○ Багийн 3 гишүүн гамшгийн үеэр гэр, эд хөрөнгөө алдсан.</li> <li>○ Багийн гишүүдийн 2 нь л сэлж чаддаггүй.</li> </ul>
<p>Сум “Улаан”, “Цэнхэр” хоёр багтай. Улаан баг нийгмийн байр суурь багатай, Цэнхэр баг илүү дээгүүр байр суурьтай. Цэнхэр багийн гишүүд бүгд өөрийн газартай, Улаан багийн гишүүд Цэнхэр багийн газар дээр ажилладаг. Цэнхэр багийн гишүүд сумын бүх уулзалтад манлайлж оролцдог, Улаан багийн гишүүд уулзалтад оролцож үг хэлэх боломж хомс. Цэнхэр багийнхан нийгмийн болон санхүүгийн хувьд илүү давуу эрхтэй байгаад Улаан багийнхан таашаадаггүй.</p>	

**Алхам 3.** Багуудад 10 минут өгч дүрүүд хуваарилахад туслах бөгөөд дүр бүр өөрийн үүргийг ойлгоно. Дараагийн 15 минутад багууд уулзалт зохион байгуулж, СГХХороонд хэн, хэнийг сонгохоо шийдэн, СГХХорооны хариуцан ажиллах гурван асуудлыг хэлэлцэнэ.

**Алхам 4.** Оролцогчдыг эргэж сургалтанд урьж дараах асуултыг асуухыг зөвлөж байна.

- Улаан баг болон Цэнхэр баг болоход юу мэдэрсэн бэ?
- Шийдвэрээ хэрхэн гаргасан?
- Гол гурван асуудлаа хэрхэн шийдвэрлэсэн?
- Шийдвэр гаргах явцад хэн хожиж, хэн хохирсон бэ?
- Дэд бүтцийн бүтээн байгуулалт аль аль багт адилхан үр нөлөөтэй байх уу, эсвэл хоёр багийн хүртэх үр өгөөжийг улам зөрүүтэй болгох уу?

Ажиглагчаар ажилласан оролцогчдоос сүүлийн гурван асуултыг мөн асууж, ямар дүгнэлт өгсөн талаар тодруулна.

*Дасгалын дүгнэлт:*

Аливаа бүлэг шийдвэр гаргах бүх үйл явцын гадна орхигдсон үед тохиолдож болох нөхцөл байдлын тулаар санал бодлоо солилцож, "шийдвэр гаргах бүх үйл явцад эрэгтэй, эмэгтэй хүмүүс, түүнчлэн бусад эмзэг бүлгийн хүмүүсийг оролцуулах хэрэгтэй" гэдгийг дүгнэж дуусгана. Энэ нь зөвхөн сумын түвшинд төдийгүй бүх түвшинд, тэр дундаа аймгийн болон үндэсний түвшинд шаардлагатай байна."

**Дасгал 2.** “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жендэрийн мэдрэмжтэй бодлого” Бие биедээ туслах арга ашиглан тодорхой сорилтуудыг шийдвэрлэх нь.

- Оролцогчдыг хэд хэдэн багт хуваана.
- Сургагч дасгалын өмнө “Жендэрийн мэдрэмжтэй дасан зохицохуйн хэмжүүр” хүснэгтийг оролцогч нарт тарааж, дасгал ажиллахад нь мэдээллээр хангаж туслана.
- Зөвлөмжийг харгалзан баг бүр өөрсдийн орон нутагт тулгамдаж байгаа нэг салбарын жишээн дээр (тухайлбал, отор нүүдэл хийх, бэлчээр өнжөөх, малчдын бүлэг жуулчдад үйлчлэх гэх мэт) тулгарч байгаа асуудлыг тодруулан, үүнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгжилтийг хангах санал гаргаж ажиллана.
- Оролцогчид дасгалын эхний хэсэгт сонгосон жишээн дээрээ тулгамдаж байгаа асуудлыг жагсаана.

- Тухайн тулгамдсан асуудал бүрийн эмэгтэйчүүдэд учирч болзошгүй нөлөө, одоо байгаа болон байж болох шийдэл тодорхойлно.
- Багууд ханын цаасанд асуудал, шийдлийг тодорхойлж хэлэлцсний дараа сургагч нэгдсэн дүгнэлт хийнэ.

**Дасгалын дүгнэлт:**

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч явуулж буй аливаа (үндэсний болон аймаг, орон нутгийн хэмжээний) арга хэмжээ нь жендэрт хэрхэн нөлөөлөх талаар урьдчилан төлөвлөж, ялангуяа эмэгтэйчүүдэд бий болох нэмэлт ачаалал, хөдөлмөр зарцуулалт нь тэдний эмзэг байдлыг нэмэгдүүлэх нөхцөл болохгүй байх талаас нь дасан зохицох төлөвлөгөөг боловсруулахад анхаарах нь чухал.

**Жендэрийн мэдрэмжтэй дасан зохицохуйн хэмжүүр**

Хэмжүүр	Болзошгүй сөрөг нөлөө	Санал
<b>Дэд бүтэц</b>		
Гол нуурын эрэг дагуу далан, хаалт барих	Эрэгтэй хүмүүс ажлын байраар хангагдах боломжтой ч эмэгтэйчүүдэд боломж хумигдмал.	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг сургаж, ажилд авах, дэмжлэг үзүүлэх. Гэр бүлийн амьдралын нөхцөлийг сайжруулахын тулд цалинтай үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулах боломжийг хангах. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд жендэрийн шалгуур тусгах.
Үерт өртөж болзошгүй газруудад гүүр барих	Эрэгтэй хүмүүст ажлын байр бий болно. Эмэгтэйчүүд хийхийг хүссэн ч тохирох ажлын байр байхгүй гэх асуудал тулгарна. Гүүрийг зөвхөн автомашин явах зориулалтаар барьвал хол зам туулж ажилдаа хүрдэг эмэгтэйчүүдэд хүндрэл тулгарч болзошгүй.	Орон зайн хөдөлгөөний хэрэгцээг анхаарч харгалзах. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг сургаж, ажилд авахад дэмжлэг үзүүлэх. Газар ашиглалтыг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлэх. Байгаль орчны үнэлгээнд жендэрийн шалгуур тусгах.

**ЖЕНДЭР БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ**

Хэмжүүр	Болзошгүй сөрөг нөлөө	Санал
<b>Экосистем</b>		
Өндөр температурт тэсвэртэй ургамал, тарианы сортуудыг нэвтрүүлэх үр	Эмэгтэйчүүдийн өдөр тутмын ахуйн хэрэгцээ, ажил үүрэг нь ус болон бусад эх үүсвэрээс хамааралтай байдаг. Эмэгтэйчүүдийн өдөр тутмын ажлын хугацааг уртасгаж болзошгүй.	Шинэ сортуудыг нэвтрүүлэхэд үзүүлэх нөлөөнд дүн шинжилгээ хийж, өдөр тутмын ажлыг илүү тэгш хуваарилахад дэмжлэг үзүүлэх. Нөөцөд тэгш хүртээмжтэй хандах, хяналт тавих, түүнчлэн тэдгээрийн үр өгөөжийг (үйлдвэрлэлийн нөөц, ажлын байр, сургалт, зээл гэх мэт) хуваарилахад дэмжлэг үзүүлэх. Төрөл зүйлийг удирдах талаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хооронд мэдлэг, туршлага солилцохыг дэмжих.
Гэмтсэн экосистемийг сэргээх	Нөхөн сэргээлт, байгаль хамгаалах үйл ажиллагаанд сайн дурын (цалингүй) хөдөлмөрийг урамшуулах замаар хүйсийн тэгш бус байдлыг улам дордуулж болзошгүй.	Гэр бүлийн ажлыг хамтран хариуцах, тэгш хуваарилалтыг дэмжих, эмэгтэйчүүд бусад үйл ажиллагаанд чөлөөт цаг гаргах. Байгаль орчныг нөхөн сэргээх ажилд эмэгтэйчүүд цалинжиж оролцохыг дэмжих. Эко системийг нөхөн сэргээхтэй холбоотой уламжлалт бус үйл ажиллагаанд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг тэгш суралцах. Зохион байгуулалт, шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн манлайлал, үр дүнтэй оролцоонд дэмжлэг үзүүлэх.
Байгалийн тусгай хамгаалалттай	Өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэй бүхий айл болон ядуу өрхийн амин	Байгалийн тусгай хамгаалалттай газар нутаг, коридорт ургамал, амьтны

ЖЕНДЭР БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

<p>газар нутаг, биологийн коридор байгуулах</p>	<p>зуулгын эх үүсвэр болсон үйл ажиллагааг хориглож болзошгүй.</p>	<p>төрөл, зүйлийн талаарх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн мэдлэгийг ашиглах. Нөөцийн ашиглалт, хүртээмж, удирдлага, хяналттай холбоотой жендэрийн харилцаанд дүн шинжилгээ хийх.</p>
<p>Ойг нөхөн сэргээх, ойжуулах, ой мод ашиглалтыг багасгах, түүнчлэн бэлчээр, хөрсний доройтлын стратеги хэрэгжүүлэх</p>	<p>Орон нутгийн хүмүүсийн голлон ашигладаг нөөцийн ашиглалтыг хязгаарлах тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ашиг сонирхол, хэрэгцээнд хохирол учруулж болзошгүй. Байгалийн нөөцтэй холбоотой шийдвэр гаргахдаа эмэгтэйчүүдийн мэдлэг, чадварыг харгалзахгүйгээс болж үнэгүйдэх. Эмэгтэй хүн хийхийг хүссэн, хийж чадах ажил дээрээ ажиллах боломж байхгүй, харин эрэгтэй ажиллах хүчийг ажилд авахыг илүү дэмжсэн ажлын байрын бий болгох.</p>	<p>Байгаль орчны нөөцийн ашиглалт, хүртээмж, менежмент, хяналттай холбоотой жендэрийн харилцаанд дүн шинжилгээ хийх. Байгалийн нөөц ашиглалтын зөрчлийг бууруулах стратегид эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах</p>

Хэмжүүр	Болзошгүй сөрөг нөлөө	Санал
<b>Ахуйн үйл ажиллагаа</b>		
Мал аж ахуйг эрчимжүүлэх	Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог харгалзан үзэхгүй, шинэ үйл явцад оролцуулахгүй байж болзошгүй. Энэ нь нөөц ашиглах, түүнд хандах, удирдах, хянах зэрэгт дахин саад учруулж болзошгүй юм.	Эмэгтэйчүүдийн шинэ чадавхыг бий болгож, уламжлалт бус ажлын эх үүсвэрийг бий болгох. Тухайлбал малчин эмэгтэйчүүд аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцох, бүлэг баг болж үйлчилгээний чадварт суралцах гэх мэт.
Газар тариалангийн усалгааг өөрчлөх; хугацаа, төрөл, хэрэглээ гэх мэт.	Өрхийн хэрэглээний усны эх үүсвэрийг зайлуулж эсвэл хол байрлуулж болзошгүй. Өрхийн өдөр тутмын ажлын хугацаа, ачааллыг уртасгаж болзошгүй.	Эмэгтэйчүүдийг өрхийн хэрэглээндээ, газар тариалан, мал аж ахуй зэрэг ашиглалтын олон зориулалт бүхий усны идэвхтэй хэрэглэгч гэж үзэх. Усалгаатай газар тариалангийн хэрэгцээг хангахын тулд эмэгтэйчүүд ус хэрхэн ашиглаж байгааг шинжлэх. Эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн технологийг сурталчлах, тэдэнд зохих сургалт явуулах. Усалгаанд ойр газар өмчлөх эрх тэгш байдлыг дэмжих.



**ЖЕНДЭР БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ**

Хэмжүүр	Болзошгүй сөрөг нөлөө	Санал
<b>Нийгэм-эдийн засгийн үйл явц</b>		
<p>Уур амьсгалын өөрчлөлтөд нэрвэгдсэн бүс нутаг дахь шилжих хөдөлгөөн, иргэдийн тогтворгүй байдал.</p>	<p>Ажлын байр, боловсрол, эрүүл мэнд, орон сууц, зээлийн хүртээмжийн нийгэм-эдийн засаг, хүйсийн тэгш бус байдал. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийг гадуурхах. Нийгэмд эмэгтэйчүүдээр толгойлуулсан өрхийн тоо нэмэгдэх. Уламжлал ёсоор "эрэгтэй" ажил эрхэлдэг гэж үзэх. Эмэгтэйчүүд хөдөлмөрийн мөлжлөгт өртдөг, тогтмол бус эсвэл улирлын чанартай ажилд бага цалин авдаг эмэгтэйчүүд олон байна. Шилжин суурьших мөчлөгийн үеэр дарамт шахалт, бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол нэмэгдсэн.</p>	<p>Эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийг дэмжих. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг ур чадвартай, цалинтай ажилд орохыг дэмжих. Нийгмийн хамгааллын системд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг оролцоог тэгш хангах. Цагаач /отроор нүүдэллэж байгаа/ эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд болон тэдний гэр бүлд анхаарал хандуулах. Шилжин суурьшилын улмаас нутагтаа үлдсэн иргэд, гэр бүл, хувь хүмүүст туслах нийгмийн үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих.</p>

**Оролцогчдоос авах сонжоо**

(Тийм – 2 оноо, Заримдаа – 1 оноо, Үгүй – 0 оноо)

1. Өөрийн ус, ундны сав хэрэглэдэг үү?
2. Хаягдлаа тушааж мөнгө олдог уу?
3. Хэрэглээгүй үедээ гэрлээ унтрааж, усаа хаадаг уу?
4. Хаягдлаараа бүтээл урладаг уу?
5. Жил жилийн трэнд моод дагадаг уу?
6. Даавуун тор өдөр тутамдаа ашигладаг уу?
7. Хог хаягдалаа ангилж хаядаг уу?
8. Аяга, тавгандаа хоол үлдээдэггүй юу?
9. Өдөр бүр 5 км явган явдаг уу?
10. Та өдөр бүр селфи хийдэг үү?

**Зөвлөмж:** Модуль 2-ын сургалт эхлэх үед оролцогчдоос сонжоо авч, сургалтын төгсгөлд оноогоо дүгнэнэ. Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд хувь бүр жижиг үйлдлээрээ хувь нэмэр оруулж болохыг энэхүү сонжоогоор тайлбарлаж болно.





